



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр, Пүрэв гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-22</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>23-98</i>
<hr/>	
<i>1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>26-92</i>
<hr/>	
<i>2. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>92-93</i>
<hr/>	
<i>3. “Хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаарх” Улсын Их Хурлын хяналтын сонсголын тайланг сонссон талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт</i>	<i>93-98</i>
<hr/>	

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр /Пүрэв гараг/-ийн  
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 51.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 10 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

*Томилоттой: Ж.Батжаргал, Д.Батлут, Г.Ганболд, Ц.Идэрбат, С.Одонтуяа, Ц.Туваан, Ч.Ундрэм, Б.Энх-Амгалан;*

*Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ;*

*Эмнэлгийн чөлөөтэй: Б.Саранчимэг;*

*Тасалсан: Ц.Анандбазар, Х.Болорчулуун, Б.Дэлгэрсайхан, Б.Чойжилсүрэн;*

*Хоцорсон: С.Амарсайхан-1 цаг 03 минут, С.Батболд-1 цаг 40 минут, Э.Батшугар-15 минут, Ж.Бат-Эрдэнэ-4 цаг 09 минут, Б.Баярсайхан-18 минут, С.Ганбаатар-10 минут, Д.Ганбат-19 минут, Ц.Даваасүрэн-07 минут, Г.Дамдинням-06 минут, Т.Доржханд-13 минут, Г.Мөнхцэцэг-05 минут, Ж.Сүхбаатар-35 минут, Ц.Сэргэлэн 07 минут, Н.Учрал-06 минут, Л.Энх-Амгалан-07 минут, Т.Энхтүвшин-17 минут.*

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Х.Ганхуяг нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Х.Ганхуяг нар үг хэлэв.

***Нэг.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд дарга бөгөөд Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж, мөн газрын Хууль, эрх зүйн газрын даргын Ч.Дондогмаа, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Эдийн засаг, хөгжлийн яамны Инновацын бодлогын газрын дарга Т.Золзаяа, мөн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга О.Мөнхтөр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Ганхүү, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, Төрийн худалдан авах ажиллагааны дарга Ц.Батзул, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Энхманлай, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, Б.Баярсайхан, Ш.Адьяа, О.Цогтгэрэл, С.Ганбаатар, Ж.Батсуурь, Ж.Чинбүрэн, Б.Жаргалмаа, Н.Наранбаатар, Н.Ганибал, Т.Энхтүвшин, Ш.Раднаасэд, Д.Ганбат, Х.Ганхуяг, Б.Баттөмөр, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Д.Тогтохсүрэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд дарга бөгөөд Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Энхманлай, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, Төрийн худалдан авах ажиллагааны дарга Ц.Батзул нар хариулж, тайлбар хийв.

*Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 52 минут үргэлжилж, 13 цаг 02 минутад завсарлав.*

*Үдээс хойших хуралдаан 14 цаг 11 минутад эхлэв.*

*Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Нэг.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Төсвийн байнгын хороо дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ш.Адьяа, П.Анужин, Т.Аубакир, Э.Бат-Амгалан, Ж.Батсуурь, Б.Баярсайхан, Г.Дамдинням, М.Оюунчимэг, Б.Пүрэвдорж, Ц.Сэргэлэн, Ц.Туваан, Г.Тэмүүлэн, Д.Цогтбаатар, Ц.Цэрэнпунцаг, Н.Энхболд, Ж.Эрдэнэбат /цаашид “ажлын хэсэг”гэх/ нарын гаргасан Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

**“1/59 дүгээр зүйлийн 59.3.5 дахь заалт:**

**“59.3.5.өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын тавьсан асуултад Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 31

Татгалзсан: 16

Бүгд: 47

66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг 2 дахь заалт болгон өөрчилж, тус заалтын 59.8, 59.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“59.8.Энэ хуулийн 59.1.2-т заасан эх үүсвэрээс энэ хуулийн 59.3.5-д заасан итгэлцүүрээр хуваарилагдах хөрөнгийг сумын орон нутгийн хөгжлийн санд шууд хуваарилна.

59.9.Энэ хуулийн 59.7, 59.8-д заасны дагуу орлогын шилжүүлгийг тодорхойлсны дараа орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн үлдсэн хэсгийг энэ хуулийн 59.3.1, 59.3.2, 59.3.3-т заасан итгэлцүүрээр тодорхойлно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32

Татгалзсан: 15

Бүгд: 47

68.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг 3 дахь заалт болгон өөрчилж, тус зүйлийн 60.2.10 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“60.2.10.энэ хуулийн 59.8-д заасан хуваарилалт.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31

Татгалзсан: 16

Бүгд: 47

66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 18

Бүгд: 47

61.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг 2 дугаар зүйл болгон өөрчилж, тус зүйлийн 1 дэх заалтын 59.2.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“59.2.2.энэ хуулийн 59.8-д зааснаас бусад хэсгийн 60 хувийг дараах итгэлцүүрийг харгалзан хуваарилна:

59.2.2.1.хүн амын тоо;

59.2.2.2.нутаг дэвсгэрийн хэмжээ;

59.2.2.3.ашигт малтмал болон газрын тосны ашиглалтын талбайн хэмжээ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 19

Бүгд: 47

59.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг 3 дугаар зүйл болгон өөрчилж, тус зүйлийн 7.9 дэх хэсгийн “төсвийн” гэснийг хасаж, “гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын” гэснийг “эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 17

Бүгд: 47

63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн “3.1.2, 4.1.3-4.1.10-т заасан нийтээр тэмдэглэх баярын болон” гэснийг “3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 19

Бүгд: 47

59.6 хувийн саналаар дэмжигдлээ.

**Хоёр.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Төсвийн байнгын хороо дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 23.9, 23.10 дахь хэсэг, Тайлбарыг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулж Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 20

Бүгд: 48

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 60.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 57.18 дахь хэсгийг бүхэлд нь хасах гэсэн Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28  
Татгалзсан: 20  
Бүгд: 48  
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

**“3 дугаар зүйл.Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.5.4 дэх заалтын “тагнуул,” гэснийг хассугай.”** гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28  
Татгалзсан: 20  
Бүгд: 48  
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн гаргасан, Төслийн гарчгийн “НЭМЭЛТ” гэсний дараа “ӨӨРЧЛӨЛТ” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 19  
Бүгд: 48  
60.4 хувийн саналаар дэмжигдлээ.

*Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 14 цаг 42 минутаас хуралдааныг даргалав.*

**Гурав.Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Төсвийн байнгын хороо дэмжсэн санал:**

**Л.Мөнхбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “2025 онд 40, 2026 оноос 65” гэснийг “2025 оноос 65” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.  
Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 24  
Бүгд: 47

49.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 21  
Бүгд: 48  
56.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Л.Мөнхбаатар:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 31  
Татгалзсан: 17  
Бүгд: 48  
64.6 хувийн саналаар дэмжигдлээ.

**Дөрөв.Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Төсвийн байнгын хороо дэмжсэн санал:**

**Л.Мөнхбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “дуудлага худалдааны” гэж” гэсний дараа “,139 дүгээр зүйлийн 139.1.17 дахь заалтын “сонгон шалгаруулалтад” гэснийг “дуудлага худалдаанд” гэж” гэж, “зураасан” гэсний дараа “болон түүнтэй адилтгах” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30  
Татгалзсан: 18  
Бүгд: 48  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

**Тав.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Төсвийн байнгын хороо дэмжсэн санал:**

**Л.Мөнхбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2, 3 дугаар зүйлийг нэгтгэж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:



**“2 дугаар зүйл.**Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийн “Тайлангаар баталгаажсан өмнөх жилийн албан татвар ногдох орлогын хэмжээ 50.0 сая төгрөгөөс хэтрээгүй нөхцөлд тухайн хувь хүн” гэснийг “Хувь хүн” гэж, 15.7 дахь хэсгийн “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангаж нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлсэн, энэ хуулийн дагуу хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх эрхтэй албан татвар” гэснийг “Энэ хуулийн дагуу хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх албан татвар” гэж,” 21 дүгээр зүйлийн 21.2.5 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1.6 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “20.1-д” гэснийг “20.1, 20.4-т” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 33  
Татгалзсан: 15  
Бүгд: 48  
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг 3 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“3 дугаар зүйл.**Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, 2 дугаар зүйлийн 21.2.5, 25.1.6 дахь заалт, 27.1 дэх хэсгийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн, 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 23 дугаар зүйлийн 23.16 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 15.6, 15.7 дахь хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2030 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл, 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 23 дугаар зүйлийн 23.17 дахь хэсгийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2030 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл тус тус дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 33  
Татгалзсан: 15  
Бүгд: 48  
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

### **Найруулгын санал:**

**Л.Мөнхбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 20.4, 20.5 дахь хэсэг, мөн зүйлийн 2 дахь заалтын 23.17 дахь хэсгийн “нийслэл,” гэснийг “нийслэлийн болон” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28  
Татгалзсан: 21  
Бүгд: 48

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

**Зургаа.Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Төсвийн байнгын хороо дэмжсэн санал:**

**Л.Мөнхбаатар:** Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 22

Бүгд: 49

55.1 хувийн саналаар дэмжигдлээ.

**Долоо.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Төсвийн байнгын хороо дэмжсэн санал:**

**Л.Мөнхбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 22 дугаар зүйлийн 22.5.15, 22.5.16 дахь заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2030 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл, 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 22 дугаар зүйлийн 22.5.17 дахь заалтыг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2030 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл, 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 18 дугаар зүйлийн 18.13, 18.14 дэх хэсэг, мөн зүйлийн 3 дахь заалт буюу 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэг, 2 дугаар зүйлийн 20.2.4 заалт, 24.5 дахь хэсгийн дугаарын өөрчлөлтийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн, мөн зүйлийн 26.15 дахь хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35

Татгалзсан: 14

Бүгд: 49

71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

**Найруулгын санал:**

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 18.13, 18.14 дэх хэсэг, 3 дахь заалтын 24.5 дахь хэсгийн “нийслэл,” гэснийг “нийслэлийн болон” гэж, мөн зүйлийн 2 дахь заалтын 22.5.15 дахь заалтын “цэс” гэснийг “цэсийн” гэж

өөрчилж, 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 22.5.15, 22.5.16, 22.5.17 дахь заалтуудын “тус тус хөнгөлнө.” гэснийг хасах. гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35

Татгалзсан: 15

Бүгд: 50

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**Найм.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Төсвийн байнгын хороо дэмжсэн санал:**

**Л.Мөнхбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “татварын хуульд зааснаас бусад” гэснийг “Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25.8-д, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 24.5-д зааснаас бусад” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35

Татгалзсан: 15

Бүгд: 50

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**Ес.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Төсвийн байнгын хороо дэмжсэн санал:**

**Л.Мөнхбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, тус зүйлд доор дурдсан агуулгатай 10.4 дэх хэсэг нэмэх:

“10.3.Стратегийн орд эзэмшигч төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотой Монгол Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу нүүрсийг харилцан ашигтай, тогтвортой, урт хугацаанд худалдах гэрээг байгуулахад энэ хуулийн 10.2 дахь хэсэг хамаарахгүй.

10.4.Энэ хуулийн 10.3-т заасан гэрээг байгуулахдаа тухайн бүтээгдэхүүний биржийн арилжааны дундаж үнийг баримтална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 23

Бүгд: 49

53.1 хувийн саналаар дэмжигдлээ.

**Арав.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Төсвийн байнгын хороо дэмжсэн санал:**

**Л.Мөнхбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8.15 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.15.Стратегийн орд эзэмшигч төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотой Монгол Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу уурхайн үйл ажиллагааны тасралтгүй, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор хайгуул-олборлолтын ажлыг хамтад нь гүйцэтгэх этгээдтэй арав хүртэл жилийн хугацаатай гэрээ байгуулахаар тендер зарлаж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 20  
Бүгд: 49  
59.2 хувийн саналаар дэмжигдлээ.

**Арван нэг.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Төсвийн байнгын хороо дэмжсэн санал:**

**Л.Мөнхбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 18.1.10 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 30  
Татгалзсан: 19  
Бүгд: 49  
61.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 23.2.3 дахь хэсгийн “сумын газар зохион байгуулалтын” гэснийг “энэ хуулийн 25.1.4-т заасан” гэж өөрчилж, мөн зүйлийн 23.2.4 дэх заалтын “эрхлэх,” гэсний дараа “тухайн жилд” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33  
Татгалзсан: 17  
Бүгд: 49  
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 23.2.10 дахь заалтын “байгууллага, мэргэжлийн байгууллагад” гэснийг “байгууллагад мэргэжлийн байгууллагын” гэж өөрчлөн, “, дүгнэлт өгөх” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 33  
Татгалзсан: 17  
Бүгд: 49  
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 23.2.15 дахь заалтын “Засгийн газарт” гэснийг “холбогдох хуульд заасан эрх бүхий этгээдэд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 35  
Татгалзсан: 15  
Бүгд: 50  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 23.2.16 дахь заалт нэмэх:

“23.2.16.улсын тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалтыг эрхлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 34  
Татгалзсан: 15  
Бүгд: 49  
69.4 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 33  
Татгалзсан: 16  
Бүгд: 49  
67.3 хувийн саналаар дэмжигдлээ.

**Төсвийн байнгын хороо дэмжээгүй санал:**

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 23 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 23.2.23 дахь заалт нэмэх:

“23.2.23.төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил ашиглалтад байгаа газар дээр хууль бусаар баригдсан барилга объектыг төрийн өмчид хураан авах ажлыг зохион байгуулах.” гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Д.Тогтохсүрэн, Б.Жаргалмаа, Б.Бейсен нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 33  
Бүгд: 46  
53.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

**Арван хоёр.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Төсвийн байнгын хороо дэмжсэн санал:**

**Л.Мөнхбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн гарчгийн “ӨӨРЧЛӨЛТ” гэсний өмнө “НЭМЭЛТ,” гэж нэмж, төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.2.8, 10.2.9 дэх заалт нэмсүгэй:

“10.2.8.бүх ангиллын кадастрын зураглалын стандарт, технологийн аргачлал, дүрэм, журмыг батлуулан мөрдүүлэх;

10.2.9.газрын кадастр хийх нутаг дэвсгэрийн ээлж дарааллыг тогтоох, газрын кадастрын судалгааг гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд нь хяналт тавих;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Д.Тогтохсүрэн нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 18  
Бүгд: 47  
61.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2, 3 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.8 дахь заалтын дугаарыг “10.2.10” гэж өөрчилсүгэй.”

**3 дугаар зүйл.**Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 9<sup>1</sup> дүгээр зүйлийг хүчингүй болгосугай. ” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35  
Татгалзсан: 13  
Бүгд: 48  
72.9 хувийн саналаар дэмжигдлээ.

#### **Найруулгын санал:**

**Л.Мөнхбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн дугаарыг 4 дүгээр зүйл болгон өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33  
Татгалзсан: 15  
Бүгд: 48  
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

**Арван гурав. Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

#### **Төсвийн байнгын хороо дэмжсэн санал:**

#### **Найруулгын санал:**

**Л.Мөнхбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай” гэснийг “болон татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагууд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 36  
Татгалзсан: 12  
Бүгд: 48  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**Арван дөрөв.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөл оруулах тухай хуулийн төслийн талаар:**

#### **Төсвийн байнгын хороо дэмжсэн санал:**

**Л.Мөнхбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “бүхий QR код (лавлагаа авах холбоос)” гэснийг, тус зүйлийн “,мөн зүйлийн 5 дахь хэсгийн “энгийн” гэсний дараа “болон тусгай” гэж, 5.5 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “хугацаа” гэсний дараа “ажлын” гэж тус тус” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Н.Учрал нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 30  
Татгалзсан: 18  
Бүгд: 48  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “бичиг” гэсний өмнө “олгоно.” гэсний өмнөх” гэж, мөн зүйлийн “өөрчилсүгэй.” гэсний өмнө “, 5.5 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “хугацаа 10 хоног” гэснийг “хугацаа ажлын 10 өдөр” гэж тус тус” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 21  
Бүгд: 48  
56.2 хувийн саналаар дэмжигдлээ.

**Арван тав.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Төсвийн байнгын хороо дэмжсэн санал:**

**Л.Мөнхбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн гарчгийн “,ӨӨРЧЛӨЛТ” гэснийг болон 2 дугаар зүйлийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28  
Татгалзсан: 20  
Бүгд: 48  
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг 2 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

**Арван зургаа.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:**

**Төсвийн байнгын хороо дэмжсэн санал:**

**Л.Мөнхбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн гарчгийг “Тогтоолд нэмэлт оруулах тухай” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.



Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 21

Бүгд: 48

56.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

“1.“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын 4 дэх заалтын “26,” гэсний дараа “27,” гэж нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 20

Бүгд: 48

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтыг 2 дахь заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Энэ тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 19

Бүгд: 48

60.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмэх:

“3.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 20

Бүгд: 48

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

**Арван долоо.“Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:**

**Төсвийн байнгын хороо дэмжсэн санал:**

**Л.Мөнхбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын “төсвийн тухай хууль” гэснийг “төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30  
Татгалзсан: 18  
Бүгд: 48  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

**Арван найм. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:**

**Төсвийн байнгын хороо дэмжсэн санал:**

**Л.Мөнхбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн тэмдэглэх хэсэгт “Монгол Улсын Засгийн газрын” гэсний өмнө “Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 20  
Бүгд: 49  
59.2 хувийн саналаар дэмжигдлээ.

**Арван ес. “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:**

**Төсвийн байнгын хороо дэмжсэн санал:**

**Л.Мөнхбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын “Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлж, төвлөрлийг сааруулах зорилгоор 2024 оныг “Хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжих” жил болгон зарласугай.” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31  
Татгалзсан: 19  
Бүгд: 50  
62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дахь заалтыг 1 дэх заалт болгон өөрчилж, тус заалтын 11 дэх дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11/ Газрын багц хуулийн төсөл, түүнд нийцүүлэн Ашигт малтмалын тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон холбогдох бусад хуулийн төслийг боловсруулан 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31  
Татгалзсан: 19  
Бүгд: 50  
62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 12 дахь дэд заалт нэмэх:

“12/төсвийн ил тод, хариуцлагатай байх зарчимд нийцүүлж төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрөөр төлөвлөн, хөтөлбөр, арга хэмжээний үр дүн болон үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлж түүнтэй уялдсан төсвийн зардлыг тооцож боловсруулж байх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 21  
Бүгд: 50  
58.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дахь заалтын 5 дахь дэд заалтын “нийтлэг” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 21  
Бүгд: 50  
58.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дахь заалтыг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28  
Татгалзсан: 22  
Бүгд: 50  
56.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан, Төслийн 4 дэх заалтыг 2 дахь заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/-д тус тус даалгасугай:

1/орон сууцны ипотекийн зээлийн эрэлт болон төвлөрлийг сааруулах бодлоготой уялдуулан ипотекийн хөтөлбөрийн эх үүсвэрийг нийслэл, орон нутагт үе шаттайгаар нэмэгдүүлэх;

2/ипотекийн зээлийн 60 хувийг хөдөө орон нутгийн иргэдийг орон сууцжуулах хөтөлбөрт хуваарилах;

3/агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах зорилгоор инженерийн дэд бүтцийн шийдэлтэй, нийт талбай нь 100 м2-аас ихгүй хэмжээтэй амины орон сууцыг орон сууцны ипотекийн зээлд хамруулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Б.Пүрэвдорж, С.Бямбацогт, М.Оюунчимэг, С.Чинзориг, Д.Тогтохсүрэн нар үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмэх:

“3.Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн дагаж мөрдөх хугацааг сунгах тухай хуулийн төслүүдийг 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/ -т даалгасугай.” гэсэн Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 17

Бүгд: 44

61.4 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 5 дахь заалт нэмэх:

“5.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 20

Бүгд: 44

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

**Хорь.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:**

**Төсвийн байнгын хороо дэмжсэн санал:**

**Л.Мөнхбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй нэгтгэж нэг төсөл болгон, төслийн 1 дэх заалтыг “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь заалтын 13 дахь дэд заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13/хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан болон тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, ачаа тээврийн урсгалыг сайжруулах, төмөр зам, нисэх буудал, авто зам, замын байгууламжийн сүлжээг өргөтгөн шинэчлэх, боомтын хүчин чадлыг сайжруулах, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийг нэмэгдүүлэх, Нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, төвлөрлийг сааруулах, шинэ суурьшлын бүс, хот байгуулах дэд бүтэц бий болгох болон төрийн үйлчилгээний салбарын төсөл хөтөлбөрийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хүрээнд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх асуудлыг судлан шийдвэрлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ц.Сэргэлэн нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 19  
Бүгд: 45  
58.0 хувийн саналаар дэмжигдлээ.

#### **Найруулгын санал:**

**Л.Мөнхбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллууд дэмжигдсэнтэй холбогдуулан эдгээр хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн зүйл, хэсэг, заалтын дугаарыг өөрчлөх, агуулга зарчмыг хөндөхгүйгээр үг хэллэг, найруулгын шинжтэй засвар хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 21  
Бүгд: 45  
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дуусав.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 16 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.*

*Хоёр.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх А.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг дахин явуулах шаардлагатай байгаа тул хуулийн төслийг дахин анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд буцаах горимын санал гаргав.

**Л.Мөнхбаатар:** Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	27
Татгалзсан:	18
Бүгд:	45

60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг дахин анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд буцаав. /16:27/

*Гурав. “Хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаарх” Улсын Их Хурлын хяналтын сонсголын тайланг сонссон талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх А.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

“Хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаарх” Улсын Их Хурлын Хяналтын сонсголын тайланг сонссон талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан, М.Оюунчимэг, Г.Дамдинням нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд “Хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаарх” Улсын Их Хурлын Хяналтын сонсголын тайланг сонссон талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг сонслоо.

*Уг асуудлыг 16 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.*

**Бусад.** Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатарын урилгаар Увс аймгийн Улаангом сумын Багийн Засаг дарга нар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Х.Ганхуяг, С.Одонтуяа нарын урилгаар Баянгол дүүргийн 14, 15 дугаар хорооны иргэд, Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэгийн ахмад ажилчид, зөвлөлийн дарга нар, “Орчлон” сургуулийн 10д ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар, Н.Учрал, П.Анужин нарын урилгаар Сонгинохайрхан дүүргийн ерөнхий боловсролын 67 дугаар сургуулийн ахлах ангийн багш, сурагчид, “Хөгжил ирээдүй” цогцолбор сургуулийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын урилгаар Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийн 11 дүгээр ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Ц.Сандаг-Очир нарын урилгаар Багануур дүүргийн 3 дугаар хорооны иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Д.Сарангэрэл, Т.Доржханд нарын урилгаар Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн оюутнуудын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн урилгаар Чингэлтэй дүүргийн 174, 27 дугаар цэцэрлэгийн багш, ажилчид, Нийслэлийн ерөнхий боловсролын 106 дугаар сургуулийн 6г ангийн багш, сурагчид, Нийслэлийн ерөнхий боловсролын 133 дугаар сургуулийн 6в ангийн багш, сурагчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан цаг 5 цаг 27 минут үргэлжилж, 72 гишүүнээс 57 гишүүн хүрэлцэн ирж, 79.2 хувийн ирцтэйгээр 16 цаг 46 минутад өндөрлөв.

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН**

2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр,  
Пүрэв гараг

Төрийн ордон “Их хуралдай” танхим  
10 цаг 10 минут

### **НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Хуралдааны ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 2023 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх 3 асуудал байна.

Нэг.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг. /Зарчмын зөрүүтэй 53 саналтай/.

Хоёрт.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /зарчмын зөрүүтэй 12 саналтай/

Гурав.Хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаарх Улсын Их Хурлын Хяналтын сонсголын тайланг сонссон талаар санал, дүгнэлт хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д заасны дагуу Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлж асуудал нэмэх, дараалал өөрчлөх, горимын санал гаргах саналыг 2 гишүүн ирүүлсэн байна. Улсын

Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг, Хассуурийн Ганхуяг нарын гишүүд ирүүлсэн байна.

Норовын Алтанхуяг гишүүний бичгийг уншиж танилцуулъя. Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар танаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хурлын 2023 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх зөвшөөрөл олгоно уу. Үг хэлэх үндэслэлүүдийн талаар тодорхой дурдаж бичсэн байна. Ингээд Норовын Алтанхуяг гишүүн.

**Н.Алтанхуяг:** Өглөөний амгаланг айлтгая. Эрхэм гишүүд анхаарч байгаарай. Би 3 санал хэлэх гэж байгаа юм. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад, төсөвтэй холбогдуулаад 1 дүгээр асуудал нь энэ нэмэгдсэн өртгийн албан татварын урамшуулал. Энэ ийм түүхтэй юм. Би бас нэг түүх хэлье. 2014 оны 9 сарын 4-ний өдөр Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын системийг хөгжүүлэх төслийн нэгжийг байгуулах тухай Улаан сайд, Алтанхуяг гээд ийм гарын үсэгтэй энэ 2 хувийг буцааж олгоё гэдэг энэ системийг 2014 онд ингэж эхлүүлсэн юм. Энийг энэ тэр үеийн Татварын Ерөнхий Газрын дарга нь Батмагнай гэж хүн байж байгаад бид нар энэ НӨАТ-ыг ер нь буцааж өгдөг урамшууллын систем чинь их зөв юм байна. Далд эдийн засгийг ил болгох юм байна. Хөшүүрэг болох юм байна. Тийм учраас энийг эхлүүлбэ гээд ингээд эхэлсэн юм. Тэгээд явсаар байгаад дараа нь хууль нь гараад 2 хувь болсон юм. Энийг 5 хувь болгохыг Жавхлан сайд та нар дэмжмээр байна. Бид нар юу гэсэн юм гэхээр тэр үед далд эдийн засгийг ил бол болгоно. Дээр нь байна шүү дээ бүгдээрээ НӨАТ төлөгч болох тэр систем рүү шилжье. Нэг нь НӨАТ-тай, нэг нь НӨАТ-гүй. НӨАТ-аас бултдаг энэ юм алга болно гэж үзээд, тэгсэн тохиолдолд бид нар нь НӨАТ-ын урамшууллыг нь өшөө нэмэгдүүлбэ гэдэг ийм концепц ханган ярьсан юм. Тэгэхээр



энэ сая Их Хурлын даргын санал аваад яваад байгаа энэ зөв зүйтэй шүү. Би тэр хэдэн хүн нь дэмжсэндээ чухал биш. Бодлогын хувьд бид нар энийг хийх ёстой. Аж ахуйн нэгжүүд дээр ямар их муухай дарамт очдог гэж бодож байна та нар энэ Нөат гэдэг чинь. Тийм учраас энийг та бүхэн маань олонх юм чинь зөв бодлогыг дэмжээд нэг их талцалгүй шиг энийг уг нь шийдчихмээр байна. 1 дүгээр асуудал.

2 дугаар асуудал энэ Хүрэлбаатар эртээд телевизээр худлаа ярьчихсан зогсож байна лээ. Үгүй ээ, энэ нүүрсний үнэ төсвийн орлого гэнэтхэн доошоо унавал яах юм бэ. Энэ НӨАТ чинь буулгаж болохгүй гэж, урамшууллыг нь нэмэгдүүлж болохгүй гэж худлаа ярьж байгаа юм. Энийг яагаад худлаа ярьж байгаа вэ гэхлээр би энэ 2019 онд Монгол улсын энэ баялгийн сангуудын тухай нэг пресентэйшн илтгэл тавьж байсан. Энэ дээр ийм байдаг байхгүй юу. 2 дахь асуудал нь. Төсвийн тогтворжуулалтын сан, Жавхлан, Төсвийн тогтворжуулалтын санг та нар идчихсэн байхгүй юу. Төсвийн тогтворжуулалтын сан гэдэг чинь бол ямар үүрэгтэй вэ гэхлээр түүхий эдийн үнэ өссөн үед нь тэр өсөлтийнх нь мөнгөнүүдийг аваад жоорлоод, хадгалаад түүхий эдийн үнэ буусан үед нь тэр тогтворжуулалтынхаа сангаас мөнгөө гаргаж хэрэглэж байх ийм үүрэгтэй. Санг Сайханбилигийн Засгийн газар, Эрдэнэбатын Засгийн газрын үеэс аваад, дараа энэ Хүрэлбаатарын үеэс аваад зүгээр л төсвийн цоорхойг нь өгдөг болчихсон. Энэ бол маш их мөнгө устгасан. Би зүгээр 2019 он хүртэл үзэхээр 1 их наяд 309 тэрбум төгрөгийг Тогтворжуулалтын сангийн мөнгийг зүгээр л цоорхойгоо нөхчхөж байгаа юм. Ингэж болохгүй. Тэгэхээр энэ НӨАТ-тай ямар ч холбоогүй байхгүй юу. Тэр юмны үнэ түүхий эдийн үнэ өсөж, буурахад тогтворжуулалтын сангаа та нар хуулийнхаа дагуу сэргээгээд энийгээ ашигла гэж байгаа юм.

3 дахь нь Ирээдүйн өв сан байхгүй юу. Ирээдүйн Өв санг бас алаад идчихсэн. Болиоч дээ Жавхлан. Энэ ийм хуультай байхгүй юу. 2030 он хүртэл энэ Ирээдүйн өв сангаас нэг ч төгрөг зарцуулж болохгүй гэснийг та нар бас хүчиндэж байгаад энэ мөнгийг аваад иддэг болчихсон. Хэдэн их наяд мөнгө энд цугларсныг аваад бас идчихсэн. Идчихсэн гэдэг нь зарцуулчихсан. Тэгэхээр ийм ийм юм. Энэ ингэж байгаа юм. 2030 оноос эхэлж сангийн хөрөнгө оруулалтын цэвэр орлогын 10 хувийг улсын төсөвт шилжүүлнэ. Энэ чинь ийм ирээдүйдээ нөөцөлсөн мөнгө байхгүй юу. Ингээд тогтворжуулалтынхаа санг аваад идчихдэг, Ирээдүйн өв сангаа аваад идчихдэг. Тэгээд НӨАТ-ыг буцаан олголт буюу урамшууллыг нь 2-ыг 5 болгоё гэхээр Үгүй ээ, гээд л хэрүүл үүсгээд. Төсвийнхөө зарлагыг багасга Жавхлан. Би бол Ерөнхий сайдыг хэлэхгүй байна. Энэ Хүрэлбаатар сайд, Жавхлан сайд 2 энэ асар их буруу бодлого явуулж байна. Монгол Улсын төсөв 1 жилийн дотор төсвийн зарлага 2 дахин өснө гэдэг чинь юу гэсэн үг юм. Ийм айл дэлхий дээр байхгүй. Харин ч төсвийн зарлагыг дандаа барьж явдаг байхгүй юу. Тэрнийг бас хуулиар зохицуулдаг. Одоо хууль бол Монголд гууль боллоо. Та нар ерөөсөө ямар ч хуулийг аваачаад л олуулаа шуураад л, өөрчлөөд л хаячхаж байгаа юм.

Дахиад би хэлэлцэх асуудалтай холбоотой 1 юм хэлэх гэж байгаа юм. Та нарын энэ тавьчхаад байгаа хавар баталчихсан тоонуудаа одоо өөрчлөх гэж байгаа юмаа болиоч ээ. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Тодорхой санал хэллээ. Энэ асуудлаар ажлын хэсэг байгуулагдсан. Төсвийн байнгын хорооноос яаралтай танилцуулах байх.

Дараагийнх Хассуурийн Ганхуяг гишүүн бичиг ирүүлсэн байна. Монгол Улсын Их Хурал 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн

газарт чиглэл өгөх тухай 69 дүгээр тогтоолыг баталж, уг тогтоолоор 2023 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр баталсан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 6 дугаар зүйлээр зарим зөвшөөрлийг хүчингүй болсонд тооцсонтой холбогдуулан салбарын хууль тогтоомжийг нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, холбогдох хуулийн төслийг 2023 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт чиглэл өгсөн. Дээрх асуудлаар Миний бие Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д заасны дагуу 2023 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд үг хэлэх хүсэлтэй тул зохих журмын дагуу зөвшөөрөл олгоно уу гэсэн байна. Хассуурийн Ганхуяг гишүүн.

**Х.Ганхуяг:** Өглөөний мэнд хүргэе. Зөвшөөрлийн хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор бас үг хэлэхгүй бол болохгүй байна. Бид нар Улсын Их Хурлаас Зөвшөөрлийн хуулийн хэрэгжилттэй холбоотой шалгах ажлын хэсэг ажилласан. Санал дүгнэлтээ сая хаврын чуулганаар хэлэлцүүлээд, Улсын Их Хурлын 69 дүгээр тогтоолыг 7 сарын 7-нд баталсан байгаа. Тэгээд 69 дүгээр тогтоолоор бол Засгийн газарт хэд хэдэн чиглэлээр үүрэг өгөгдсөн байдаг. Ерөөсөө хэрэгжилт хангагдахгүй байна. Тэгээд энэ хэрэгжилт хангагдахгүй байгаагаас гадна Зөвшөөрлийн хууль бол маш энгийн хууль юм. Ерөөсөө л яг хувийн хэвшил бол өөрсдөө хэлэлцээд, өөрснөө бид нарт бүх юмыг нь боловсруулж өгсөн хууль гэж харахад бол болно. Яагаад гэхээр дандаа л хуулийн этгээд талаас нь, иргэн талаас нь эрхийг нь хангасан ийм хууль юм байгаа юм. Тэгээд зөвшөөрлийн хууль дээр хэдэн асуудал үүсчхээд байна.

1 дүгээрт бол Зөвшөөрлийн хуулиар ямар нэгэн зөвшөөрлийг бүртгэл нэрээр, лиценз нэрээр шинээр бий болгохгүйгээр маш тодорхой оруулж

өгсөн. Зөвшөөрлийн хуулийн 1.5-д заасан байгаа. Мөн тухайн хуулийнхаа 8.1, 8.2-т яг ийм ийм зөвшөөрлүүд байна гэдгээ бид нар бүр хуульчлаад, нэрлээд хэн олгох вэ гэдгийг нь заачихсан байгаа. Тэгээд энэ зөвшөөрлүүдтэй холбоотойгоор ямар асуудал үүсэж байна гэхээр и-монгол платформ дээр и-бизнес гэдэг цэс гаргаад 100 гаруй зөвшөөрлийг бүртгэл нэрээр нэмчихсэн байна. Тэгээд энийг Байнгын хороон дээр ч хэлсэн. Энэ дээр бол мухлагийн зөвшөөрөл, 8 нэрийн барааны дэлгүүрийн зөвшөөрөл, дугуй засварын зөвшөөрөл гээд ерөөсөө байж болох бүх үйлчилгээг дахиад зөвшөөрөл бий болгоод оруулчихсан байгаа. Тэгээд зөвшөөрлийг шинээр нэмэхийн тулд хэд хэдэн процессоор бид нар хуульдаа маш тодорхой зааж өгсөн байхгүй юу. 1 дүгээрт бол нээлттэй сонсгол явуулна. 2 дугаарт Засгийн газрын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцүүлнэ. 3 дугаарт Засгийн газраар хэлэлцүүлээд Улсын Их Хуралд өргөн барина гээд маш тодорхой оруулж өгсөн. Хэрвээ зөвшөөрлийг оролдохоор бол Улсын Их Хурал хуулиар өөрчлөхөөр бид зааж өгсөн. Гэтэл өнөөдөр и-бизнес дээр 100 гаруй бүртгэл нэрээр шинэ зөвшөөрөл бүр тусгай зөвшөөрөл гэдэг цэс дотроо 100 гаруй бүртгэл гэж оруулаад тэгээд саяын яриад байгаа тэр мухлаг юу байдаг юм баахан зөвшөөрлийг шинээр бий болгочихсон. Нөгөө бид нарын батлаад байдаг хуулийг яаж гууль болгох вэ гэдгийг бид нар яг нүдээрээ л хараад байж байна. Иргэд, аж ахуйн нэгжүүд асуудал үүсэхээр асар их хэмжээгээр гомдол ирэх юм. Тэгээд энэ дээр бол бид нар Эдийн засаг, хөгжлийн яам, Засгийн газар руу удаа дараа бичгүүд явуулж байна. Хариултаа авмаар байна. Өнөөдөр ингээд Эдийн засаг, хөгжлийн сайд Хүрэлбаатар бас хуралд оролцож байна. Тэгээд энэ дээр яг би хариултаа авчихмаар байна.

2 дугаар асуудал болохоор энэ дунд шатны энэ авлига, хүнд суртал бол замаа алдаж байна. Бид нар бол 35 дугаар тогтоол 69 дүгээр тогтоолоор яг аль аль хуулиар нэмэлт, өөрчлөлт

оруулах вэ аль аль хуулийг нийцүүлэх вэ гэдгээ маш тодорхой зааж өгсөн. Тэгээд өнөөдөр нөгөө витаминтай холбоотой асуудалд бид нар зөвшөөрөл шаардлагагүй гээд заачхаад баталчхаад байхад дунд шатны буюу Эрүүл мэндийн яамны бүр нэр бүхий албан тушаалтнууд 3 удаа бичгээр өгсөн. Бүр хуулийг нь ингэж оруулна шүү гээд хуулийг нь бичээд өгсөн. Оруулж ирээгүй. Тэгээд өнөөдөр витамин дээр болон бусад зарим нэг зөвшөөрлүүд дээр зөвшөөрөл нэхсэн хэвээрээ л байгаад байна. Тэгээд энэ дээр би Хүрэлбаатар сайдаас бас яг хариу авчихмаар байдаг. Иргэд Аж ахуйн нэгжүүд хүсэлтээ өгөөд байдаг зүгээр ингээд чөмөдантайгаа орж ирэхэд л 2 ширхэг витамин үлдээгээд бусдыг нь бүгдийг нь хурааж авдаг жишиг яг үргэлжлээд л явж байна. Хил, гаалиар орж ирэхэд нь зөвшөөрөл нэхдэг байдал үргэлжлээд л явж байна. Тэгэхээр энэ хуулийг хууль болгосооргүй байна. Улсын Их Хурал бол маш сайн дэмжсэн. Аж ахуйн нэгжүүдтэй бид нар 1500 гаруй аж ахуйн нэгжтэй энэ хуулийн зүйл заалт болгоноор хэлэлцээд орж ирсэн. Тэгээд сайн хууль гэдэг маань яг яалт ч үгүй иргэд, аж ахуйн нэгжүүд өөрсдөө эргээд хяналтаа тавьдаг хуулийг л сайн хууль гэдэг. Тийм болохоор энэ дээр ямар нэгэн гажуудал үүсэхээр маш ихээр ингэж санал гомдол ирдэг. Тэгээд би ерөөсөө л 2 юмыг л та бүхнээсээ хүсэх гээд байгаа юм. 1 дүгээрт Их Хурлаас дахиж ажлын хэсэг байгуулж шалгамаар байна. Шалгалтын ажлын хэсэг гаргамаар байна. 2 дугаарт би Хүрэлбаатар сайдаас яг саяын асуултууд дээр би хариу авчихмаар байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Хэлэлцэх асуудалтай холбогдуулж үг хэлнэ. Асуулт хариултын цаг биш. Өнөөдрийн хэлэлцэх асуудалтай асуудал нэмэх, тов дараалал өөрчлөх, хойшлуулах, асуудал нэмэх горимын санал гаргах бол мэдэгдэж байгаа. Маргааш Засгийн газар асуулт хариултын цагтай. Тэр дээр тавьж болно. Асуулгын хариуг

бичгээр, амаар аль ч хэлбэрээр бичгээр хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар асуулга, асуулт тавих бүрэн эрхтэй гишүүд.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Чимэдийн Хүрэлбаатарын урилгаар Увс аймгийн Улаангом сумын багийн Засаг дарга нар Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Улаангом сумынхаа багийн Засаг дарга нарт ажил хөдөлмөрийн өндөр амжилтыг Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Багийн Засаг дарга нарын цалин нэмэгдсэн. Цалин нэмэгдлээ авч байгаа биз дээ. Ажлаа улам сайжруулаарай.

**Хэлэлцэх асуудалдаа орёё. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.**

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн танилцуулна. Индэрт урьж байна.

**Д.Тогтохсүрэн:** Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн 21 хуулийн төсөл, Монгол Улсын Их Хурлын 7 тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн

байнгын хороо болон холбогдох Байнгын хороодод шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн хуралдаанаараа дээрх хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгээ явуулж, дараах санал, дүгнэлтүүдийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй, Төрийн байгуулалт, Эдийн засгийн байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд хамаарах хууль, Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэн санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хамт Төсвийн байнгын хороонд ирүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын даргын 2023 оны 162 дугаар захирамжаар Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд тус ажлын хэсгээс хууль, тогтоолын төслүүдийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг тус бүрээр нь санал хураалгаж шийдвэрлэсэн болно.

Мөн Төсвийн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39. 10 дахь хэсгийг үндэслэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцэн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан гишүүн бусад Байнгын хороо ажлын хэсгээс гаргасан саналын томъёолол тус бүрээр санал хураалгасан.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгээс:

1. Уул уурхайн биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

хуулийн төсөлд стратегийн орд эзэмших төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотой Монгол Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу нүүрсийг харилцан ашигтай, тогтвортой, урт хугацаанд худалдах гэрээг байгуулахад уул уурхайн биржээр заавал арилжаалахгүй байхаар хуулийн төсөлд өөрчлөлт оруулах,

2. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан Засгийн газрын бүрэн эрхэд хамаарах газрын ерөнхий төлөвлөгөө, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нийцсэн эсэх талаар гаргасан газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүгнэлтэд үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх олгох шийдвэр гаргахтай холбоотой заалтыг хасах,

3. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлд төсвийг ил тод хариуцлагатай байх зарчимд нийцүүлж, төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрөөр төлөвлөн хөтөлбөр, арга хэмжээний үр дүн болон үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, түүнтэй уялдсан төсвийн зардлыг тооцож боловсронгуй байх гэсэн дэд заалтыг нэмэх. Мөн орон сууцын ипотекийн зээлийн эрэлт болон төвлөрлийг сааруулах бодлоготой уялдуулан ипотекийн хөтөлбөрийн эх үүсвэрийг нийслэл орон нутагт үе шаттайгаар нэмэгдүүлэх. Ипотекийн зээлийн 60 хувийг хөдөө орон нутагт иргэдийг орон сууцжуулах хөтөлбөрт хуваарилах, агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах зорилгоор инженерийн дэд бүтцийн шийдэлтэй нийт талбай нь 100м<sup>2</sup>-аас ихгүй хэмжээтэй амины орон

сууцыг ипотекийн зээлд хамруулах арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар, Монголбанканд даалгахаар гэж өөрчлөн найруулах санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын гишүүн Раднаасэд Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил ашиглалтад байгаа газар дээр хууль бусаар баригдсан барилга, объектыг төрийн өмчид хураан авах ажлыг зохион байгуулах гэсэн нэмэлт санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно. Байнгын хорооны хуралдаанаар хууль Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулах үед гарсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд тараасан болно.

Монгол Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ бүртгүүлнэ.

Ажлын хэсгийг танилцуулъя. Сангийн сайд Болдын Жавхлан, Уул уурхайн хүнд үйлдвэрийн сайд Жамбалын Ганбаатар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Барсүрэнгийн Баасандорж, Чулуунбаатарын Дондогмаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Жигжидийн Ганбат

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Энхтуяагийн Ганхүү Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Цогтын Баярбат Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Цэдэнбалын Батзул Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга, Баттулгын Дөлгөөн Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга, Анандын Энхманлай Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Түмэндэмбэрэлийн Золзаяа Эдийн засаг, хөгжлийн яамны Инновацын бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Ганболдын Золбоо, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга Зоригтбаатарын Энхболд, Эдийн засаг, хөгжлийн яамны Төр хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга Очиржанцангийн Мөнхтөр, Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Энхтөрийн Батмөнх, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Лувсанвандангийн Ичинноров.

Раднаасэд гишүүн нэмэгдэх юм байна. Раднаасэд, Дашдондогийн Ганбат гишүүдийн нэрийг нэмж оруулъя. Нэр нь орохгүй байна гэж байна. Өөр хүн байна уу. Улсын Их Хурлын гишүүдийн эрхэнд халдахгүй. Асуулт асууж үнэн зөв хариулах үүрэгтэй гишүүд. Тогмидын Доржханд гишүүн.

**Т.Доржханд:** Баярлалаа. Энэ дагасан хууль дээр орон сууцын ипотекийн зээлийн эрэлт болон төвлөрлийг сааруулах бодлоготой уялдуулан ипотекийн хөтөлбөрийн эх үүсвэрийг нийслэл, орон нутагт үе шаттайгаар нэмэгдүүлнэ гэсэн ийм тогтоолын бас төсөл орж ирж байна. Тэгээд Сангийн сайд нь байна уу. Засгийн

газар, Сангийн сайд байна. Хөгжлийн сайд нь байна. Бид нар чинь энэ ипотекийн зээлийг Засгийн газар руу 1 дүгээрт шилжүүлнэ гээд. Тэгээд энийг ярьж байгаад эдийн засаг маш хэцүү байсан 2016, 2017 онд чинь 5 тэрбум долларын өргөтгөсөн санхүүжилтийн хэлэлцээр хийгээд, мөнгө авч байсан шүү дээ валютын сангаас. Тэгээд эдийн засаг ингээд босоод ирэнгүүт нөгөө нэг тохиролцоо байдаггүй. Яагаад вэ гэхээр дэлхий дээр ингэж зээл өгдөг ипотекийн санхүүжилт хийдэг төв банк гэж байхгүй шүү дээ. Дэлхий дээр байхгүй шүү дээ. Тэгээд ийм буруу бодлогыг ингээд үргэлжлүүлээд яваад байдгаа хэзээ болих юм бэ. Хэзээ Засгийн газар авах юм. Энийгээ хэлчихмээр байна.

2 дугаарт энэ агуулга чинь яах юм мөнгө хэвлэх гээд байгаа юм уу. Төв банкныг мөнгө хэвлээд, эх үүсвэрийг нь нэмэгдүүлээд тэгээд орон нутаг, нийслэлд өг гээд байгаа юм уу. Ингэж уншигдаад байна. Энэ дээр тодорхой тайлбар өгөөч. Одоо та бүгд чинь ингээд маш их төсвөө ингээд тэлчихсэн, тэгээд мөнгөний бодлого дээр ямар ч орон зай байхгүй болгочихсон. Тэгээд нэмээд ингээд төсвөө ингээд тэлээд байдаг, үр дүнд нь бас мөнгөний бодлогоо та нар ингээд сайхан мөнгөө хэвлээд тэгээд орон нутгаар ингээд тараачих. Яагаад гэвэл ирэх жил сонгууль байна гэсэн ийм байдлаар явах юм бол инфляцаа дийлэхгүй шүү дээ. Төв банк чинь 6+-2 гэдэг ийм л инфляцын зорилтот түвшинээ дахиад л оруулаад ирсэн байна лээ шүү дээ. Гэтэл энэ жилийн эхэнд л 17, 18 хувьтай байсан инфляц одоо оны дундаж дүнгээрээ бол 14, 15-тай л гарахаар байна шүү дээ. Тэгээд манай судлаачдын тооцоогоор болохлоороо төсвийг 1 их наядаар нэмэх юм бол инфляц 1 хувиар өсөх нь гээд тэгээд ирэх жилийн инфляц чинь 14, 15 хувьтай байхаар байна гэдэг ийм л үр дүн гаргаад байна шүү дээ. Тэгээд энэ чинь мэргэжлийн байгууллагууд нь энэ дээр яг тодорхой өөрсдийн тооцоололтой байр суурьтай байх ёстой шүү дээ. Тийм

болохлоор Сангийн яам Хөгжлийн банкнаас асуугаадахъя. 2 асуулт шүү.

Нэг дэх нь энийгээ Засгийн газар руу хэзээ шилжүүлэх юм бэ? Монголбанк, төв банкаа ингээд зүгээр нэг арилжааны банк шиг ийм ажил хийлгээд байж болохгүй шүү дээ. Энэ чинь бие даасан хараат бус институц байх ёстой.

2 дугаарт мөнгө хэвлэх гээд байна уу, үгүй байна уу. Энэ дээрээ тодорхой хариулт авмаар байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатар, Хассуурийн Ганхуяг, Салдангийн Одонтуяа нарын урилгаар Баянгол дүүргийн 14, 15 дугаар хорооны иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс та бүхэнд сайн сайхныг хүсэн ерөө.

Хэн хариулах вэ. Болдын Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Доржханд гишүүний асуултад хариулъя. Санаа зөвж байгаа асуудал агуулга бол зөв өө, зөв. Би санал нийлж байна. Ирэх жил аль болох Төв банкны инфляцаа онилсон зорилтот тэр бодлогын түвшинд бид аль болох төсөв, мөнгөний бодлогыг нийцүүлэх хэрэгтэй. Энэ дээр бол нэг ийм юм байгаа шүү Доржханд гишүүн ээ. Хэрвээ тэр ойлгомжгүй ч юм уу эсвэл зүгээр агуулгын хувьд дутуу ойлгогдоод байвал Төв банк зөвхөн оператор хийнэ. Зөвхөн тэр клирингийг нь хийнэ ч гэдэг юм уу тодруулж оруулчихвал бүр хардлагагүй байх. Хаанаас ч нэмж мөнгө хэвлэх, нийлүүлэлт хийх ямар ч шаардлагагүй болчихсон байгаа. Энэ чинь өөрөө 10 хэдэн жилийн хугацаанд 4 гаруй их наяд төгрөгийн ийм пүүл үүсчихсэн. Сар болгон 30-40 тэрбум төгрөгийн эргэн төлөлт орж ирдэг. Энийгээ эргүүлээд л гаргаад байхад жилд 400-500 тэрбум төгрөгийн эргэлт үүсчихсэн байхгүй юу.

Тэгэхээр яг одоохондоо Засгийн газрын аль ч яам дээр ямар Хэрэг эрхлэх тэр авалтай нь биш. Яг ингээд оператор клиринг хийх боловсон хүчин болон яг техникийн түвшинд бид боломжгүй байгаад байна. Бидэнд жоохон хугацаа хэрэгтэй байна. Ядаж нэг жилийн хугацаа хэрэгтэй байна. Тэр хооронд бас Дэлхийн банкны бид төсөл авчихсан явж байгаа. Засгийн газар ямар бүтцээр, ямар үүрэгтэйгээр цаашаагаа тогтвортой энэ ипотекийн зах зээлээ Засгийн газар өөрөө ингээд бүрэн хянаад ингээд авч явах вэ. Мөнгөний бодлоготойгоо уялдуулаад гээд нэг ийм л юм байгаа юм. Тийм учраас тэнд ямар нэг мөнгө хэвлэх, шинээр мөнгөний нийлүүлэлт хийх ямар ч шаардлагагүй л болчихсон байгаа юм л даа. Асуудал нь өөрөө. Ийм л юм байгаа юм. Тэгээд үүний цаана ингээд зах зээл өөрөө хохироод байгаа учраас боломжгүй байна. Болохгүй байгаа юмаа болохгүй байгаа гэдгийг нь хэлээд, тэгээд мэргэжлийн байгууллагаар нь нэг хэсэг явуулаадхаач л гэж байгаа юм. Ийм л зүйл юм байгаа юм. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Тогмидын Доржханд гишүүн тодруулж асууна.

**Т.Доржханд:** Тэгэхээр Сангийн сайд маш тодорхой ойлголтоо нэгтгэлээ шүү. 1 дүгээрт мөнгө хэвлэнэ гэдэг ойлголт бол байхгүй гэж хэлж байсан. Гэтэл зарим гишүүдээс бол мөнгө хэвлэх ёстой гэдэг санаачилга гараад яваад байгаа юм байна лээ шүү. Тийм зүйл байх ёсгүй шүү. Мөнгө хэвлээд төсөв тэлчихсэн ийм үед мөнгө хэвлээд, тэгээд хэчнээн цалин, тэтгэвэр, тэтгэмж нэмлээ гээд ямар ч бодит орлого өсөхгүй шүү. Тэгээд эргээд эдийн засгаа чирнэ шүү. 2012, 2016, 2017 оны тэр баахан ингээд төсвийг нь тэлээд л 4 төсөвтэй явсан Монгол банкаа Засгийн газар шиг бас нэг яам шиг болгосон энэ асуудлыг та нар давтаж болохгүй. Энийгээ яаралтай өгөх хэрэгтэй.

2 дугаарт энэ яг Сангийн яам дээр авах гээд байгаа юм уу, Эрчим хүчний

яам дээр авах гээд байгаа юм уу цаашидаа. Эрчим хүчний яам дээр авах гэж байгаа бол эрчим хүчний сайдаас нь асуумаар байна. Яг бэлтгэлээ хангаж байгаа юм уу. Та яг авах юм уу. Хэзээ авах юм. Энийгээ тодорхой хариулж өгөөрэй. Тэгэхгүй бие бие рүүгээ ингээд түлхээд, тэгээд Монголбанк дээрээ та нар 4 жил цоожилчихсон шүү. Ипотек өгдөг дэлхийн төв банк гэж байхгүй шүү.

**Г.Занданшатар:** Жавхлан сайд хариулъя. Болдын Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Доржханд гишүүнтэй санал нийлж байна. Одоо Нийслэлийн орон сууцын корпорац шиг ер нь нэг тийм институт л байгуулагдаж таарах байх. Тэгээд Барилга, хот байгуулалтын яам, манай 2-ын л оролцоотойгоор л хяналтдаа байлгаад л явна даа. Бид аль болох цалин, тэтгэвэр, тэтгэмжийг инфляцтайгаа уялдуулж сая 7 сард орсон өөрчлөлтийг бас 6 сарын дараа, дараанаас шүү 4 сарын 1-ээс өөрчлөлт орохоор нэмэгдэл нь тэндээс эхлэхээр ингэж төсөвтөө оруулж ирсэн байгаа. Тийм болохоор аль болох л энэ эдийн засгийн яг айл өрх рүү орж байгаа энэ орлогын аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдлыг хамгаалж инфляцад өртөхгүй байхаар, эргээд инфляцыг өдөөхгүй байхаар Монголбанктэй ярилцаад цаг хугацааны хувьд ингэж зохицуулалт хийж оруулсан байгаа шүү.

**Г.Занданшатар:** Сангийн сайд Доржханд гишүүний саналыг дэмжиж байгаа юм байна. Хуулиараа ч гэсэн төсвийн шинж чанартай үйл ажиллагааг Монголбанк санхүүжүүлэх ёсгүй. Тэгэхээр энэ дагалдах хууль, тогтоолд байгаа тэр заалтыг хасах нь гэж тохирлоо. Монголбанк санхүүжүүлж болохгүй. Мөнгө хэвлэж болохгүй. Тэгээд банканд байсан мөртөө Жавхлан сайд хүртэл ингээд Монголбанк доороо нэг хэвлэх машинтай мөнгө хэвлээд байдаг юм шиг юм яриад байх юм. Энэ ард түмний чинь амьжиргаа

үнийн өсөлтөд хэлмэгдэж байна. Энэ ипотекийн зээл шууд бусаар ханшид нөлөөлнө, шууд нөлөөлнө. Хамгийн их импортыг дэмждэг ийм зарцуулалт. Тэгээд энийг ингээд нэмэгдүүлээд, төсвийг тэлээд, ард иргэдийн хамгийн их санаа зовж байгаа асуудал үнийн өсөлт байна. Тэгтэл энэ үнийн өсөлтөд анхаарахын оронд, төсвийн зардал хямгадахын оронд энэ мөнгөний нийлүүлэлтийг улам тэлж, төсвийг улам тэлж, ард иргэдийн амьжиргаанд үнийн өсөлт чинь маш хүндээр тусаж байна шүү дээ. Энийгээ Сангийн сайд яагаад ойлгодоггүй юм бэ. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн. Пүрэвдорж гишүүн үгээ татсан уу.

**Б.Пүрэвдорж:** Дарга аа, би бэлтгэлгүй байна. Жоохон байж байгаад дараа нь асуучихъя.

**Г.Занданшатар:** Ширнэнбандийн Адьшаа гишүүн. Ширнэнбандийн Адьшаа гишүүн алга байна. Балжиннямын Баярсайхан гишүүн асуулт асууя.

**Б.Баярсайхан:** Баярлалаа. Жил болгон улсын төсөв хэлэлцэхэд бид нар мэдээж эдийн засгийн хөгжил, улсын төсвөө хэрхэн төсөвлөх, зөв төсөвлөх талаар ярьдаг. Бид энэ 2020-2024 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртөө хүний хөгжлийг дэмжинэ гэсэн ийм том зорилттой орсон. Хүний хөгжлийн бодлого боловсруулна. Манай Эдийн засаг, хөгжлийн яам бол Монгол Улсыг нийтэд нь эдийн засгийн болоод хүний хөгжлийн бас нэгдсэн удирдлагаар хангана гэсэн ийм зорилготой байгуулагдсан ийм яам байж байгаа. Энэ чиглэл дээр хүний хөгжлийг дэмжих, хүний хөгжлийн бодлогыг боловсруулахад энэ жилийн төсөв дээр төсөв юу тавигдсан бэ. Ямар төсөвт тавигдсан юм бэ. Юу хийгдэх юм бэ. Энэ дээр нэг тодорхой хариулт авмаар байна. Салбар хариуцсан яамд нь бол энэ дээр тодорхой бас хариулт өгч чадахгүй байгаа.

2 дугаарт нь би Зам тээврийн сайдаас өнгөрсөн хаврын чуулган дээр хэлж байсан. Энэ Монгол Улсыг хөгжүүлэх тэр үндсэн чиглэлд тусгагдсан хэд хэдэн ажлуудыг бас асуумаар байна. Завхан аймаг энэ жил Улиастай-Алтай чиглэлд Азийн хөгжлийн банкны зээлээр зам баригдах байгаа. Арц сууриас Нөмрөг хүртэл 167км авто замыг концессоор хийгдэхээр ингээд шийдвэрлэгдсэн. Завхан аймагт ганцхан зам байгаа нь энэ жил зураг төсөвтөө орсон зам 12километр Идэр сумаас төв зам хүртэлх 12км замын ажил байгаа. Тэгээд энэ ажил дээр хаврын чуулган дээр мөн хавар чуулган завсарлахын үед Эдийн засгийн байнгын хороон дээр салбарын сайд бол энэ ажил хийгдэнэ гэж хэлсэн. Тэгэхээр Бямбацогт сайдаас бас энэ асуултыг асууж байна.

2 дугаарт нь энэ Халтар сайд салбарын сайдаар ажиллаж байхдаа Тосонцэнгэлийн нисэх онгоцны буудлыг засварлаж энд Тосонцэнгэл болоод хойд аймаг, сумдын иргэдийг онгоцоор нисэх боломжийг хангана гээд төсвөөс 280 сая төгрөг аваад, ингээд энэ онгоцны буудлаа засварласан байгаа. Тэгэхээр Тосонцэнгэлд ирэх жилийн төсөвт шийдвэрлэгдэж онгоц нисэх үү. Иргэд нисээд эхлэх юм бол онгоцоо явуулна гээд байна. Үнэхээр Тосонцэнгэлийн иргэд ганцхан Завханыхан биш, Увс, Хөвсгөл, Архангай аймгийн иргэд энэ Тосонцэнгэлийн нислэгийг бол хүлээж байдаг. Өмнө нь нисэж байсан ийм үйлчилгээ байгаа. Завхан аймагт 7 хоногт бол 2 удаа онгоц нисдэг. Энэ дээр нь тухайн орон нутагт байгаа Уул уурхайн яамны ажилчид захиалга өгчихдөг учраас иргэдэд бол билет олдоогүй ээ. Их Хурлын гишүүний хувьд надад ч гэсэн Завхан руу бол нислэгээр явахад бол хүндрэлтэй байдаг. Тийм учраас энэ Тосонцэнгэл, Завхан аймгийн нислэг дээр бас Бямбацогт сайд та хариулт өгөөч гэж хүсэж байна.

Мөн энэ эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл дээр Доной нисэх онгоцны



буудлыг олон улсын зэрэглэлтэй болгоно гэсэн бас ийм зорилт туссан байгаа. Мэдээж энэ жилийн төсөв дээр бол энэ бол хийх боломжгүй. Нэмээд сануулахад энэ жилийн төсөвт ороогүй ч гэсэн Халтар сайд Загастайн даваан замыг хүлээж авах үед нэг хучилт бол дутуу хийгдсэн гэдгийг бол хэлж байсан. Тэгэхлээр цааш цаашидаа энэ Завхан аймгийн хамгийн сүүлд нийслэлтэй холбогдсон сумд нь нийслэлтэй холбогдож ерөөсөө чадаагүй байгаа. 24 сум алслагдсан газар нутагтай. Өнөөдрийн байдлаас байдлаар 5-6 сумыг л энэ засмал зам дайрч өнгөрдөг ийм байгаа. Тийм учраас ялангуяа Идэрийн 12км замыг энэ жилдээ хийлгэнэ гэснээр нь хийлгэмээр байна гэсэн.

**Г.Занданшатар:** Бямбацогт сайд асуултад хариулна. Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт асуултад хариулна.

**С.Бямбацогт:** Баярсайхан гишүүнээс бас асуултад хариулъя. Тэгэхээр сая Идэр сумын тэр 12км замын асуудлыг бид нар Зам, тээврийн хөгжлийн сайдаас Сангийн яам руу бас саналаа явуулсан. Тэгээд Сангийн яам дээр нэгтгэгдсэн. Ингэж нэгтгэхдээ бас үндсэндээ тодорхой бас баримтлах зарчмууд бариад, тэр шаардлагад нийцэхгүй байгаа учраас гээд бас хасагдсан юм байна лээ. Бусдаар яг та бас өнгөрсөн хавар Эдийн засгийн байнгын хороонд бас анхаараарай гэж хэлж байсан. Яг түүний дагуу бид нар уг нь саналаа явуулсан боловч Сангийн яамнаас Засгийн газраар ороод төсөв өргөн барих үед хасагдсан байгаа шүү. Энийг та зөв ойлгоорой. 2 дугаар хэлэлцүүлгүүд ярьж байгаад бас шаардлагатай бол та саналаар бас оруулах бололцоо, боломж байгаа байх гэж бодож байна.

Онгоцны нислэгийн тухайд Улиастай руу бол онгоц алдаг оног нисдэг байсан. Улиастай төдийгүй ер нь Монгол 21 аймгаас чинь цөөхөн аймаг руу

2, 3 аймаг руу нисдэг болчихсон байсан шүү дээ. Энэ жил бид нар нэлээн асуудал болж байж, нэлээн ярьж байж, нэлээн хэл ам таталж байж. МИАТ компанийг 2009 оноос ч нисээгүй орон нутгийн нислэгийг нисүүлж эхэлсэн. Үүний үр дүнд үндсэндээ 2, 3 аймаг руу биш 9 аймаг руу онгоц тогтмол нислэг үйлдэж байна. Билетийн үнэ бол 2 дахин буурсан байгаа. Хамгийн дээд тал нь Хөвсгөл аймаг руу Мөрөн рүү бол үндсэндээ 2,5-3 дахин буурсан. Ингээд нислэгүүд бол нэлээн нислэгтэй байгаа. Зарим аймгууд руу тухайлах юм бол Дорнод аймаг, Говь-Алтай аймаг, Өмнөговь аймаг гэсэн аймгууд руу бол нислэгийн суудал дүүргэлт багатай байгаа. Бас алдагдалгүй нисэх ёстой. Тийм болохоор бас тодорхой арга хэмжээ авах гэж бид нар бас анхаарч байгаа. Тийм болохоор Улиастай бол уг нь онгоц нисэж байгаа тэр уул уурхайн компаниуд нисээд иргэд нисэж чадахгүй байна гэдэг асуудал дээр бид нар ямар зохицуулалтууд хийж болох вэ. Бас анхааръя. Тосон руу бол яг одоо шууд нисэх бололцоогүй байна. Яагаад гэвэл МИАТ компани ганцхан онгоцтой, ганц онгоцоороо бид нар 9 аймагт нислэг үйлдэж байна. Тийм болохоор одоогоор Тосон руу шууд нисэх бол бололцоо алга байна. Улиастайгаар дамжуулж нислэгийн суудал дүүргэлтийг харж байгаад таны ярьж байгаа асуудлыг бас анхааралдаа авъя.

Завхан аймаг бол 21 аймгаас хамгийн сүүлд хатуу хучилттай замаар холбогдсон. Гэхдээ бас сүүлийн үед бас энэ зам, тээврийн салбарын сэргэлтийн бодлогын хүрээнд бас тодорхой ажлууд хийгдэж байгаа. Говь-Алтай, Завхан, Улиастай чиглэлд бас хатуу хучилттай замаар холбогдоно. Цаашилаад бид нар Ази, Европ, Орос, Хятадыг холбосон 3 дахь бас босоо коридор Орос, Хятадыг холбосон Завхан, Улиастай, Говь-Алтай аймгийн Алтай хотоор дайруулаад ингээд бас барих ийм бодлого барьж байгаа. Өөрөөр хэлэх юм бол Арц суурь, Нөмрөг, Улиастай, Алтай, Бургастай гэсэн боомтоор Ази, Европ, Орос,

Хятадыг холбосон ийм босоо тэнхлэгийн ийм зам барих ийм бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн байгаа. Энэ бол үндсэндээ Завхан аймгийн болон Говь-Алтай аймгийн ард иргэдэд бас нэлээн том үр дүнгээ өгөх байх гэж бодож байна.

**Г.Занданшатар:** Баярлалаа. Эдийн засаг, хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар хариулна.

**Ч.Хүрэлбаатар:** Баярсайхан гишүүний асуултад хариулъя. Ер нь 2024 оны жилийн төлөвлөгөөг бол Улсын Их Хурал 2023 оны 5 дугаар сард баталсан жилийн төлөвлөгөөний гол зорилго бол ерөөсөө л өрхийн орлогыг нэмэгдүүлэх гэж байгаа. Тэгэхээр хувийн хэвшилээ дэмжсэн, өрсөлдөх чадвартай эдийн засгийг бий болгох замаар ажлын байруудыг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажлуудын хэмжээг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдын цалин, тэтгэврийг нэмэгдүүлэх зэрэг ийм арга хэмжээнүүдийг бүгдэнг нь төлөвлөж оруулж ирсэн байгаа гэдгийг би энд онцолж хэлмээр байна.

Зүгээр 2 дугаарт нь Алтанхуяг гишүүн хэд хэдэн зүйл ярьчихлаа. Тогтворжуулалтын санг бараг Жавхлан, Хүрэлбаатар 2 зохицуулаад, зарцуулаад дуусаж байгаа юм шиг юм ярьж байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль бол 2010 онд батлагдсан, 2011 оноос эхлээд хэрэгжиж эхэлсэн. Үгүй ээ, хэрвээ би буруу санаагүй бол 2012-2014 оны хооронд Алтанхуяг Ерөнхий сайд байсан. Энэ Тогтворжуулалтын санг өөрөө адилхан л тэр хуулийн дагуу зохицуулаад л явж байсан шүү дээ. Тэгчхээд одоо болохоор ингээд бусад руу дайрдаг, доромжилдог юм нь хэрээс хэтрээд 2 үгийнх нь нэг нь Хүрэлбаатар болчихоод байгаа юм. Ингээж бас болохгүй шүү дээ.

Дээр нь Ирээдүй өв сангийн мөнгийг идчихсэн юм шиг ярьж байна. Монгол Улсын Сангийн яам дээр байж байгаа төрийн сангийн үлдэгдэл өнөөдөр

4,3 их наяд төгрөг. Энэ жилдээ амжуулаад бид нар Ирээдүй өв сангийн 2,9 орчим их наяд төгрөгийг бид нар тусад нь гаргаад, Монголбанк дээр байршуулна. Түүнээс тодорхой нэлээд хэсгийг нь бид нар бас цаашидаа доллар болгож валютын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авч хадгалах ийм бодлогыг энэ 1 сарын 1-ээс авч хэрэгжүүлэхээр Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам яриад явж байгаа. Тэгэхээр ингэж улс орон даяар зүгээр нэг микрофон олдсон боломж дээр нь гүтгэлэг тарааж болохгүй шүү дээ. Жилийн өмнө Монгол Улсын эдийн засаг амаргүй л байсан. Өнөөдөр яах вэ тогтворжоод явж байна. Гэхдээ энэ тогтворжиж бий болж байгаа амжилтад бол тийм эмзэгдүү байгаа гэдгийг би хэлье. Тийм учраас хэдүүлээ бас улс төр хийж болно. Гэхдээ худлаа ярьж хүн гүтгэж, хаа хамаагүй юм хиймээргүй байна. Телевизийн олон ангит урт нэвтрүүлгүүд хийж дайрч доромжилмооргүй байна. Өчнөөн тэрбум төгрөг орчим зарцуулж хүн гүтгэлгийн ажлуудыг хиймээргүй байгаа шүү дээ. Увсад өрсөлдөх гэж байгаа Алтанхуяг аа, зүгээр очоод өрсөлд. Хажуу талд нь хүн битгий доромжлоод, гүтгээд байгаад байгаарай.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг, Жамбалын Ганбаатар, Салдангийн Одонтуяа нарын урилгаар Улаанбаатар Төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэгийн ахмад ажилтнууд, зөвлөлийн дарга нар Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Ган замчид, төмөр замчдадаа ахмадууддаа, зөвлөлийн дарга нарт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе.

Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна. Ширнэнбандийн Адьшаа гишүүн. Уучлаарай Цогтгэрэл гишүүн. Ширнэнбандийн Адьшаа гишүүн асууна.

**Ш.Адьяа:** Энэ 2024 оны төсөв өргөн барьсантай холбогдуулж хэд хэдэн хуульд өөрчлөлт оруулах тухай Засгийн газраас өргөн мэдүүлсэн байна. Энэ тухай би энэ Ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай хуулийн асуудлаар хариуцсан сайдуудаас нэг асуулт асууя гэж бодож байна. Ноднин энэ улсын төсвийн дагалдах хууль гэж хэлэлцэх үед энэ Ашигт малтмалын тухай хуульд нэг хулгайн заалт оруулсан. Ард иргэдийнхээ эрхийг боомилсон, авлигыг өөгшүүлсэн ийм хуулийг батлуулсан юм. Тэгээд одоо энд ямар хуулийн өөрчлөлтийг Ашигт малтмалын тухай хуульд оруулж ирэх ийм чиглэлийг барьж байна. Энэ 12 дугаар сард багтааж оруулж ирэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл өргөн барьсан. Дээр нь энэ Газрын тухай хууль. Одоо энэ Газрын тухай хууль дээр яг ямар юм оруулж ирэх гээд байгаа юм. Энэ чинь Нийслэлийн Газрын тухай хууль гэж Нямбаатар дарга I Газрын тухай хууль Засгийн газарт өргөн мэдүүлсэн тухайгаа хэвлэл мэдээлэл яриад байгаа. Дээр нь өнөөдөр энэ Засгийн газраас Газрын тухай хууль дээр яг ямар заалт оруулах гээд байгаа юм. Энэ газрын тухай хуулийг чинь ингээд 1, 2 сард багтаагаад шийдэх тийм хууль мөн үү. Газартай холбоотой энэ асуудал чинь өнөөдөр Монголын хамгийн эмзэг цэг болоод байгаа. Дээр нь үндэсний аюулгүй байдалтай холбоотой ч асуудал болоод байгаа шүү дээ. Энийгээ одоо нээлттэй хэлэлцүүлмээр байна. Яг төсөв батлах дээр л нэг ийм юм дагалдуулж орж ирээд л Их Хурлын гишүүд төсвөө батлуулна гээд л тэр рүү харж байх хооронд ийм юм хийдэг нэг ийм арга барил байна уу, байхгүй байна уу. Энэ Засгийн газарт энэ тухай тодорхой хариулт авмаар байна. Ухаандаа одоо тэр газар олгохтой холбоотой асуудал дээр бүр хууль зөрчсөн шийдвэр гаргасан Засгийн газар. Нийслэлийн Засаг дарга газар олгох эрхийг нь Засгийн газрын хуралдаанаас хязгаарлаж байсан. Үгүй ээ, энэ чинь ингээд хуулиа зөрчөөд ингээд байж болох юм уу. Энэ чинь Газрын тухай хуульдаа эхэлж өөрчлөлт оруулчхаад, тэр газар

олгодог этгээдүүдийнхээ эрхийг тэр хуулиараа хязгаарла. Зүгээр Засгийн газрын хуралдаан дээр тэмдэглэлээр ингээж хууль зөрчдөг энэ шийдвэр цаашидаа үргэлжилбэл энэ хууль дээдлэх зарчим, хуульд итгэх итгэл чинь улам доошоо орно.

Энэ газартай холбоотой асуудал чинь хүний амьдралтай холбоотой асуудал шүү. Улс орны эрх ашигтай холбоотой асуудал. Ийм учраас энэ талаар нэг дэлгэрэнгүй мэдээлэл авъя гэж бодож байна.

**Г.Занданшатар:** Жавхлан сайд хариулъя. Болдын Жавхлан сайд. Төсөв дагуулаад яагаад газрын хууль оруулж ирсэн юм бэ. Анхдагч хууль ингээж оруулж ирэх үү гэж байна. Ашигт малтмал дараа нь хариулна. Жавхлан сайд хариулахгүй юм байна. Цэрэнпилийн Даваасүрэн сайд хариулъя даа.

**Ц.Даваасүрэн:** Ер нь яах вэ газрын хуулийг өргөн барьчихсан байгаа нь бол Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байгаа л даа. Тэгэхдээ яах вэ, одоохондоо манайд Газрын харилцааны газар байгаа учраас би зүгээр Газрын ерөнхий хууль яаж орж ирэх юм бэ гэдэг талаас нь л хариулт өгье. Тэрнээс биш одоогийн өргөн барьчихсан байгаа тэр Нийслэлийн нөгөө газар албадан чөлөөлүүлэх тухай хуулийн заалт энэ тэрийг би бас яг нарийвчлан хэлэх боломжгүй байна. Газрын хууль дээр бол бид нар энэ иргэний нийгмийн зүгээс, иргэдийн зүгээс ялангуяа хөдөөгийн иргэдийн зүгээс тавьж байгаа асуудлуудыг нарийвчлан судалж, тусгаж оруулж ирэхээр бэлтгэж байгаа. Тухайлах юм бол, бэлчээрийг тусгай хэрэгцээнд авдаг байсан орон нутгийн эрхүүдийг байхгүй болгочихсон байсан юм. Ер нь орон нутаг газар дээрээ эрх мэдэлгүй болчихсон байсан юм. Тэр өргөн барьсан хуулиар. Энийг бол буцаагаад хөдөөгийн иргэд бэлчээрээ хамгаалах, мөн хөдөө орон нутгууд газраа бас хамгаалах эрх

мэдэлтэй байх тэр зохицуулалтуудыг нь хийж өгнө. Газар олголтыг олон газар хийж байгааг бол ер нь журамлах л ийм реформыг хийж байгаа юм. Одоогийн энэ явагдаж байгаа, энэ өргөн баригдаж байгаа хуулиудын цаад агуулга ерөөсөө тийм байгаа. Энэ олон газар олгож байгааг ерөөсөө больё. Нэг газар л олгоё гэж. Ингэж явахгүй бол угаасаа болохгүй. Төлөвлөлтийнхөө дагуу газар олгоно гээд хуулиуд манайд хангалттай бий. Тэгсэн мөртөө төлөвлөлтийнхөө дагуу олгогдохгүй байгаа чинь өөрөө бүтцийн асуудал байна л гэж үзэж байгаа юм. Тийм учраас энэ бүтэц дээр эрх зүйн зохицуулалтаар шийдвэрлэх асуудал бол байгаа. Энэ бүгдийг шинэ хуульд тусгана. Одоогийн орж ирж байгаа хуулиуд ч гэлээ гэсэн бас тэр агуулгыг оруулсан байгаа гэдгийг хэлье. Тэгэхээр цаашидаа бол газар яах нь вэ, төлөвлөлтийн дагуу олгодог болох тэр бүтцийг л бид нар бий болгохыг зорьж байна л гэсэн үг.

**Г.Занданшатар:** Энэ бол газрын харилцаанд тусдаа асуудал. Болдын Жавхлан сайд хариулъя. 2 минут.

**Б.Жавхлан:** Адьшаа гишүүний асуултад хариулъя. Нэмж ийм мэдээлэл өгье. Ийм юм байгаа юм Адьшаа гишүүн ээ, одоо төсвийн ерөнхийлөн захирагч нь бол Барилга, хот байгуулалтын яам дээр байдаг. Төсөв дагуулж өргөн барьж байгаа агуулга нь болохоор энэ чинь Ерөнхий сайдын доор очиж байгаа юм. Тэгэхээр төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсөв нь гүйж байгаа учраас бид төсөв дээр ийм зохицуулалт хийж байгаа ийм л зүйл байгаа юм. Тэгээд өөр зүйл бол байхгүй шүү. Агуулгыг нь бол сая Даваасүрэн сайд хэлчихлээ. Тэгээд ер нь энэ төсөв дээр нууж хаах юм байхгүй. Төсөв маань бол улам л ил тод болж байгаа. 9 сарын 29-нд өргөн барьснаас хойш ингээд 1 сар гаруй хугацаанд бид олон нийтэд ил тод байдлаар ингэж энд хэлэлцүүлэг хийж ингэж явдаг. Бид 2 ч удаа сэтгүүлчидтэй уулзалт хийж, төсвийг дахин дахин тайлбарлаж

мэдээлэл өгч ингэж ажиллаж байгаа шүү. Тэгээд Ашигт малтмалын тухай хууль бол төсөвтэй огт хамаагүй, өргөн мэдүүлээгүй, тусдаа явж байгаа ийм хууль байгаа.

**Г.Занданшатар:** Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн хуулиар өргөн барихаас Хууль, тогтоомжийн хуулиар 1 сарын өмнө хэлэлцүүлэг хийх ёстой л доо. Өргөн барьсан хойноо биш. Улсын Их Хурал ч гэсэн өмнө нь танилцуулдаг, ярьдаг, бүлгээр ярьдаг байсан. Тэгээд сая бол шууд л ороод ирсэн л дээ. Жамбалын Ганбаатар сайд хариулъя.

**Ж.Ганбаатар:** Ашигт малтмалын хууль 2006 онд батлагдсан. 2006 онд батлагдсанаас хойш маш олон удаагийн өөрчлөлтүүдийг орсон. Олон хуулиудыг нь дагалдах маягаар. Дээрээс нь та бүхэн мэдэж байгаа Урт нэртэй хууль, Түгээмэл тархцын хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Бичлийн журам гээд олон хуулиуд энэ хуулиудын зохицуулалтыг ийш тийш нь татаж салгасан. Энэ бүх үндэслэлийн үндсэн дээр хуулийг шинэчлэн найруулаад 2023 оны 3 сарын 1-нд таны цонхон дээр аваачиж өгсөн. Тэгээд таны тодорхой саналууд ирсэн. Тэгээд саналуудыг тусгаад 10 сарын 1-нд бас буцаагаад хариу өгсөн байгаа юм. Өнөөдөр яг энэ хуульд бол тодорхой саналаа өгөх бүрэн боломжтой. Одоо арай өргөн баригдаагүй байгаа. Тэгэхээр Адьшаа гишүүн та саналаа өгвөл бид тусгаад явах бүрэн боломжтой гэдгийг хэлье. 2023 оны 3 сарын 1-нд анх энэ хууль таны цонхон дээр тавигдсан. Тэрнээс хойш хэлэлцүүлгүүд яваад 1371 санал ирснээс, 476 саналыг нь бид бол тусгасан байгаа юм. Энэ хуульд бол ер нь энэ хууль хоорондын зөрчил гэхэд 156 хууль хоорондын зөрчил байгаа юм. Энэ 2006 оны Ашигт малтмалын хуульд Энэ зөрчлүүдийг зайлшгүй арилгах, тэгээд бусад хуулиудаар зохицуулж байгаа харилцаануудыг нэгтгэх ийм зайлшгүй шаардлага байгаа. Энэ хуулийн гол

зорилго бол хариуцлагатай уул уурхайг явуулах. Хариуцлагатай уул уурхай гэдгийг бол та ойлгож байгаа байх. Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, ил тод байдлыг хангах, хөрөнгө оруулагч нарт зөв мэдээллийг хүргэх гол зорилгууд нь ийм шүү. 2 минутад багтаж хариулахад ийм байна.

**Г.Занданшатар:** Одоо Ширнэнбандийн Адьшаа гишүүн тодруулж асууна.

**Ш.Адьшаа:** Ганбаатар гишүүнд баярлалаа. Энэ хууль батлуулахын тулд их юм хийж байгаа. Их санаачилгатай ажиллаж байгаа гэдгийг мэдэж байна. Ойлгож байна. Тэгэхдээ энэ 2023 оны төсөв батлах үед энэ ашигт малтмалын тухай хуульд хулгайн заалт оруулсан. Яагаад гэхээр энэ ард иргэдийн мэдэх эрх тэр олон нийтээр хэлэлцүүлдэг тэр юм нь байхгүй болгосон шүү дээ. Тэгээд тэр уул уурхайн тухай нутаг дэвсгэрт уул уурхай эзэмшиж байгаа компаниуд хандив өгөхийг тэр сумын орон нутгийн иргэдийг, орон нутгийн удирдлагуудыг лоббидохыг дэмжсэн ийм хууль баталсан байхгүй юу. Та бол санаж байгаа. Би 2, 3 удаа энд эсэргүүцээд, ингээд ямар ч хүчин мөхсөдсөн. Энэ тухай л би яриад байгаа. Тэрнээс биш таныг энэ хууль батлуулахын төлөө маш их хүчин чармайлт гаргаж, сайн ажиллаж байгаад би их баяртай байгаа. Ингээд сайн хууль батлагдаасай, хариуцлагатай уул уурхай болоосой гэдэг дээр санал нэг байна. Хариуцлагагүй.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Энхбаярын Батиугар, Ням-Осорын Учрал, Пүрэв-Очирын Анужин нарын урилгаар Сонгинохайрхан дүүргийн ерөнхий боловсролын 62, 67 дугаар сургуулийн ахлах ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Хүндэт багш, сурагчдаадаа сурлага, спорт, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе. Сурах чиглэлийг эрхэм болговол

хандах чиг үүрэг болохын учир сур сур бас дахин сур гэж улам сайн хичээж сурицаахыг хүсэн ерөөе. Гишүүдийн нэрийн өмнөөс хэлж байна.

Ингээд одоо Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна.

**О.Цогтгэрэл:** 2 асуулт байгаад байгаа юм. 1 дүгээрт нь энэ АМНАТ-ын асуудал, төсөв дагаж орж ирдэг. Тэгэхдээ ер нь энэ АМНАТ-ын хууль дээр АМНАТ-ын орлого дээр бодлогын тийм нэг маргаантай асуудлууд өнгөрсөн хугацаанд бас их явж ирсэн. АМНАТ-ыг давхардуулж авч байна гэдэг асуудал яригддаг. Давхардуулж аваагүй, суутган зарчмаар авдаг гэж тайлбарладаг. Гэхдээ эцсийн дүндээ Монгол Улсад өнөөдөр уул уурхайн бүтээгдэхүүнийг түүхий эдийг дагасан боловсруулах аж үйлдвэр гэдэг зүйл хөгжихгүй л байгаад байгаа юм. Эцсийн дүндээ. Тэр салбарынх нь уулзахлаар ярьдаг. Өөрийн уурхайгүй бүхий л боловсруулах үйлдвэрүүд бүгдээрээ дампуурсан. Дампуурснаас гадна цаашидаа Монголд энэ хууль тогтолцоогоор цаашидаа боловсруулах үйлдвэр хөгжихгүй. Яагаад гэвэл төмрийн хүдэр хилийн урд талд угаагдаж анхны боловсруулалтууд хийгдэж байна. Жошны тэр флотацын хүдэр гэдэг зүйлүүд нь хилийн цаад талд хийгдэж байна. Нүүрс угаах, баяжуулах, коксжуулах үйлдвэрлэлүүд хилийн цаана хийгдэж байна. Энэ бүгд Монголд байхгүй ээ л гэдэг. Манайхан тайлбарлахдаа болохоор энийг давхардуулж аваагүй гэдэг үндэслэл бас хэлдэг. Гэхдээ яг одоо ер нь энэ засгаас барьж байгаа та нарын бодлого дотор яг энэ уул уурхайн боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих, тэр салбарынхны яриад байдаг АМНАТ-тай холбоотой бодлого чиглэлийг ер нь яая гэж бодож байгаа юм. Ер нь жилийн жилд хэдэн тонн нүүрс илүү зараад л, урагшаагаа машинд ачиж гаргаад л энийгээ бид нар хөгжил дэвшил гээд л ингээд ойлгоод яваад байх юм уу, үгүй юм уу. Яг энэ дээр бодлогын ямар өөрчлөлтийг тэгээд

өнгөрсөн энэ АМНАТ-ын хууль болоод энэтэй холбоотой ямар дүгнэлтүүд байдаг вэ. 1 дүгээрт.

2 дугаарт нь НӨАТ-тай холбоотой. НӨАТ гээд бид нар ингээд том л зүйл ярьцаагаад байгаа. НӨАТ-ын энэ буцаан олголт буурах ёстой гэдгийг дэмждэг. Энэ дээр нэлээн тийм тодорхой тоо асуухад яг өнөөдөр Монголд хил, гааль дээр нөгөө НӨАТ-ын буцаан олголтын систем маань яг яаж ажилладаг вэ. Энэ бүрдсэн үү. Гадаадын жуулчид ирээд ер нь НӨАТ гэдэг чинь эцсийн дүндээ хэрэглээний татвараас гадна энэ хэрэглээ нь Монгол нутаг дээр хэрэглэгдчихсэн бол татвар авах л ёстой шүү дээ. Гадагшийгаа гарвал Монголд хэрэглээгүй жуулчин 1 говийн ноолууран цамц аваад гарвал НӨАТ-ын буцаалтаа 10 хувиа авах ёстой. Тэгэхээр энэ тогтолцоо өнөөдөр бүрдсэн үү. Яг үүгээр хэчнээн жуулчин, хэчнээн иргэн ер нь хэчнээн хэмжээний НӨАТ-ын буцаалтыг энэ өөрөө дахиад экспорт болоод олон зүйлийг аялал жуулчлалыг дэмжих бас нэг том хөшүүрэг үүний цаана явж байдаг шүү дээ. Гадагшаа, дотогшоо хил, гаалиар орж гардаг хүмүүс бүгдээрээ л мэдэж байгаа. Тэгэхээр энэ тусдаа 2 асуулт дээр нэг тодорхой хариултууд өгөөч.

**Г.Занданшатар:** Жамбалын Ганбаатар сайд хариулъя.

**Ж.Ганбаатар:** Би АМНАТ дээр нэг цаашид барих гэж байгаа бодлого дээр хэд хэдэн зүйл хэлээдэхье Цогтгэрэл гишүүн ээ. Тэгээд нэмээд Сангийн сайд бас хэлэх байх. Зүгээр яг түрүүний таны асуудаг тэр боловсруулах үйлдвэрүүдийн хувьд бол цаашидаа барьж байгаа бодлого бол “Б” зөвшөөрөл гэж зөвшөөрөл нэмж байгаа. 1 зөвшөөрөл. Энэ зөвшөөрлийн хүрээнд бол яг таны асууж байгаа тэр ямар ч уурхайгүй байгаа, тэгсэн мөртөө бас тодорхой хэмжээнд боловсруулаад экспортлохыг зорьж байгаа тэр хэсгийг ямар төрийн бодлогоор дэмжих вэ гэдгийг бид бас шийдвэрлэхийн тулд, тэр

хүмүүсийг ямар нэгэн байдлаар тэр хуулиас гадуур явуулахгүй, бас хуулийн зохицуулалт дотор байлгахын тулд тэр “Б” зөвшөөрөл гэдгийг нэмж байгаа. Цаад гол зорилго нь бол энэ хүмүүсийг яг тэр боловсруулах үйлдвэрийг дэмжих энэ зорилготой шүү. Тэгээд энэ зөвшөөрлийг аваад цаашаа үйл ажиллагаа явуулж байгаа энэ хүмүүст бас зохицуулалттай больё. Тодорхой энэ хариуцлагад оруулъя гэдэг ийм байдалтай энэ зөвшөөрлийг бол нэмж байгаа. Энэ бол Ашигт малтмалын хуульд суугаад, өргөн баригдчихсан. Сая зөвшөөрлийн зөвлөл хуралдаад энэ зөвшөөрлийг бол нэмэх нь зөв гэдэг шийдвэр бол гаргачихсан байгаа. Тэгэхээр ийм байна. Цаашидаа ер нь АМНАТ-ын бодлого бол биржээр зарагдсан бүтээгдэхүүнийг биржийн үнээр л АМНАТ тооцно. Ерөөсөө цаашидын зорилго бол. Тэгэхгүй бол нүүрсийг бол хамаа замбараагүй өөр гаднын зах зээлийн үнэ гэдгээр өөр байдлаар ч юм уу бас зарж байгаа үнээс нь өндөр үнээс АМНАТ аваад байгаа гэдэг маргаанууд байдаг. Гэхдээ бид бол цаашидаа барьж байгаа бодлого бол бүх бүтээгдэхүүнээ биржээрээ зарна. Тэгээд биржийнхээ үнээс АМНАТ-аа тооцно гэсэн ийм зорилготой байгаа. Зэсийн хувьд АМНАТ бол улсын олон дунджаас маш өндөр байгаа. Тийм учраас зэсийн АМНАТ-ыг шинээр орж ирж байгаа компаниудад Оюутолгой, Эрдэнэт хоёрыгоо бол өөр хуулийн зохицуулалтаар зохицуулаад шинээр орж ирж байгаа тохиолдолд АМНАТ-ыг нь бол тодорхой хэмжээгээр дэлхийн зах зээлийн АМНАТ-д ойртуулж байгаа юм. Энэ бол хайгуулыгаа дэмжих, цаашидаа зэсийн ордыг хайж илрүүлэх ийм зорилготой байгаа гэдгийг бол хэлье. Миний хариулт бол ийм байна.

**Г.Занданшатар:** Болдын Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Гишүүн ээ, нэг ийм ойлголт байдаг шүү дээ. АМНАТ-д гэхээр бид эрдэс баялгийнхаа эцсийн

бүтээгдэхүүн гэдэг ойлголт байдаг. Шат шатны боловсруулах шат яваад байна, яваад байна, эцсийн бүтээгдэхүүнд очоод ингээд АМНАТ чөлөөлөгддөг. Эцсийн бүтээгдэхүүн хүртэл л шат шатны боловсруулалт дээр АМНАТ-ыг ингээд цэвэрлээд өсөн нэмэгдэж байгаа АМНАТ-ыг шат шатанд нь өмнөхийг нь цэвэрлэж хасаж ингэж тооцож ингэж авдаг ийм суурь зарчимтай юм байгаа юм. Энэ татвараас арай жосохон өөр шүү. Ашигтай ажил нь уу, алдагдалтай ажиллаж байна уу хамаагүй ард түмэнд төлөх ёстой Үндсэн хуулийнхаа суурь ойлголт 6.2-оор төлж байгаа төлбөр юм байгаа юм. Тийм учраас энэ дээрээ бол бид суурь тогтолцоо дээр бол ямар нэгэн өөрчлөлт ойрын хугацаанд хийх ийм бодлого бол байхгүй. Энэ удаагийн төсөв дээр бол өөрчлөлт байхгүй орж ирж байгаа.

Манайхныхаар бол Tax free гэж ойлголт манайхан маш сайн мэднэ. Энхийг 1 сарын 1-ээс өгч эхэлж байгаа юм шүү. Гадаадын иргэд, жуулчид Монгол Улсад ирээд хэрэглээ үүссэн бол буцаад гарахдаа бүрнээр нь авдаг. Манай иргэд Германд очоод яаж Tax free буцааж авдаг билээ яг тэр зарчмаар олон улсын системд бид нар орж байгаа. Хуулиа баталчихсан шүү дээ. Хэдүүлээ хуулиа баталчихсан. 1 сарын 1-ээс хэрэгжээд эхлэх юм байгаа юм. Боловсруулах шатыг нь дэмжих нь бол бидний хувьд маш чухал асуудал. Үнэхээр яг тулчихсан байгаа асуудал. Бид аль болох л түүхийгээр нь биш боловсруулж ингэж гаргах хэрэгтэй. Ялангуяа нүүрс дээр бид ойрын хугацаанд түүхийгээр нь гаргах 5-10 жилийн л цонх байгаа. Тэрнээс цаашаа бол үнэхээр тултал нь боловсруулалт хийж гаргахгүй бол бидний зах зээл улам л хумигдана. Тийм учраас одоогоос боловсруулах шатаа дэмжих хэрэгтэй. Ингээд 1 сарын 1-ээс бид уул уурхайн салбарт боловсруулах шат дээр технологийн тоног төхөөрөмж орж ирвэл гаалийг нь бүрэн чөлөөлж байгаа. Гаалийг нь бүрэн чөлөөлж байгаа НӨАТ-ыг 4 жил хүртэл

хойшлуулах ийм шинэ зохицуулалт.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууна.

**О.Цогтгэрэл:** Яг уул уурхайн салбарынхны хэлдэг 2 зүйл байдаг юм байна лээ л дээ. Тэр “Б” зөвшөөрөл гэдгийг нь сайн мэдэхгүй юм. Тийм хэрэгцээ шаардлагууд байдаг байлгүй. Гол зүйл АМНАТ-ын татвар. Нөгөөдөх нь тэр жишиг үнэ, олон улсын жишиг гээд бид нарын арилжааны үнээс өндөр авчихдаг учраас гэдэг. Гэхдээ яг ямар ч байсан бодит байдал дээр өнөөдөр Монгол Улсын хилийн дотор талд боловсруулах үйлдвэрүүд баригдахгүй л байгаа нь л эцсийн дүндээ үнэн л болчихоод байна л даа. Ямар ч байсан өнөөдөр тийм сонирхол байхгүй. Эдийн засгийн тооцоо хийж үзээд, нөхдүүд бүгд хилийн цаана үйлдвэрлэл бариад байгаа. Гэтэл тэр гол ярьж байгаа АМНАТ-ын асуудлыг тэр давхардуулж авдаггүй, суутгаж тооцдог, НӨАТ шиг явдаг гэдгийг бол ойлгож байна л даа. Гэхдээ л үүний цаана Монгол Улсад техник, технологи нэвтрэхгүй ажлын байр Монгол Улсын нутаг дэвсгэр дээр бий болохгүй байгаа нь л өөрөө энэ бодлогын том өөрчлөлт бид нараас шаардаад байгаа гэж л үзэж байна л даа. Тэгэхээр энэ дээр бид нар тэр хариу үйлдлээ үзүүлэх ёстой л гэж боддог. Ямар ч л байсан Монгол нутаг дээр өнөөдөр боловсруулах үйлдвэр баригдахгүй байна. Бодит байдал энэ.

**Г.Занданшатар:** Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

**С.Ганбаатар:** Дагалдах хууль дээр Төрийн албаны тухай хууль орж ирсэн байгаа. Тэрэнтэй холбогдуулж асуулт асууя. Төрийн албан хаагчдын цалинг 10 хувь нэмэх нийтлэг хот тохижилтын үйлчилгээний цалинг 20 хувиар нэмэхээр орж ирсэн. Энэ дээр дагалдах хууль дээр яагаад энэ Төрийн албаны хууль дээр энэ бол яах вэ дээ юмны үнийн өсөлттэй

уялдуулж үндэслэж нэмж байгаа нэмэлт. Гэтэл өнгөрсөн жил дагалдах хууль дээр Төрийн албаны хууль дээр орж ирсэн зүйл байгаа шүү дээ. Бүтээмжийг уялдуулж, бүтээмжтэй уялдуулж нэмнэ гэж заасан. Төрийн албан хаагчдын бүтээмжтэй холбогдуулж нэмэгдүүлэх төсөв энэ төсөв дээр 0 мөнгө орж ирсэн. 0. Монгол Улсад бүтээмжгүй байж болно. Бүтээмжийг анхаарахаа больсон. Тэгэхээр энийг дагалдах хууль дээр яагаад оруулж ирээгүй вэ. Энэ дээр холбогдох тооцоо судалгаа үндэслэл юу байгаа вэ. Үүнтэй уялдуулж бас 2 дугаар асуултаа асуучихъя даа. Тэтгэврийн төсөвт тэтгэврийн хэмжээг 2024 оны 4 сарын 1-ний өдрөөс нэмэгдүүлэхээр заасан байгаа. Тэгтэл Тэтгэврийн тухай хууль бол 2024 оны 1 сарын 1-ээс эхэлж хэрэгжих ёстой. Яагаад 1 улирал хүмүүсийг хохироож байгаа вэ гэсэн ийм 2 асуултыг би асууя.

**Г.Занданшатар:** Болдын Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Ганбаатар гишүүний асуултад хариулъя. 4 сарын 1 гэдэг нь ийм учиртай юм байгаа юм шүү. Яг таны ярьж байгаа тэр эдийн засгийн аюулгүй байдлыг л хангаж байгаа юм. Инфляцад идүүлэхгүй байх. Сая бид тодотголоо 7 сард хийсэн. Ингээд 8 сараас цалингийн эффект нь ороод, ингээд цалингийн нэмэгдлүүдээ аваад явж байгаа. Ингээд 8 сард нэмсэн цалинг төд удалгүй 4 сарын дараа ингээд нэмчих юм бол ёстой нөгөө эдийн засгаа халаагаад, инфляцаа өдөөгөөд нэмсэн биш буцаад бүр үнэгүйдэл болох ийм аюултай. Тийм учраас бид нар цаг хугацааг ядаж 6 сарын мөнгөний бодлогын хүү, мөнгөний бодлогын нөлөөлөл бол ер нь 6 сард гэж ингэж хардаг. Тийм учраас энэ хугацааг гаргаад ингээд оруулж байгаа юм шүү. 4 сарын 1. Дээрээс нь тэр хууль дээр инфляцтай уялдуулж гэж байгаа. Уялдуулж нэмэх ёстой гээд. Тэгэхээр инфляцтай уялдуулна гэдэг маань мөнгөний бодлогынхоо цаг хугацааны

орон зайтай ч бид нар бас уялдуулах ёстой ийм л зохицуулалт юм байгаа юм. Санжаадорж дарга тэр тоотой холбоотой асуудал нэмээд хариулчихъя.

**Г.Занданшатар:** Болдын Жавхлан сайд товч тодорхой хариулъя. Цаг чинь байна. Төрийн албан хаагчдын бүтээмж. Болдын Жавхлан сайд товч тодорхой хариулъя.

**Б.Жавхлан:** Ганбаатар гишүүн ээ, тэр чинь ийм юм байгаа юм шүү. Тэр нэмэгдэл чинь өөрөө сууриа нэмж байгаа байхгүй юу. Суурь цалингаа нэмж байгаа. Гүйцэтгэлд суурилсан нэмэгдлүүд чинь бол тэр дээрээ нэмэгдээд явах юм байгаа юм. Тэр нь бол урсгал зардал дээрээ сууцхсан байгаа. Ялангуяа манай хамгийн том урсгал зардалтай 3 салбар байна. Боловсрол, эрүүл мэнд, нийгэм хамгаалал гээд. Ингээд соёлын салбар, спортын салбар гээд энэ бүх салбарууд орчихсон байгаа. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээ авдаг. Тэгэхээр тэр бүх зүйлүүд нь ялангуяа Эрүүл мэндийн даатгалын салбар дээр бол энэ жил бүр энэ нь нэмэгдээд, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээрээ явдаг болсон байгаа. Тэр 10 хувь бол суурь шүү. Суурь нь нэмэгдэж байгаа.

**Г.Занданшатар:** Төрийн албан хаагчийн бүтээмж, үр дүнг сайжруулах цогц шинэчлэлийн хөтөлбөр гээд энэ дээр коэффициент энэ тэр заачихсан байгаа. Тийм юм ерөөсөө асуултад тодорхой хариулахгүй, тойроод яваад байх юм. Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандана шүү. Чуулганд тайлбар өгөхөөс татгалзах, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчих, санаатайгаар худал мэдээлэл өгсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэл гэж үзэж тухайн этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэдгийг сануулъя. Энэ мэдээлэл гаргаж өгөхгүй дардаг, нуудаг энэ бүх юмнууд Төрийн албан хаагчид төрийн хууль дээдлэх үүрэгтэй. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулж асууна.



**С.Ганбаатар:** Хуулиа л дагадаг байх даа. Хууль дээр нийгмийн даатгалын сангаас Тэтгэврийн тухай хуульд 2024 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжинэ. Хэрэгжихдээ улирал болгон инфляцын түвшинтэй уялдуулж нэмэгдүүлнэ гэж байгаа. 8 сард нэмчихсэн, одоо хавааск гэж хэлж болох юм уу, үгүй юү би сайн ойлгохгүй байна. Ингээд төсөв дээр орж ирэхдээ бол 4 сарын 1-ний өдрөөс нэмэгдүүлэхээр танилцуулгад бичсэн байгаа юм шүү бас. Тэгэхээр тэтгэврийн нэмэгдэл 1 бүтэн улирлаар хойшилж байна, хууль хэрэгжихгүй байна гэсэн миний ойлголт авч байна. 2 дугаарт тэр төрийн албан хаагчдын цалингийн асуудал бол яг чин үнэндээ хэлэх юм бол үнийн хөөрөгдөлтэй уялдуулж л 10%, 20%-ийг нэмэгдүүлж байгаа юм. Бүтээмжтэй уялдуулж нэмэгдүүлэх төсөв төлөвлөгөө одоохондоо энэ.../минут дуусав/

**Г.Занданиатар:** Энийг албан бичгээр хариу өгье. Жамбын Батсуурь гишүүн.

**Ж.Батсуурь:** Баярлалаа. Тэгэхлээр би өнөөдөр бол Төсвийн тухай хуулийн хамт өргөн мэдүүлсэн дагасан хуулиудыг ярьж байгаа гэж ойлгож байгаа. Тэгээд ихэнх хүмүүс төсөв яриад байна. Ер нь тэгэхдээ 1 зүйлийг манай Сангийн яам, Засгийн газар дараа дараагийн юм дээр анхаармаар байна. Энэ дагасан хуулиар тухайн хуулийн бүр концепцыг өөрчлөх маягаар ийм зүйлүүд их орж ирж байна. Болилоо, тэглээ, ингэлээ гээд. Жишээлэх юм бол 2 хуулийн заалт хоорондоо утга төгөлдөр биш эсрэг. Жишээлэх юм бол орон нутагт боловсон хүчнээр хангах, төрийн захиргааны албан хаагчид дутагдалтай байгаа учраас түүнийг ажилласан жилийг нь нэмэгдүүлж тооцъё гээд 1 дүгээр заалтад байж байж, хөдөө орон нутагт хамгийн их дутагдалтай байдаг. Нягтлан бодогчийг төрийн захиргааны албан хаагч болгоё гээд дараагийн заалтаар орж ирж байгаа байхгүй юу. Тэр чинь нэг бодлоор хөдөө төрийн захиргааны албан хаагч

нар дутагдалтай байна. Энэ хүмүүсийг дэмжье гэж 1 дүгээр заалтаараа оруулж ирээд, тэр нь өөрөө бас Үндсэн хууль зөрчиж орж ирж байна. Орон нутагт 4, 5 жил ажилласан хүн бол 4, 5 жилээрээ Улаанбаатараас очиж ажиллах юм бол 1,5, 1,6-аар үрчих юм гэнэ. Гэтэл дараагийн заалт дээрээ болонгуут төсвийн байгууллагын нягтлан бодогч нарыг төрийн захиргааны албанд оруулъя гэж байгаа юм. Дутагдалтай байгаа юм бол харин үйлчилгээнийх нь илүү байх ёстой юм биш үү. Тэгээд энэ энэ дагасан хуулиудыг хараад байхад дандаа л дарга анги руу ингэж дээшээ дэвшсэн албан тушаал, цалин, онд нь багтаад цалингийн үлдэгдлийг урсгал зардлын өдрүүдийг хуваарилах ийм зүйлүүдийг дагасан хуулиар орж ирүүлээд байх юм. Энийг л болимоор байна. Засгийн газрын нэгдсэн бодлоготоо салбарын яамнууд нь зангидагдахгүй байна. Жишээлэх юм бол уул уурхайн бүтээгдэхүүнүүдийг заавал биржээр худалдах ёстой гээд саяхан шийд гарч байсан. Одоо эргээд энийгээ заавал биржээр арилжаалахгүй байх ёстой гээд. Ингээд орон гаран хуулиуд. Сүүлдээ бүр гаран гаран ч хууль болж байгаа юм байна. Ийм байдлаар асуудалд хандахаар дагасан хуулиар энэ бүр хуулийн концепц бий. Жишээлэх юм бол Газрын хууль. Газрын хууль орж ирэхэд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр нутгийн захиргааны байгууллагын явуулдаг тэр эрх мэдлүүдийг бүгдийг татаж авах хэмжээний ийм концепцын өөрчлөлт оруулж ирж байх жишээний байна шүү дээ. Ийм байдлаар 21 хууль, 7 тогтоол оруулж ирж бүх хуулиудыг сэглэж байна. Энэ тал дээрээ анхаараач ээ л гэж хэлэх гэж байгаа юм. Яах вэ төсөв бол ирэх 7 хоногт хэлэлцэх байх. Тэгээд зарим дээр Үнэт цаасны тухай хууль, бусад хуулиуд дээр цахим болгоё, цахим биш болгоё гээд л ингээд хуульчлаад байгаа байхгүй юу. Тэгээд ямрыг нь цахим, ямрыг нь цахим биш болгох гээд байгаа юм. Цахим үндэстэн гээд зарлачихсан шүү дээ Засгийн газар чинь. Тэгээд цахим үндэстэн юм бол явах

ёстой. Гэтэл зарим хуулиуд дээр болонгуут цахим санал ирсэн. Энэ хуулийг өөрчилье гээд байгаа байхгүй юу. Тэгвэл авлигатай тэмцэх хууль, Авлигатай тэмцэх үйл ажиллагаа, түгжрэл энэ дээр чинь Монголын ард түмэн цахимаар 7 жил саналаа илэрхийлж байна шүү дээ. 7 жил саналаа илэрхийлж байна шүү дээ. Дорвитой өөрчлөлт гарч байгаа зүйл байхгүй. Сая Ганхуяг гишүүн хэлж байна. Дунд шатын авлигал бүр гаарлаа гэж байна. Дээд цэгтээ хүрчихсэн. Олон улсын түвшин, дэлхийн түвшинд тэр ухарчихсан. Ингэхэд цахимаар Монголын ард түмэн өглөө босоод л энэ авлигын эсрэг, түгжрэлийн эсрэг саналаа илэрхийлээд л байгаа шүү дээ. Гэтэл гэнэт заримыг нь болонгуут 100 мянга хүрчихлээ, одоо хэлэлцье гээд. Улаан гэрэл асчхаад байхад ч.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Болдын Жавхлан сайд хариулъя. Төсөв дагуулж оруулж ирдэг гэдэг асуудал ярьж байна л даа. Энэ анхдагч суурь органик хуулиудыг ер нь энэ хуулиудыг хэлэлцүүлж Хууль тогтоомжийн хуулийн шаардлага хангагдаж байж хэлэлцүүлдэг номтой л доо. Төсөв дагуулж орж ирээд ямар ч хэлэлцүүлэггүй нөгөө органик суурь хуулиудын бүтцийг эвдээд байна гэсэн асуулт асуугаад байна шүү дээ. Төсөвтэй ямар холбоотой болоод энэ суурь бүтцүүдийг өөрчлөөд байгаа юм бэ. Хариулт сонсчхоод болъё.

**Б.Жавхлан:** Батсуурь гишүүний асуултад хариулъя. Та тухайлан яг энэ хууль чинь өргөн барьсан төсөвтэй чинь хамаагүй байна. Энэ нь хамаагүй яваад тэгээд суурь хуулиа зөрчилдөж байна гэсэн тодорхой зүйл байвал хариулъя. Тэгэх үү. Наадах чинь бас жоохон ерөнхий юм болчихлоо.

**Г.Занданшатар:** Жамбын Батсуурь гишүүн тодруулж асууна.

**Ж.Батсуурь:** Одоо ч ганцхан минутад амжуулна. Би жишээлэх юм бол

Төрийн албаны тухай хууль дээр асууж байгаа юм. 1 дүгээр зүйлээр нь болонгуут орон нутагт ажиллаж байгаа хүмүүсийг дэмжье гэсэн мөртөө, 2 дугаар зүйл дээр нь болонгуут нягтлан бодогч нарыг төрийн захиргааны албанд шилжсүүлье ч гэдэг юм уу. Газрын тухай хууль дээр асуусан. Мөн Биржийн тухай хууль дээр асуусан. Саяхан л бүх асуудлуудыг биржээр орж байхгүй бол болохгүй гээд хуульчилсан. Одоо биржээр биш болж байна гээд. Ингээд 1 хууль орж ирээд л нөгөөдөх нь дагасан хуулиараа зөрчилдөөд л, нэг хууль орж ирээд л ингээд орон гаран байна гэсэн талаас нь асууж байгаа юм. Тэгээд одоо асууж амжихгүй нь л дээ.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын 133 дугаар сургуулийн 6<sup>В</sup> ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Багш, сурагчдаада сурлагын өндөр амжилт хүсэн ерөөе. Сайн сурцааж сайн хүн болцгоогоорой.

Болдын Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Төрийн албаны тухай хуульд орж байгаа өөрчлөлтийг Баасандорж дарга хариулна. Биржтэй холбоотой асуултыг Ганбаатар сайд хариулна. Газрын хуультай холбоотой асуудал дээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариулна.

**Г.Занданшатар:** Жамбалын Ганбаатар сайд хариулъя.

**Ж.Ганбаатар:** Биржийн хууль дагаж орж ирсэн шалтгаан нь төмөр замын холболттой холбоотой. Тэгэхдээ Их Хурлын бүрэн эрхийн дагуу Их Хурлын шийдвэрээр ийм томоохон бүтээн байгуулалтуудыг шийдвэрлэх зүгээр ийм заалт л орж ирж байгаа. Их Хурлын бүрэн эрх шүү. Дээрээс нь зөвхөн биржийн дундаж үнээр АМНАТ-аа тооцно гэж байгаа. Энэ бол Монгол Улсад бол хохиролтой зүйл бол байхгүй л

дээ. Тэгээд энэ Их Хурлын бүрэн эрхийн л асуудал байгаа. Их Хурал шийдэх юм уу, шийдэхгүй юм уу. Их Хурал ийм төмөр замын холболтыг ийм аргаар шийдвэрлэе гэвэл, түүнээс биш Засгийн газар гэдэг юм уу, өөр замаар шийдвэрлэх ямар нэгэн боломж байхгүй. Ингэж засагдсан байгаа гэдгийг хэлье. Харин тэгж байсныг нь засаад янзалчихсан байгаа гэдгийг хэлье. Өөр ойлголт. Гэхдээ бол санаа нь бол яг адилхан байсан. Тэгээд өөрөөр ойлгогдоод байсан гээд.../минут дуусав/

### **Г.Занданшатар:**

Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууна.

**Ж.Чинбүрэн:** Гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Надад 2 асуулт байна. Дагалдах хуультай холбоотой Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар энэ дээр Төсвийн байнгын хороо дэмжсэн санал дээр 50 сая төгрөгөөс хэтрээгүй нөхцөлд тухайн “хувь хүний” гэсний “хувь хүн” гэж. Тэгэхээр эдийн засгийн инфляцтай холбоотой энэ эдийн засгийн тоон өсөлттэй холбоотой 50 сая гэдэг төгрөгийг нэмэх боломжийн талаар Байнгын хороон дээр ярилцсан уу, хэлэлцсэн үү. Энэ 50 сая гэдэг тоог ер нь нэмэх боломж бий юу. Энд хариулж өгөөч ээ.

2 дахь асуулт нь бол энэ Төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн тал дээр нэг санал хэлмээр байгаа юм. Тухайлах юм бол бид энэ 2020 оны эрүүл мэндийн салбарын том шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэлийн санхүүжилтэд ороод мөн энэ гүйцэтгэлийн санхүүжилтээс улбаатай бид бас стратегийн худалдан авалт хийх ийм боломжийг хууль, эрх зүйн орчинд нь бий болгоод өгчихсөн. Тэгтэл өнөөдөр бид Монголдоо эмчилж чадахгүй байгаа хүүхдүүдийн өвчнийг гадаадад

эмчлүүлээд ирэхэд нь бүрэн даах боломж энэ гүйцэтгэлийн санхүүжилт дотор бол стратегийн худалдан авалтаар хийх, дээр нь ямар нэгэн төсөв мөнгө нэмэхгүйгээр хийх боломж байгаад байгаа юм. Тухайлах юм бол бид энэ Новардис гэдэг компанитай сарын 1 долларын оригинал бүтээгдэхүүнүүд авдаг болсонтой холбогдуулан зөвхөн Эрүүл мэндийн даатгалын санд 9 тэрбум төгрөгийн хөнгөлөлт бий болсон. Хэмнэлт бий болсон. Тухайлах юм бол оригинал чанартай бүтээгдэхүүнийг сарын хэрэглээний 1 доллар, дээр нь логистик, тараалтын зардлаа нэмээд, тэгээд нийтдээ 9 тэрбум төгрөг хэмнэчихсэн байх жишээтэй. Тэгэхээр ийм боломжууд байж байна. Энэ боломжоор хэмнэгдсэн мөнгөө бид бас энэ хүүхдийн өвчнийг гадаадад эмчлүүлсэн тохиолдол бүрэн даах, тэгэхдээ энэ бол Монголд эмчилж чадахгүй гэсэн тохиолдол шүү дээ. Бүх өвчин биш. Ийм боломж бол байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр бид энэ Засгийн газрын чиглэл өгөх тогтоол дотроо Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс энэ магадлах хороо байгуулаад, Монголдоо эмчилж чадахгүй байгаа тэр өвчнүүдийг гадаадад эмчлүүлсэн тохиолдол бүрэн даахад ер нь 10 тэрбум төгрөгөөс хэтрэхгүй жилийн ийм зардал байх гээд байгаа. Тэгээд энийг ажил хэрэг болгох чиглэлд зөндөө олон удаа ярилаа. Тэгэхээр бид бүр энэ тогтоолоор дамжуулж, энийг хий гэдэг үүрэг, чиглэлийг өгмөөр санагдаад байгаа юм. Энэ дээр бас та бүгдийн байр суурийг бас сонсмоор байх юм. Энэ дээр хариулт авъя.

**Г.Занданшатар:** Болдын Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Чинбүрэн гишүүний асуултад хариулъя. Тэр таны ярьж байгаа тэр 50 сая төгрөгийн босго яг таны хэлж байгаагаар өөрчлөгдөж байгаа шүү. Босгогүй болж байгаа. 1 сарын 1-ээс хялбаршуулаад. Тэгэхээр энэ бол иргэдэд татварын орчинд нэлээн

тийм хялбаршуулсан шинэ горим руу орж байна гэсэн үг. Баасандорж дарга аа, тэр Төрийн албаны хуультай холбоотой юман дээр та нар хариулж болохгүй байгаа юм уу. Бодлогоо оруулж ирчхээд тэрийгээ сайхан тайлбарлаад өгчих л дөө.

Тэгээд эрүүл мэндтэй холбоотой асуудлыг Чинзориг сайд хариулсан нь дээр байх.

**Г.Занданшатар:** Сайд нар орж ирэхгүй бол чуулган завсарлууллаа. Чинзориг сайд хаачсан юм. Содномын Чинзориг сайд, Сандагийн Бямбацогт сайд суудалдаа сууя. Асуултад хариулах хүмүүс байхгүй байна шүү дээ. Болдын Жавхлан сайд хариул. Төсөвтөө л орж ирсэн юм чинь та л хариулна. Болдын Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Чинбүрэн гишүүний асуулт нь бол эрүүл мэндийн салбарын бодлогын асуудал асуусан шүү. Төсөвт...

**Г.Занданшатар:** Тэгээд салбарын бодлогын асуудлыг төсөвт яах гэж оруулж ирсэн юм. Сангийн сайд л оруулж ирж байгаа шүү дээ. Хууль зүйн сайд 2. Тэгээд мэдэхгүй суугаад байх юм. Барсүрэнгийн Баасандорж 92 хариулчихъя. Чинзориг сайдыг дууд.

**Б.Баасандорж:** Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Баасандорж. Гишүүний асуусан асуултад хариулъя. Түрүүн бас Батсуурь гишүүн Төрийн албаны тухай хуулийн өөрчлөлттэй холбоотой асуусан. Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.9 дэх хэсгийг нэмэх хуулийн төслийг Төсвийн тухай хууль дагалдуулж өргөн мэдүүлсэн байгаа. Улаанбаатар хотоос тухайн орон нутагт иргэний иилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгэж, тухайн төрийн захиргааны албан тушаалдаа тухайн иргэн маань 3-аас доошгүй жил ажиллах юм бол өөрөөр хэлбэл алслагдсан бүсэд ажиллах юм бол 1 жил ажилласан хугацааг нь 1 жил 3 сараар,

аймгийн төвөөс бусад сум, тосгонд 1 жил ажилласан хугацааг нь 1,6 жил буюу 1 жил 6 сараар тус тус дүйцүүлэн тооцож болно гэдэг зохицуулалтыг оруулж өгсөн юм. Энэ нь яг өөрөөр хэлбэл хөдөө орон нутагт бол Сүхбаатар аймаг гэдэг юм уу ер нь орон нутгуудад нь төрийн албан хаагчийн хомсдол нэлээн байгаа. Тэгэхээр энэ байдлыг 1-д шийдэх.

2-т нь төвлөрлийг сааруулах. Хот, хөдөөгийн сэргэлтийн үндэсний хорооноос энэ санал маань гараад ер нь энэ Улаанбаатар хоттойгоо төвлөрч байгаа төвлөрлийг сааруулах үүднээс мөн энэ хуулийн зохицуулалт батлагдах юм тодорхой түвшинд дэмжлэг үзүүлэх болов уу гэдэг үүднээс энэ зохицуулалтыг оруулж өгсөн.

Мөн төрийн албаны тухай хуулийн 57.18 дахь хэсгийг нэмсэн байгаа. Энэ нь төсвийн байгууллагын нягтлан бодогчийн албан тушаалын ангилал зэрэглэлийг тухайн салбарын төрийн албан хаагчийн албан тушаалын ангилал зэрэглэлтэй адил байхаар тогтоож болно гэж. Өөрөөр хэлбэл тухайн төрийн байгууллагад ажиллаж байгаа нягтлан маань ТҮ дээр ажиллаж байгаад төрийн захиргааны албан тушаалынхаа шаардлага юмыг хангаж байгаа бол ТҮ-ээр ажиллуулахдаа төрийн захиргааны ангилал зэрэглэлтэй адилтгаж үзээд цалинг нь тогтоож болох боломж нь болно гэдгээр нээж өгч байгаа юм. Тухайн төрийн албан хаагч томилох эрх бүхий албан тушаалтан маань энэ шийдвэрийг гаргахаар. Гэхдээ ажлын хэсгээс Төсвийн хуулийн ажлын хэсгээс Төрийн албаны тухай хуулийн 23.9, 23.10, 57.18-ыг хасах санал чуулганы нэгдсэн хуралдаанд гишүүдэд танилцуулж байгаа.

Мөн саяын нөгөө 57.18-тай холбоотой бас саналуудыг ажлын хэсгээс оруулж байгаа. Хасагдаж байгаа. 57.18 мөн адил.

**Г.Занданшатар:** Содномын Чинзориг сайд хаагуур яваад байдаг юм бэ. Төсөв хэлэлцэж байхад, Төсвийн дагасан хуулиуд хэлэлцэж байхад, танайхтай холбоотой хуулиуд байна шүү дээ. Содномын Чинзориг сайд хариулъя. Асуултаа ойлгосон уу.

**С.Чинзориг:** Чинбүрэн гишүүний асуултад хариулъя. Ер нь бол дотооддоо оношилж эмчилж чадахгүй байгаа 26 төрлийн өвчин байна гэсэн ийм Эрүүл мэндийн сайдын тушаал байдаг юм байна лээ. Энэтэй холбоотойгоор бид нар энэ 2024 оны улсын төсөв дээр бас жаахан бодлогын өөрчлөлт хийгээд юм оруулж байгаа юмнууд бол байгаа. Ирэх 7 хоногоос хэлэлцэх болов уу. Уг нь гишүүд түрүүн хэлэлцээд өгчихвөл сайн байна. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах асуудал Их Хуралд өргөн барьчихсан байгаа. Тэр хуульд өөрчлөлт оруулаад бид нар Эрүүл мэндээ дэмжих сангийн хөрөнгийг зөвхөн нийгмийн эрүүл мэндийн асуудалд зарцуулж байгааг эмнэлгийн тусламж үйлчилгээнд бас зарцуулдаг болгоё гээд хамрах хүрээг нь жаахан өргөжүүлж өгөхөөр орж байгаа юм. Одоо бол энэ санд архи, тамхины онцгой татвар 1-2 хувь, эмийн татварын НӨАТ-ын татварын бас 1-2, 2 хувиар бас дэмжих сан бүрдүүлж байх юм. Яг энэ гүйцэтгэлээр аваад үзвэл 10-12 тэрбум төгрөг жилд төвлөрөх ёстойгоос одоогоор бол 2023 онд гэхэд зөвхөн 2 тэрбум төгрөг өгөөд л нийгмийн эрүүл мэндэд зарцуулж байна. Одоо төсөв дээр бид нар Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг ирэх жил 10 тэрбум төгрөг болгож энэ жилийнхээс 5 дахин нэмэгдүүлж төсөвт бол тусгаж өгсөн. Энэ сангийн тухай хуульд өөрчлөлт оруулснаар бид нар тэр дотооддоо оношилж эмчилж чадахгүй байгаа технологи нэвтрүүлэх зардлыг нь энэ сангаас бас санхүүжүүлж өгдөг болъё.

2 дугаарт асуудал дотоод оношилж эмчилж чадахгүй байгаа өвчний улмаас зайлиггүй шаардлагаар

гадаад улс орнуудад эмчилгээнд явж байгаа иргэдэд санхүүгийн төлбөрийнх нь 5 хувийг өгч байгаа, энийг нэмэгдүүлье. Би тантай санал нэг байна. Хүүхдийн зардлыг бас илүү хувиар энэ сангаас нөхөж олгодог байх ийм зохицуулалт оруулахаар төсөвт бол 10 тэрбум төгрөг тусгасан. 2 дугаарт тэр Тусгай сангийн тухай хуулийг Их Хуралд өргөн барьчихсан байгаа. Энэ хуулийг төсвийг дагалдуулаад батлаад өгчих юм бол энэ 2 асуудал нэлээн бас нааштай өөрчлөлт гарах болов уу гэж бид төсөөлж төлөвлөөд байгаа юм.

### **Г.Занданшатар:**

Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн тодруулж асууна.

**Ж.Чинбүрэн:** Тэгэхээр миний хэлэх гээд байгаа санаа бол бид бас энэ стратегийн худалдан авалтын бодлогоо энэ хуульд оруулсан зүйлээ ашигламаар байгаа байхгүй юу. Тэгэхлээр Эрүүл мэндийн даатгалын санд хэмнэлтүүд бий болж байна. Хөнгөлөлттэй оригинал бүтээгдэхүүнийг авснаар зөвхөн даатгалын санд эмийн үнэ дээр 9 тэрбум төгрөг хэмнэгдэж чадаж байна. Тийм учраас бид энэ Монголдоо эмчилж чадахгүй байгаа хүүхдийн өвчнийг бол төр даах тусламж үйлчилгээнд хамаараад байгаа шүү дээ. Бид заавал даах ёстой. Тийм учраас одоо та бол Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даргын хувьд бол энийг Таатгалын үндэсний зөвлөлийнхөө шийдвэрээр энийг бол хийчих боломжтой. Дээрээс нь зарим нэг санхүүжилтийн асуудлыг бол зохицуулах үнийг нь тарифыг зохицуулснаар энийг бол шийдэх боломж байгаад байгаа. Харин тантай санал нэг байна. Энэ тусгай сангуудаар бол бид харин нөгөө эмчилж чадахгүй байгаа эмч, эмнэлгийн байгууллагуудаа сургах асуудал дээр нь илүү анхаараасай гэж хүсэж байна.

### **Г.Занданшатар:**

Содномын Чинзориг сайд хариулъя.

**С.Чинзориг:** Төсөв батлагдчихлаар бид нар зайлшгүй гүйцэтгэлийнхээ санхүүжилтийнхээ аргын тарифтаа өөрчлөлт оруулж тохируулга хийнэ. Цалин нэмэгдэж байгаа, орон нутгийн нэмэгдэл нэмэгдэж байгаа, дээр нь орон нутгийн нэгдсэн эмнэлгүүдийн байр ашиглалт үйлчилгээний тогтмол зардлыг бас шийдэх гээд ийм асуудлууд бол байгаа. Тэр тарифын өөрчлөлт хийхдээ бид нар таны яриад байгаа тэр хүүхэдтэй холбоотой асуудлыг бол авч үзье. Гэхдээ миний бодол бол Тусгай сангийнхаа хуульд өөрчлөлт оруулаад тэндээ тэр технологи нэвтрүүлэх чадавх бэхжүүлэх технологи нэвтрүүлэх зардлыг эрүүл мэндийн байгууллагууд өөрсдөө хариуц гэхээр бас санхүүгийн боломжид хүрэхгүй байгаа тэрийг нь шийдэж өгье. Дээр нь тэр гадаадад эмчилгээ зайлшгүй яваад ирж байгаа иргэдийн санхүүжилтийг 5 хувь өгдгийг бас ахиулья. Би бодохдоо хүүхдийг илүү хувиар төлбөрийг нь даадаг баахан зүйтэй гэсэн ийм байр суурьтай бол байгаа.

**Г.Занданшатар:** Бадарчийн Жаргалмаа гишүүн асуулт асууна.

**Б.Жаргалмаа:** Та бүхний өглөөний амгаланг айлтгая. 2 асуулт байна. Энэ дагасан хууль дээр. Яг өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотын хэмжээнд нийтдээ хүн амын 48,6% нь буюу 200 мянга гаруй өрх гэр хороололд амьдарч байгаа. Үүнээс 163,742 яндан байна гэсэн ийм тоон мэдээлэл байдаг. Улаанбаатар хотын агаар хөрсний бохирдлын 80 хувь нь гэр хорооллын хашаа байшин, гэр хорооллоос шалтгаалсан гэдгийг мэргэжлийн байгууллагууд тогтоосон байдаг. Тэгвэл энэ гэр хорооллыг орон сууцжуулах, яндангийн тоог цөөлөх тал дээр ер нь гол авч хэрэгжүүлж байгаа бодлогыг би ипотекийн зээл гэж бодож байгаа. Яг өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотод борлуулагдаад Улсын комисс хүлээгээд авчихсан 7096 орон сууц байна гэсэн ийм мэдээлэл

байдаг юм байна. Гэтэл өнөөдөр орж ирж байгаа энэ хууль дээр орон сууцны ипотекийн зээлийн 60 хувийг хөдөө, орон нутгийн иргэдийг орон сууцжуулах хөтөлбөрт хуваарилах гээд шууд хувь заагаад өгчихсөн байгаа. Орон нутгийн гишүүд маань бол энийг дэмжиж байгаа нь ойлгомжтой. Гэхдээ Улаанбаатар хотод Монгол Улсын нийт хүн амын талаас илүү хувь нь буюу 1,7 сая иргэн амьдарч байгаа. Энэ эрүүл аюулгүй орчинд амьдрах гэдэг Үндсэн хуулийн гол заалт нь өнөөдөр биелэгдэхгүй байгаа. Өдөр болгон хэр үнэртэж байгааг та бүхэн сайн мэдэж байгаа. Бид нар Төв цэвэрлэх байгууламжийнхаа ажлыг дуусгаагүй байгаа. Гэтэл ипотекийн зээлийн 80 хувь гээд хэлчихээр гэр хорооллын яндангийн тоо буурах боломж ер нь хэр байгаа вэ гэдэг дээр би мэргэжлийн байгууллагуудаас, Барилга, хот байгуулалтын яамнаас асууя. Ер нь энэ дээр ямар бодлогоор ийм тоо тавьж өгч байгаа юм бол. Мэдээж хэрэг ипотекийн зээлийг бид бас 6 хувьд хүргэх, орон нутагт 100 саяын зээл байсныг 150 болгох, Улаанбаатар хотод 150 байсныг 200 болгох гэдэг нааштай шийдвэрүүд гаргаж байгаа боловч ингээд хувь заагаад өгчихөөр Улаанбаатар хотын орон сууц борлогдох, эргээд нөгөө яндангийнхаа тоог бууруулах зорилтод хүрэх үү.

2 дугаарт 23.2.23-д төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил ашиглалтад байгаа газар дээр хууль бусаар баригдсан барилга объектыг төрийн өмчид хураан авах ажлыг зохион байгуулах гэсэн саналыг уг нь Раднаасэд гишүүн гаргасан юм байна. Үүнийг дэмжээгүй байна л даа. Би энэ дээр юуг хэлэхэд байна вэ гэхээр нөгөө сургуулийн газар чинь орох юм биш үү. Сургуулийн эзэмшлийн газрыг хууль бусаар хувийн компанид өгсөн энэ тэр гэдэг тоон мэдээлэл зөндөө байдаг л даа. Би сая Барилга, хот байгуулалтын яамнаас мэдээлэл авлаа. Нийтдээ 166 сургуулиас 22 сургуулийн газрын асуудал бас хөндөгдсөн байдаг юм байна. Үүнээс орон сууц барьчихсан 8 нэгж талбар

байна гэж байна. Бид нар сургуулийн хүүхдийнхээ нөгөө сурч боловсрох боломжийг хаагаад байгаа маргаантай асуудлууд маш их байдаг гэдэг. Тэгвэл энэ асуудлыг яагаад дэмжихгүй ингээд орхигдуулчихав гэдэг энэ 2 асуултад хариулт аваад, дараагийнхаа асуултыг асууя гэж бодож байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Болдын Жавхлан сайд , Цэрэнпилийн Даваасүрэн сайд хариулъя.

**Ц.Даваасүрэн:** Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Ер нь Улаанбаатарт үүсээд байгаа асуудал маань бол хэт төвлөрөлтэй холбоотой л гэж бас үзэх үндэслэлтэй. Яагаад гэвэл агаарын бохирдол, замын түгжрэлийн асуудал бол бас шууд Улаанбаатарт хэт их хүн ам төвлөрсөнтэй холбоотой. Нөгөө талаар энэ асар том эрсдэл. Хүн амынхаа талыг нэг жижижсэн газар бөөгнөрүүлчхээд газар хөдлөлт болбол, онц халдварт гамшигт өвчлөл гарвал яах вэ гэдэг ийм том эрсдэлүүдийг бол бид нар бодох ийм цаг болсон. Маш хүчтэй газар хөдлөлт явбал хүн амынхаа талыг эрсдэлд оруулж болохгүй. Тийм учраас тэр Хархорины бүтээн байгуулалт мөн ингээд хөдөө, орон нутагт ипотекийн зээлийг нэмэгдүүлэх хөдөө, орон нутагт боловсон хүчний дутагдалтай байгаа учраас тийшээ төрийн албан хаагчид шилжих энэ бололцоог хангах үүднээс орлогын асуудлыг нь шийдье. Орон байр хангамжийн асуудлыг нь шийдье гэдэг агуулгаар Засгийн газраас тодорхой бодлого гаргаж, 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаагийн нэг нь ипотекийн зээлийн 60 хувийг хөдөө олгодог болъё гэж. Энэ шинээр их, дээд сургууль төгсөж байгаа амьдралаа эхлэх гэж байгаа залуучуудад боломж олгоё гэж хөдөө амьдрах. Хөдөөгөө бид нар орхиж болохгүй байна. Тийм учраас хөдөөгийн иргэд тэнд аятай тухтай амьдрах орлоготой байх энэ бололцоог хангаж байж, бид нар өнөөдөр энэ том эрсдэлээс аврагдана.

Гуравхан сая хүнтэй, нөхөн үржихүй муутай ийм орон нэг газар ингэж бөөнөөрөө хэт төвлөрч болохгүй. Энэ бол маш аюултай. Сирид болдог шиг газар хөдлөлт болох юм бол бид нар чинь хүн амынхаа талыг эрсдэлд оруулах гээд байна шүү дээ. Тэгэхээр энэ бол нэг тийм тойргийн асуудал бол биш болсон. Улс орны хэмжээний үндэсний аюулгүй байдлын асуудал болсон гэдгийг иргэд маань ч ойлгох байх гэж би бодож байгаа юм. Тийм учраас хөдөө рүү шилжүүлэх, хөдөөд боловсон хүчний дутагдлыг шийдвэрлэх энэ чиглэлээр ипотекийн зээлийн 60 хувийг хөдөөд олгодог болъё гэж байгаа юм.

**Г.Занданшатар:** Бадарчийн Жаргалмаа гишүүн тодруулж асууя.

**Б.Жаргалмаа:** Би нэгэнт цаг өгчихсөн юм чинь асуучихъя. Ер нь орон сууцын үнэ 7,1 хувиар өсөөд байгаа гэдгийг та бүхэн сайн мэдэж байгаа байх. Хөдөөгийн хөгжлийг дэмжиж байгаа. Гэхдээ Монгол Улсын нийт хүн амын талаас илүү хувь нь амьдарч байгаа нийслэл хотынхоо энэ төвлөрлийг сааруулахад бас хөдөөгийн хөгжил нь нөлөөлж байгаа боловч яг өнөөдөр амьдарч байгаа иргэдийнхээ эрүүл аюулгүй байдал дээр бид нар бас анхаарах ёстой. Та ч гэсэн энэ утаагаар амьдарч, амьсгалж байгаа гэдгийг хэлье. Нөгөөтээгүүр ипотекийн зээл борлуулагдаагүй орон сууцынхаа балансыг барих гэдэг юм уу энэ дээр тодорхой хэмжээний зохицуулалт хийх шаардлага байгаа шүү гэдгийг бас хэлэхийг хүссэн юм. Ер нь бол тэр сургуулийн барилгын асуудал дээр би хариулт авъя. Сургуулийн хүүхдүүд чинь гадаа биеийн тамирын талбайгүй, орчингүй, ногоон байгууламжгүй болоод шавааралдуулаад байгаа энэ бол төлөвлөлт шүү дээ Даваасүрэн сайд аа. Энэ төлөвлөлтийнхөө асуудлыг ер нь яаж шийдвэрлэж байгаа юм бэ. Энэ дээр хариулт өгөх үү.

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ. Болдын Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Та ингээж асуусан шүү дээ. Раднаасэд гишүүний өчигдөр Төсвийн байнгын хороон дээр гаргасан санал яагаад дэмжигдээгүй вэ гэж асуусан. Тэгэхээр дэмжээгүй гишүүд нь эсвэл Төсвийн байнгын хороо дээрээс энийг асуух нь хариулах нь зөв байх. Би мэдэх юм алга.

**Г.Занданшатар:** Мэдэх юм алга гэнэ ээ. Мэддэг хүн байна уу тэгээд. 88.

**А.Энхманлай:** Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга Энхманлай. 2002 онд Засгийн газраас төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудын газрын бүртгэлийг хийж, судалгаа гаргасан байгаа. Тэгээд энэ судалгаагаар бол нийтдээ Монгол Улсын хэмжээнд 19.325 нэгж талбар дээр төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагууд 80 мянган га газрыг бол эзэмшиж байна гэсэн ийм судалгаа гарсан. Энэ судалгаан дээрээ үндэслээд бид бүхэн бол нийслэлийн хэмжээнд сургууль, цэцэрлэг, эмнэлгийн газрууд дээр бас шалгалт хийсэн байгаа. Ингээд нийслэл дээр бол 166 ерөнхий боловсролын сургууль, 283 цэцэрлэг, 49 эрүүл мэндийн байгууллагууд газар ашиглаж байна гэсэн ийм судалгаа байгаагаас 22 ерөнхий боловсролын сургууль дээр газрын хэмжээнд бол өөрчлөлт орсон. 6 цэцэрлэг.../минут дуусав/

**Г.Занданшатар:** 88 гүйцээгээд хариулчих. 88.

**А.Энхманлай:** 9 эрүүл мэндийн байгууллага дээр газрын хэмжээ бол өөрчлөгдсөн гэсэн ийм судалгаа гарсан байгаа юм. Тэгээд сая Төсвийн байнгын хорооны хурал дээр бол Раднаасэд гишүүнээс энэ саяын ярьсан төрийн өмчөөс хувийн хэвшил рүү олгогдсон,

орон сууц баригдсан, одоо баригдаж байгаа газруудыг буцааж төрд шилжүүлэх энэ үүргийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын бүрэн эрх дээр оруулж өгөөч гэсэн ийм санал гаргасан. Гэхдээ энд бол бас хүний өмч хөрөнгө байгаа 1 дүгээрт хамгийн гол нь шийдвэр гаргасан этгээд бол орон нутгийн удирдлагууд Засаг дарга нар байгаа. Тийм учраас бол шийдвэрээ хүчингүй болгоод хуульд нийцүүлээд мөн шийдвэртэй холбоотой шүүхийн маргаан үүсэж шийдэгдсэний дараа газар бол төрийн өмчид шилжих бүрэн бололцоотой. Дээрх үл хөдлөх хөрөнгийн асуудлыг бол шүүхийн журмаар бол шийдэх ийм бололцоотой учраас энэ асуудлыг бол дэмжээгүй гэж ийм шийдвэр гарсан.

**Г.Занданшатар:** Нийслэл чинь энэ сургуулийн орчмын газар, энэ тэрийг сургууль, цэцэрлэг нийтийн эзэмшлийн газарт ав авна шийдвэр гаргая гээд гаргачхаагүй билүү энэ чинь. Зочид танилцуулъя.

Нийслэлийн ерөнхий боловсролын 106 дугаар сургуулийн 6<sup>с</sup> ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байна. Хүндэт сурагчид та бүхэндээ сайн сайхныг хүсэн ерөөе. Гишүүдийн нэрийн өмнөөс.

Тэгээд сургууль, цэцэрлэгийнх нь асуудлыг шийдээрэй гэж. Яагаад энийг дэмждэггүй юм. Нанзадын Наранбаатар гишүүн.

**Н.Наранбаатар:** Төсөв дагасан Улсын Их Хурлын тогтоолоор 2024 оныг хот хөдөөгийн сэргэлтийг дэмжих жил болгон зарлаж, бас төвлөрлийг сааруулах орон нутгийн хөгжлийг дэмжих, тэнд ажиллаж байгаа төрийн албан хаагчдыг дэмжих аж ахуйн нэгжүүдийг дэмжих чиглэлээр бас олон сайхан заалтууд арга хэмжээнүүд авахаар төсөвт орж ирж байгаа. Түүний нэг нь бол энэ төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад, аймгийн төвд шилжиж очиж



ажиллаж байгаа төрийн албан хаагчдыг 1,1 жил 6 сартай адилтгана, сумд болохоор 1 жил 3 сараар гээд ингээд ажилласан жилийг бол дүйцүүлэхээр оруулж ирсэн байгаа. Тэгэхдээ энэ дээр бас ялгаа гарч ирээд байна. Орон нутаг руу зөвхөн Улаанбаатараас шилжиж очиж ажиллаж байгаа хүмүүст нь энэ ажилласан жилийг нь дүйцүүлж 1 жил 6 сар болгоод, тэндээ одоо ажиллаж байгаа хүмүүсийн хувьд нь хуучнаар нь байлгахаар энэ заалт дээр Төрийн албаны тухай хуулийн 23.9 дээр орж ирсэн байгаа. Тэгээд яг нэг ижил ажил орон нутагт хийж байгаа. Төрийн албан хаагчдыг бас ялгасан ийм заалт болчихож байгаа юм биш үү. Энэ нөгөө Үндсэн хуулиар бас ижил тэгш эрхтэй байх зарчим алдагдаж байгаа юм биш үү гэсэн нэг ийм асуулт байна. Тэгэхээр энэ ажлын хэсгээс санал орж ирээд санал хураалгах юм байна. Тэгээд энэ заалтыг хасахаар орж ирж байгаа. Энэ нь нөгөө 2024 оныг Хот, хөдөөгийн хөгжлийг дэмжих жил болгосонтойгоо бас зөрчилдөж байгаа юм биш үү гэсэн ийм асуулт байна.

2-т нь тэр төрийн албаны хууль дээр 57.18 дээр нөгөө нягтлан бодогчдын зэрэглэлийг тухайн салбарын төрийн албан хаагчийн албан тушаалын ангилал зэрэглэлтэй адил байхаар тогтоож болно гэсэн ийм бас аятайхан заалт орж ирж байсан. Тэгээд бас ажлын хэсгээс санал гаргаад хасахаар болчихсон байх юм. Тэгээд энэ 2 дээр хариулт авъя. Ямар учраас хасаж байгаа юм. Ямар учраас Төрийн албан хаагчдыг бас ингээд хооронд нь ялгаж байгаа юм бэ гэсэн ийм асуулт байна.

**Г.Занданшатар:** Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн. Ажлын хэсэг хариулъя.

**Д.Тогтохсүрэн:** Төрийн албаны хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг Засгийн газраас өргөн барьсан. Хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх үед Их Хурлын гишүүд энэ хуулийн төсөлтэй

холбогдуулаад байр сууриа илэрхийлсэн. Төрийн байгуулалтын байнгын хороо дээр энэ асуудал яригдсан юм байна лээ. Ингээж үзээд ажлын хэсэг юу гэж үзсэн гэхээр зэрэг 23.9 дэх заалтыг хасъя гэдэг ийм санал оруулаад Байнгын хороо дэмжсэн байгаа.

Ямар шалтгаанаар гэвэл сумд ажиллаж байгаа төрийн албан хаагчдыг ингээж ялгаварлаж бол болохгүй юм. 1 ижил нөхцөлд ажиллаж байгаа хүмүүсийг нэгийг нь 1 жилээр, нэгийг нь 1 жил 6 сараар ингээж ялгаварлаж болохгүй ээ. Тийм учраас бол энэ 23.9 дэх заалтыг хасъя. Харин Засгийн газраас орж ирсэн тэр 2 төслийг бол дэмжиж байгаа. Тэр сумд ажиллах нөхцөлийг л бүрдүүлэх ёстой. Жишээлбэл юу гэдэг юм ажлын байраар хангах, ажлын байранд ороход нь тавигддаг шаардлагыг бууруулах, орон сууцын хангамжийг нь сайжруулах чиглэлд анхаарах, цалин хөлсийг нь нэмэгдүүлэх ийм л арга хэмжээнүүд авах ёстой болохоос биш ажилласан жилээр нь ингээж арга хэмжээ авах нь бол хэт ялгавартай байдлыг цаашидаа орон нутагт бий болгох юм байна. Дээр нь орон нутгийн албан хаагч хуурамч байдлаар хотын иргэн болж буцаж очих ийм сөрөг үр дагаврууд бас бий болох юм байна гэж ажлын хэсэг дээр ярилцаад 23.9, 23.10 дахь заалтыг хасах нь зөв юм байна гэж үзсэн юм. 57.18 дахь заалт буюу тэр нягтлан бодогчдын албан тушаалын ангилал зэрэглэлтэй холбоотой асуудлыг мөн хасах ийм санал оруулаад Байнгын хороо дэмжсэн. Учир нь юу байна вэ гэхээр Төрийн албаны зөвлөл, Засгийн газар энийг ажлын хэсэг дээр ярилцаж байгаад заавал хуульд албан тушаалыг оруулахгүйгээр журмаар шийдчихэж болох асуудал байна гэж үзсэн учраас энийг журмаар шийд гэдэг байдлаар орхиж, энэ заалтыг хуулийн төслөөс хассан ийм саналтай байгаа.

**Г.Занданшатар:** Нягтлан бодогчийг хасчихлаа гэж байна. Саяын нэмэлтээр чинь тэгээд төсөвтэйгөө

хамт шийднэ гээд бүгд орж ирж байна. Саяын нэмэлтээр чинь хорогдоогүй шүү дээ. Цалин нэмэгдэхгүй байгаа гэсэн шүү дээ нягтлан бодогч нарынх.

Нанзадын Наранбаатар гишүүн тодруулж асууя.

**Н.Наранбаатар:** Төрийн албаны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй 2 дугаар зүйл дээр төрийн захиргааны гэсний дараа үйлчилгээний болон улс төрийн гээд. Тэгээд энэ дээр төрийн тусгайг оруулчхаж болохгүй байгаа юм уу. Уг нь нээгээд өгчихвөл бас төрийн тусгай албан хаагчид орон нутагт ажиллах боломж, нийгмийн асуудал нь шийдэгдэх боловсон хүчний хангамж нэмэгдэх ийм асуудал байгаа юм. Энэ дээр ямар хариулт байна вэ.

**Г.Занданшатар:** Тогтохсүрэн дарга. Тэр хуулийн зөрчилтэй холбоотой. Наянтайн Ганибал гишүүн асуулт асууя.

**Н.Ганибал:** Ер нь зүгээр бид нар улсын төсөв хэлэлцэх болгондоо маш олон хуулиудыг өөрчилдөг энэ байдлаасаа хэзээгээр гарах вэ гэдэг асуудлыг бол би хэд хэдэн удаа тавиад байна. Тэгээд өнөөдөр бас дагалдаад орж ирсэн хууль, мөн Улсын Их Хурлын тогтоол гээд хэд хэдэн асуудалд бас өөрийнхөө байр суурийг бас илэрхийлье гэсэн юм. Ер нь Эдийн засгийн байнгын хороо дээр түрүүн бас гишүүд яриад байсан ипотекийн зээлийн асуудлыг хэлэлцсэн байгаа. Тэгээд энэ дээр бол орон сууцын ипотекийн зээлийг бол эх үүсвэрийг нь Монголбанкны Ерөнхийлөгчид даалгана гээд энэ заалтыг бол Эдийн засгийн байнгын хороон дээр санал оруулаад бол хасуулсан байгаа. Өнөөдөр бас зарчмын зөрүүтэй саналаар санал хураагдах байх. Ер нь Монгол Улсын Монголбанк маань бие даасан үйл ажиллагаа явуулахад Засгийн газар Улсын Их Хурлын тогтоолын төсөл оруулж ирэхдээ Монголбанкны асуудлыг өөрсдөөс нь асуухгүйгээр оруулаад ирж байгаа нь өөрөө бас зарчмын хувьд, логикийн хувьд

маш том алдаа гарч байгаа юм. Цаашилаад бас эргээд энэ органик хуулиуд дээр оруулж ирж байгаа өөрчлөлтүүд дээр маш олон асуудлуудыг зэрэг зэрэг хөндсөн ийм байдал анзаарагдаад байгаа юм.

Тэгэхээр энэ дээр бас тодотгоод асуух 1 хууль дээр өөрчлөлт орж ирчхээд байна л даа. Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хууль дээр өнөөдөр бас томоохон заалт ороод ирсэн байна. Энэ заалтыг бас та бүхэндээ уншиж танилцуулъя. Тэгээд энэ заалтыг Уул уурхайн сайдаас бас тодорхой асуумаар байна. Энэ дээр бол стратегийн орд эзэмшигч төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь Монгол Улсын олон улсын гэрээ эсхүл Монгол Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу уурхайн үйл ажиллагааны тасралтгүй үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор хайгуул олборлолтын ажлыг гүйцэтгэх этгээдтэй 10 хүртэл жилийн хугацаатай гэрээ байгуулах тендер шалгаруулалт зарлаж болно гэсэн энэ заалтыг оруулаад ирсэн. Ер нь энэ төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай энэ хууль маань бүр ингээд дэндүү их сэглүүллээ. Ковидын үед бол маш олон өөрчлөлтүүд орсон. Харамсалтай нь нөхцөл байдал өөрчлөгдсөн ч гэсэн тухайн хууль түүнийг дагаж мөрдөж байгаа Засгийн газар бол энэ үйл ажиллагаагаа яг тэр дагуу явуулаад байгаа юм. Ер нь бид нар энэ стратегийн орд “Эрдэнэс Тавантолгой” дээр жишээлбэл 17 их наядын оффтейк гэрээ хийчихсэн. Энэ гэрээг Төрийн болон албаны нууцад хамруулаад хийчихсэн. Одоо хүртэл учир шалтгааныг нь хэн ч тогтоодоггүй. “Эрдэнэс Тавантолгой” өнөөдөр ард иргэддээ өгөх 1072 хувьцаанаасаа ноогдол ашиг олох тухай асуудал нь 5 жилээр хойшлогдчихсон ийм асуудал байгаа юм. Одоо энд ингээд 10 жилээр гэрээ хийх энэ боломжийг Засгийн газар олж авах гэж байна хуулиараа. Тэгээд

үүний хариуцлага нь хэн үүрэх юм бэ. Хэрвээ алдаатай байвал. Энэ яагаад 10 байгаа юм, яагаад 5 биш байгаа юм, яагаад 4 биш байгаа юм, яагаад 3 биш байгаа юм бэ. Энэ уг нь маш том асуудлыг хөндсөн ийм хуулийн заалт өнөөдөр ингээд төсөв дагаад ороод ирчихсэн байгаа. Тэгэхээр энэ дээр бас ингээд энэ уул уурхайн сайдаас тодорхой асуумаар байна. Энэ яг яагаад ийм үр ашигтай байгаад энэ юм уу, эсвэл энэ асуудлыг дагаад төсөв мөнгө нэмэгдэх гээд байгаа юм уу, эсвэл зарим нэгэн компаниуд 10 жилийн хугацаатай давуу эрх олгох гээд байгаа юм уу. Энэ хийгдсэн гэрээ нь өнөөдөр хийгдэх гэж байгаа гэрээ нь өнөөдөр байгаа учраас өнөөдөр энэ хуульд өөрчлөлт орж ирж байгаа байх гэсэн ийм хардлага, хардалт төрж байна.

**Г.Занданшатар:** Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Жамбалын Ганбаатарыг дуудъя. Яагаад ингээд хэдэн минут тэвчээртэй суугаад, жилийн төсөв, түүний дагасан хуулиа хэлэлцэж байхад өөрсдийнхөө оруулсан хуулийг яриад сууж болдоггүй юм бэ. Жавхлан сайд аа, сайд нараа дууд. Гишүүдийг загнаад л байдаг юм байна лээ. Наад сайд нараа суулга л даа чи. Болдын Жавхлан сайд хариулъя. Ингээд хүлээгээд суугаад байна шүү дээ.

**Б.Жавхлан:** Ганибал гишүүний асуултад хариулъя. 7 сард Улсын Их Хурлын тогтоол гарсан байгаа. Тэр дээр маш тодорхой заалтууд орсон. Тэр дээр л уг нь гүйцээд энэ хамт орчих л байсан юм байна лээ л дээ. Тэндээс сугараад үлдчихсэн Биржсийн хууль, Төрийн худалдан авах ажиллагааны тухай хууль 2 дээр нэмж зохицуулалт орохоос өөр аргагүй болж ирж байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр Гашуунсухайт дээр бид 10-аад жил гацсан ажлыг л хөдөлгөх гээд байгаа юм. Цаад талаасаа Хятадын талын төрийн өмчийн компани төмөр замаа тавьчихсан. Бид 10 хэдэн жилийн өмнө та нар төмөр замаа тавьчих бид нар наанаас нь тавья гээд хэлээд, тэгээд бид

юу ч хийгээгүй 10 жил хүлээлгэчихсэн. Одоо бол ингээд наанаас нь би замаа аваачаад тавьчихсан хоорондоо холболт хийх шаардлагатай болж ирж байгаа юм. Үүний бүтээн байгуулалтын ажилтай л холбоотой юм байгаа юм. Цаад талын талаас бид 10-аад жилийн өмнө амласан үүргээ биелүүлэхийг шаарддаг. Ингээд ямар ч байсан Биржсийн хуульдаа өөрчлөлт оруулаад, хүсэж байгаа тэр нүүрсийг нь тэр оффтейк биш шүү, тэрэнтэй ерөөсөө ямар ч хамаагүй. Худалдаж авъя гэж байгаа нүүрсийг нь биржсийн үнээр, тэгэхдээ биржсийн бусаар, одоо бүтээн байгуулалт хийж байх хугацаа нь жил бүр 5 сая, тэрнээс хойш жил бүр 20 сая тонн нүүрс авахаар ийм шаардлага тавьж байгаа. Энэ дээр мөн Худалдан авах ажиллагааны тухай хууль дээр өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа учраас энэтэй холбоотой л ийм зөвлөлүүд юм байгаа юм. Ганбаатар сайд ороод ирлээ нэмээд хариулчихъя.

**Г.Занданшатар:** Жамбалын Ганбаатар сайд. Юундаа хэдэрлээд байгаа юм бэ. Яагаад ингээд цагтаа суудаггүй юм. Энэ сайд нар чинь хэдэрлэж байна гэж яриад байна. Жамбалын Ганбаатар сайд хариул. Наянтайн Ганибал гишүүн тодруулж асууя.

**Н.Ганибал:** Ганбаатар сайд нэмээд хариулна биз. Үгүй ээ, энэ дээр ийм юм байгаа байхгүй юу. Энэ чинь нөгөө 10 жил хүртэлх хугацаатай гэрээ байгуулах нь болохоороо бүр заачихсан. Хайгуул, олборлолтын ажлыг гүйцэтгэх этгээдтэй гээд байгаа шүү дээ. Тийм ээ. Энэ дээрээ л тодруулж асуух гээд байгаа байхгүй юу. Тэрнээс бол тэнд хийгдсэн ажлын юуг гэдэг нь бол буцааж олгох, бартер тэр оффтейк гэрээний асуудал яриагүй л дээ. Би зүгээр хайгуул олборлолтын ажлыг яагаад энэ стратегийн орд эзэмшигч аж ахуйн нэгжүүд 10 хүртэлх жилээр ямар нэгэн компанитай гэрээ байгуулах гээд байгаа юм бэ. Энэ тодорхой яригдсан асуудлууд

байгаа учраас өнөөдөр яаралтайгаар төсөв дагуулаад хууль оруулж ирж байгаа байх. Ямар яг ажил байна вэ гээд л асуугаад байгаа юм.

**Г.Занданшатар:** Жамбалын Ганбаатар сайд хариулъя.

**Ж.Ганбаатар:** Сая Сангийн сайд хариулсан. Тэр төмөр замын холболттой холбоотой асуудал л байгаа Ганибал гишүүн ээ. Энийг маш яаралтай холбож байж уул уурхайн бүтээгдэхүүнүүдийн гарц нэмэгдэнэ. Уул уурхайн салбар өөрсдөө өөрөө бол ерөнхийдөө хангалттай хэмжээгээр бүтээгдэхүүнээ экспортлох бүрэн боломжтой. Гэтэл хил, гааль, логистикийн асуудал л байгаа. Тэгэхээр энийг сайжруулахын төлөө л энийг хийж байгаа юм. Үүний үр дүнд цаашдаа оруулсан явуулж байгаа ач холбогдол өөрөө цаанаа Монгол Улсад 2, 3 жилийн дараа маш өндөр ач холбогдолтой учраас зохих хэмжээний хуулиудад өөрчлөлт оруулж байгаа. Энийг бол Засаг дээр яригдсан асуудал гэж үзэж байгаа. Зөвхөн тэр асуудал дээр л төмөр замын холболттой холбоотой асуудал дээр сая Жавхлан сайд бас хариуллаа. Тэрийг хэлье ээ.

**Г.Занданшатар:** Наянтайн Ганибал гишүүн.

**Н.Ганибал:** Үгүй ээ, би уг нь яг тодорхой л асуугаад байгаа юм л даа. Энэ хуулийг тэгвэл заавал наад асуудалтай чинь холбоотой юм бол энд заавал энэ хуулийг ингэж оруулж ирэх ямар шаардлага байгаа юм бэ. Энэ чинь хайгуул олборлолтын асуудал байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр зүгээр стратегийн ордууд гэдэг чинь зөвхөн “Эрдэнэс Тавантолгой” биш эргээд цаана нь бас Монгол Улсын стратегийн ордууд байна л даа. Энэ ордууд бас энэ боломжийг нээж өгч байгаа асуудал байхгүй юу. Тэгэхээр энд яг ямар асуудлыг шийдэх гээд энэ хууль орж ирж байгаа юм бэ л гэж асуугаад байна шүү дээ. Тэгэхээр энэ чинь нэг аливаа асуудлыг шийдэхийн тулд

шаардлагатай учраас төсөв дагуулаад яаралтайгаар энэ органик хуульд өөрчлөлт оруулж байгаа гэж ойлгоод байна шүү дээ. Тэрнээс салбарын том хууль нь энэ дээрээ олон нийтийн хэлэлцүүлгээ хийгээд энэ асуудлыг эцэслээд явбал өнөөдөр Монголын ард түмэн бүгдээрээ энийгээ мэдээд цаана нь энэ асуудлаа ойлгох ийм л боломж байх ёстой л доо.

**Г.Занданшатар:** Болдын Жавхлан сайд хариулъя. Та энэ утсаа оролдохоо больчих, хүмүүсийн яриа сонс.

**Б.Жавхлан:** Гишүүний асуултад тодруулгад нэмж мэдээлэл өгье. Тэр хил холболттой холбоотой гэдгийг бол Ганибал гишүүн ойлгож байх шиг боллоо. Энэтэй холбоотойгоор ийм зохицуулалт орж ирж байгаа юм шүү энэ Худалдан авахын тухай хууль дээр. Стратегийн орд эзэмшигч төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотой Монгол Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу үйл ажиллагааны тасралтгүй, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор хайгуул, олборлолтын ажлыг хамтад нь гүйцэтгэх этгээдтэй 10 хүртэл жилийн хугацаатай гэрээ байгуулахаар тендер зарлаж болно гэсэн ийм нэмэлт оруулж байгаа юм. Урт хугацаатай, гэрээ байгуулах нөхцөлтэй тендер шалгаруулалт зохион байгуулах шаардлага үүсэж байгаа. Энэ тендер шалгаруулалтыг зохион байгуулахад шаардлагатай хугацаагаар шинэ хуулийг сунгахаас өөр аргагүй болж байна гэсэн ийм нөхцөл байдалтай уялдаж байгаа юм.

**Г.Занданшатар:** Төмөртогоогийн Энхтүвшин гишүүн асуулт асууна.

**Т.Энхтүвшин:** Баярлалаа. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр жилээс жилд бас орон нутагт нэмэгдэж байгаа. Энд бас баярлаж байгаа. Мөн энэ

дагалдах хуулиар бас ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогыг тухайн сумд 100% олгохоор зохицуулалтыг бас тусгасан байна. Тэгээд энэ бол нэлээн зөв, зүйтэй ийм хуулийн санал болжээ гэж миний хувьд бодож байна. Ер нь цаашидаа ч гэсэн бид нар энэ Ашигт малтмалын тухай хуульдаа өөрчлөлт оруулаад Ганбаатар сайд бол сайн мэдэж байгаа. Энэ баялгийнх нь тодорхой хувийг сум, орон нутагт нь хүртдэг, иргэд нь хүртдэг ийм зарчим руу л бид нар цаашидаа бол явах ёстой юм билээ. Ер нь жилээс жилд л уул уурхайн хайгуулын ажил уул уурхайн олборлолтын ажил жилээс жилд л эсэргүүцэлтэй ард иргэдтэй нэлээн түлж байна шүү дээ. Тийм учраас цаашидаа бол энэ АМНАТ-ийг Ашигт малтмалын тухай хуульдаа өөрчлөлт оруулдаг бол 30 хүртэлх хувийг сум, орон нутагт нь өгдөг, сум, орон нутаг нь цаашидаа бие дааж хөгждөг, сум орон нутаг нь тэр нөлөөллийнхөө бүсэд байгаа айлуудыг нөхөн төлбөрийг олгодог. Сум, орон нутгаа эрүүл мэнд боловсролын салбарт бас хөрөнгө оруулалт хийдэг ийм зарчим руу явбал цаашидаа Монгол Улсад бол энэ уул уурхайн салбар ч тэр, баяжуулах боловсруулах үйлдвэр ч тэр хөгжих ийм бололцоо боломж бас байна гэдгийг хэлмээр байна. Тийм учраас энэ бол бас нэлээн оновчтой ийм санал орж иржээ гэж миний хувьд бас бодож байна. Мөн дагалдах хууль дээр төрийн албан хаагчдын орон нутагт ажиллахад тодорхой хэмжээний 5 жил тутамд 1 удаа дэмжлэг үзүүлэхээр ийм заалт орж ирсэн байж байгаа. Энэ яг 5 жилийн дэмжлэг нь 2024 ондоо олгогдоод явах уу, эсхүл 2024 оноос хойш тооцож, 2029 онд энэ дэмжлэг нь олгогдоод явах юм уу энэ дээр тодорхой бас нэг хариултыг бас хэлж өгөөч.

Мөн энэ Улаанбаатар хотоос сум, орон нутагт төрийн захиргааны байгууллагад очиж ажиллах ажилчдад 1 жилд нь сумд ажиллах юм бол 1 жилийг 1,6 сараар тооцох, аймгийн төвд

ажиллах юм бол 1,3 сараар бас тооцож дүйцүүлэхээр бас ийм заалт орж ирсэн энэ бас хасагдсан байх юм. Тэгээд бид нарын нөгөө яриад байдаг Улаанбаатар хотод байж байгаа төвлөрлийг бууруулъя, Улаанбаатар хотод байж байгаа төрийн захиргааны сайн албан тушаалтнуудыг сум, орон нутагт тогтвортой ажиллуулах ийм бололцоо боломжийг нээж өгье гээд Монгол Улсын Ерөнхий сайд бас ярьж байсан. Тэгээд энэ маань яагаад хасагдчихав. Энэ дээр бас тодорхой хариултыг хэлж өгөөч гэж хүсмээр байна.

Мөн энэ Төрийн албаны тухай хууль дээр орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллахад бас нийгмийн баталгааг хангах ийм тодорхой заалтууд бас орж ирсэн байна. Энэ дээр нөгөө босоо удирдлагатай гэдэг татвар, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын энэ агентлаг, ажилчид хамрагдах юм уу. Зөвхөн сум, орон нутагт ажиллаж байгаа төрийн захиргааны албан тушаалтан хамрагдах юм уу гэдэг дээр бас тайлбар хэлж өгөөч гэж хүсэж байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Болдын Жавхлан сайд хариулна.

**Б.Жавхлан:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Гишүүнд баярлалаа. Тэр АМНАТ дээр бол бид нар шинэ зохицуулалт хийж, орж ирж байгаа. Өөрөөр хэлбэл аль болох уул уурхайг илүү ихээр эдийн засгийн эргэлтэд оруулна. Тэр хэмжээгээр АМНАТ нь илүү хуваарилагддаг энэ зарчим руугаа шилжиж байгаа. Тухайлбал манай Эрдэнэт байна. Олон жил л Монголын ард түмэнд АМНАТ тушааж байгаа газар. Тэгвэл өмнө нь хамгийн дээд талдаа 9,8 тэрбум төгрөг л орон нутгийн хөгжлийн сандаа авч байсан. Энэ зохицуулалтаар ирэх жилээс 28 тэрбумыг авахаар байгаа. Дорноговь ч мөн адил, Өмнөговь ч мөн адил. Бүр 2 2 дахин нэмэгдээд ингээд очиж байгаа.

Энэ бол их зөв бодлого болж байгаа гэж ингээж харж байгаа.

Тэр 5 жил тутмын нэмэгдэл бол урагшаагаа шүү гишүүн ээ. Нэгэнт 10 жил ажиллачихсан хүн бол 1 удаагийн 5 жилийнхийгээ он гараад авчихна, тэгээд л ингээд аваад явна гэсэн үг. Урагшаагаа гэсэн үг. Тэр босоо хэвтээ дээр бүгд орж байгаа. Бүгд хамрагдаж байгаа.

**Г.Занданшатар:** Жамбалын Ганбаатар сайд хариулъя.

**Ж.Ганбаатар:** Үйлдвэржилтийн байнгын хороон дарга Энхтүвшин даргын асуултад хариулъя. Орон нутаг байгалийнхаа баялгийг ашиглуулаад байдаг. Тэгээд сая би энэ зун бас Дорнодоос авхуулаад хэд хэдэн аймгуудаар явсан л даа. Тэгээд үнэхээр л нүдэн дээр нь ашигт малтмал нь экспортлогдоод хил дээр ингээд цуваад, цуваад л гараад байдаг. Орон нутагт өөрчлөгдөж байгаа зүйл ер нь байхгүй. Тэгэхээр энийг бол өөрчлөх зайлшгүй шаардлагатай. Сангийн сайдтай би энэ асуудлыг бол ярьж байгаа. Ашигт малтмалын хуулийн шинэчилсэн найруулгаар бол АМНАТ-ын нийт орлогын 20 хувийг аймагт нь, 10 хувийг сумд нь гэдэг энэ заалт бол суусан байгаа. Энийг харин дэмжиж өгөхийг бол хүсье. Энэ хэлэлцүүлэг бол удахгүй явах байх. Энийг би яагаад би юу яах вэ энэ хуульд угаасаа ийм заалт байгаа. 10 хувь гэдэг заалт тодорхой. Энийг биелүүлдэггүй юм байна лээ. Буруу тайлбарладаг. Сангийн яамныхан. Тийм учраас биелүүлэх ёстой. Тэгээд ашигт малтмалаа ашиглуулаад байгаа аймаг, сум тодорхой хэмжээгээр хөгжих ёстой. Тэгж байж энэ ард иргэд уул уурхайн талаар ойлголт зөв болно. Яг иргэдийн оролцоо нэмэгдэнэ. Энийг би хатуу байр суурьтай байгаа. Зүгээр ийм байж байж бас цаашидаа төсвийн орлого нэмэгдэнэ гэдгийг Сангийн яамныхан зөв талаас нь ойлгоосой гэж хүсэж байгаа юм. Тэгээд яг таны хэлснээр Ашигт малтмалын хуулийн шинэчилсэн найруулгад явж

байгаа. Өнөөдрийн орж байгаа өөрчлөлтүүд бол ахиц үнэн. Гэхдээ 20 хүртэлх хувийг нь бүрдүүлдэг 2 аймаг байгаа. Энэ бол Өмнөговь, Эрдэнэт. 20 хүртэлх хувийг бүрдүүлдэг 2 аймаг байгаа шүү. Энэ бас нэлээн хязгаарлагдмал байгаа. Бусад ашигт малтмалаа ашиглуулж байгаа аймгуудын хувьд бол мэдээж би Жавхлан сайдтай санал нэг. Угаасаа Засаг дээр шийдвэрлэсэн асуудал ахиц бол байгаа. Гэхдээ үндсээр нь өөрчлөх, яг таны хүсэж байгаагаар өөрчлөхийн тулд Ашигт малтмалын хуульд 30 хувь гэдэг заалтыг бид оруулж өгсөн байгаагаа хэлье ээ. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн, Даваажанцангийн Сарангэрэл гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүдийг дараа нь хойшлуулъя. Одоо Шатарбалын Раднаасэд гишүүн асууя.

**Ш.Раднаасэд:** Би тодорхой 2, 3 юм асууя.

1 дүгээрт энэ Худалдан авах ажиллагааны хууль 1 сараар хойшилж байна. Дарга нь өнөөдөр ирсэн байна. Нөгөө эмнэлгүүд дээр чанар голлосон үнийн худалдан авалттай холбоотой журам дүрмээ баталсан уу. Энийг асуумаар байна. Энэ ямар түвшинд байна вэ.

2 дахь юм, өнөөдөр энэ эрүүл мэндийн байгууллага гэлтгүй нийт Улаанбаатар хотод баригдаж байгаа барилгуудын төсөв өсөөд байгаа асуудал. Ингээд харахаар энэ дандаа л барих байшингаа томруулах өргөтгөл хийх боломжтой эмнэлэг, сургууль, цэцэрлэгүүдийн газрыг ерөөсөө хувийн эмнэлгийг нь бол хувийнхан, хувийн эмнэлгүүд, сургуулийг нь бол хувийн сургуулиуд, цэцэрлэгийг нь бол хувийн цэцэрлэг, сургууль ингээд л авчихсан л байгаа байхгүй юу. Эндээс хамаараад энэ төсөвт өртөг чинь өсөөд байна. Улаанбаатар хотоос гаргаж барья

гэхээр тэр эмнэлэг, сургуулиуд чинь бүгд өсчхөөд байна. Өртөг нь, дэд бүтцийнх нь өртөг нь. Одоо гэхэд чинь 6 эмнэлэг ерөнхийдөө газраа хувийн эмнэлгүүдэд алдсан байна шүү дээ. Энэ захирлууд нь анх хувийн орон сууц барина, ажилчдын орон сууц барина гэдэг нэртэй авдаг. Яваандаа энэ хувийн эмнэлэг болдог энийг дарга, захирал дагасан өөрсдийнхөө эзэмисэн мэргэжлээрээ далимдуулж, эсхүл тэр хүний өвчин ярьж, мөнгө ярьдаг, гэхдээ цаана нь бол өөрсдийнхөө ашгийг боддог ийм юмаа хэзээ арилгах вэ. Энэ хавдрын эмнэлгийн төсөв гээд байнга л ярьж байна. Өдөр тутам төсөв нь өсөөд байна. Жил ирэх тусам бараг сараар өсөж байна шүү дээ. Хавар 4 сард 90 сая доллар байсан төсөв одоо 178 сая долларын өртөгтэй гээд. Бариулахгүй байх сонирхол байгаа юм уу, эсхүл ерөөсөө их сайн чанарын юм нэгмөсөн барьчихъя гээд энэ эмнэлгийн тоног төхөөрөмжийнх нь үнэ өртөг нь ингэж өдрөөр өөрчлөгдөөд байдаг болчихоод байгаа юм уу. Тэгээд 2, 3 жилийн өмнө газрынх нь зураг гарсан гэж байгаа. Одоо энэ хариуцлагын асуудал Худалдан авах ажиллагааны хууль дээр бас орсон. Энэ хэрэгжилт дахиад 1 сараар хойшиллоо. Ингээд сунгадаг, юмныхаа үнийг өсгөдөг. Яахаараа 1 тэрбум төгрөгөөр зураг зурна гэххээд дахиад 2 тэрбумыг өгвөл зургийг чинь дуусгаж өгнө гээд ингээд сууж байдаг юм. Тэгээд энэ зураг төсвийн чинь метр квадратын үнэ өртөг ер нь яаж тооцогдоод байна. Даваасүрэн сайдаас энийг асууя гэсэн юм. Энэ газар олголттой холбоотой Газрын тухай хуульд би нэг өөрчлөлт санал гаргасан. Байнгын хороо дээр унасан. Энэ гишүүд дэмжээд яваад өгөөч. Дарга аа, би цааш нь үргэлжлүүлээд минутаа авчихъя. Яагаад гэхээр энэ төрийн өмчийн газар дээр барьж байгаа, барилга барьж байгаа хүн бол хууль бус гэдгээ мэдэж барьж байгаа байхгүй юу. Эмнэлгийн даргатай, газрын албатай хуйвалдаж, ямар нэгэн байдлаар. Тэгээд шүүхээр яваад эцэслээд шийдээд, нураагаад явтлаа бас өдий дөө гэж эд нар тооцож, тэгж хийж байгаа

шүү. Хэрвээ шүүхийн шийдвэрээр энэ нь хууль бус болох нь тогтоогдох юм бол төрд хураагаад авдаг ийм зохицуулалт хийлгэчих юм бол тэр хүн хэзээ ч тэрийг барихгүй байхгүй юу. Нөгөө цаазаар авах ялтай гээд биччихвэл хүмүүс айгаад энэ гэмт хэргийг хийдэггүй юм гээд яриад байдаг биз. Тэгээд эрх зүйн ухамсрын түвшиний юм. Тэгвэл тэр барилга барьж байгаа хүнд ч гэсэн энэ зохицуулалтыг нь хийгээд, нэг талдаа тэр барилга барих гээд байгаа тэр хүний шуналыг нь хязгаарлаж өгч байгаа, нөгөө талдаа энэ газрыг хамаагүй хөдөлгөөд яваад байдаг төрийн байгууллагуудыг бас зогсоочхож байгаа байхгүй юу. Энэ зүйлүүдийг асуухгүй бол болохгүй байна.

Тэгээд сүүлийн үед энэ эмийн үнэ, эрүүл мэндтэй холбоотой асуудал дээр онцгой анхаарахгүй бол гуравдагч этгээдийн эмнэлгүүд чинь Чинзориг сайд аа, элгээрээ хэвтчихсэн байна шүү. Одоо яах юм бэ 1 дүгээр эмнэлэг, 3 дугаар эмнэлэг, Гэмтэл, Хавдар, Эх нялхас, Арьсны өвчин судлалын төв, дүүргүүдийн 3 эрүүл мэндийн төвийн газрууд чинь ингээд хувийнхны гарт оччихсон. Өргөтгөл хийх боломжгүй ийм нөхцөл байдалд байна. Гэтэл энэ.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Эхлээд Жавхлан сайд, дараа нь Даваасүрэн сайд.

**Б.Жавхлан:** Раднаасэд гишүүний асуултад хариулъя. Тэр халдварын эмнэлгийн зураг төсвийг тухайн үеийн Барилга, хот байгуулалтын сайдын багц дээрээс 2021 онд 960 сая төгрөгөөр гэрээ хийгээд, зургийн даалгавраа аваад хот төлөвлөлтийн хүрээлэн гүйцэтгэхээр ингээд одоо хүртэл дуусаагүй явж байгаа. Зураг төсөв нь дуусаагүй, зураг төсвийг дуусгахын тулд гээд нэмэлт санхүүжилт цаанаасаа нэхээд байна гэж тайлагнасан. 960 сая төгрөгөөс одоогоор 476 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн. Үлдэгдлийг нь бол бид олгоогүй ингээд явж байгаа. Энэ талаар

дэлгэрэнгүй мэдээлэл яамнаас нь өгөх болов уу гэж бодож байна.

**Г.Занданшатар:** Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн газартай холбоотой асуулт.

**Ц.Даваасүрэн:** Раднаасэд гишүүний тэр хэлээд байгаа шүүхийн шийдвэр гаргаад гэдэг юм уу, дүгнэлт гаргаад буулгах эрх зүй чинь өөрөө уг нь байгаа байхгүй юу. Одоо хууль дээр ямар зохицуулалт байна гэхээр хэрвээ хууль бусаар газар олгосон байгаа бол ерөнхий байцаагчийн дүгнэлт гаргаад, тэгээд орон нутгийн удирдлага буулгах арга хэмжээ авна гээд хууль дээр байж байгаа юм. Тэгээд сая жишээлбэл, яг энэ олон нийтэд нэлээн хэл ам дагуулаад байгаа авлига хороолол дээр яг наадах чинь болж байна шүү дээ. Нөгөө байгаль орчны ерөнхий байцаагчийн дүгнэлт нь гарсан. Ингээд гараад яг хуулийн дагуу Нийслэлийн Засаг дарга буулгах шийдвэрээ гаргахаар шүүх рүү өгчхөж байгаа юм. Тэгээд шүүх нь түдгэлзүүлчхэж байгаа байхгүй юу. Тэгэхээр ер нь ингээд харахад шүүх дээр очоод энэ процесс удааширдаг, хэд хэдэн шат дамжиж явдаг энэ хооронд олон юм болдог гээд тэгж төсөөлөөд байгаа гэж таны хэлээд байгаа чинь үнэн л байгаа байхгүй юу. Тэрэнд итгээд л нөхдүүд хууль бусаар газраа олж авснаа мэдсэн мөртөө тэнд барилгаа барьчихаад байна л гэж би яг өөртэй чинь ижилхэн тэгж харж байгаа. Хуулийн заалт бий юу, зохицуулалт бий юу. Хангалттай байгаа байхгүй юу. Энэ төсөвт өртөг нэмэгдсэн дээр бас нэг ийм нэг ковидтой холбогдолтой юм байгаад байгаа юм. Нөгөө ковидоос шалтгаалаад бид нар 1, 2 жилийн төсвийг ингээд нөгөө он дамнуулаад тавьчихсан шүү дээ. Тийм ээ. Нөгөө бага бага, амсуулаад энэ тэр. Тэр чинь ингээд он дамжаад явчихаар бас үнийн өсөлтөд нөлөөллөө гэдэг шалтаг болчихоод байгаа байхгүй юу. Тийм учраас манайхан тэр халдварт дээр тодруулаарай. Би ойлгохдоо бас л энэ бүгдээс шалтгаалаад л мөнгө төгрөг

хүрэлцэхгүй болсон гэсэн юм ярьж байгаа юм байна лээ. Энэ хооронд гэхэд ажиллах хүчний өртөг гэхэд 2 дахин өсчихсөн байгаа байхгүй юу. Хүний цалин гэхэд. Бүх юмны үнэ 2 дахин өслөө шүү дээ. Тэгээд ингээд ирэхээр нөгөө 2 жил дамнуулаад төсвийг нь ингээд хуваарилаад 3 жил дамнуулаад.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Баярбат. 86.

**Ц.Баярбат:** Раднаасэд гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Барилга, хот байгуулалтын Төрийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч. Түрүүн гишүүний асуусан зураг төсөлтэй холбоотой асуудал дээр нэмэлт хариулт өгье. Барилгын зураг төслийн ажлын жишиг үнийг бол Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 108 дугаар тушаалаар батлаад, одоо бид нар мөрдөж байгаа. Тэрнээс хойш энэ зураг төслийн үнэд бол ямар нэгэн өөрчлөлт ороогүй байгаа. Нэмэгдсэн зүйл байхгүй байгаа. Зураг төслийн жишиг үнийг тооцохдоо бол ер нь ямар зориулалтын барилга вэ гэдгээс нь хамаараад метр квадрат талбайгаар нь боддог. Хавдрын эмнэлгийн хувьд бол нийтдээ эскиз зураг юмнууд нь хийгдчихсэн байж байгаа. Түрүүний хот төлөвлөлт хүрээлэн гэж компани дээр хийгдсэн. Нийтдээ 5 блок барилгын зураг төслийн хэсгээс хийгдсэн. Тэгэхээр анхны өгөгдсөн зургийн даалгавраас бас объектомын хэмжээ яг стандарт нормын дагуу боловсруулахад бол талбайн хэмжээ нэмэгдэж байгаа учраас зураг төсөл боловсруулах үнийг өсгөх ийм санал ирүүлчихсэн байгаа юм. Тэгэхээр манай яамнаас бол энэ дээр ажлын хэсэг гараад, яг энэ норм, стандарт, зургийн даалгавартай хэрхэн нийцэж байгааг нь дахин нягталж үзэж байгаа ийм байдалд байна.

**Г.Занданшатар:** 85. Худалдан авах ажиллагааны газрын дарга.

**Ц.Батзул:** Төрийн худалдан авах ажиллагааны газар, Батзул. Раднаасэд



гишүүний асуултад хариулъя. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг б сарын 16-ны өдөр баталсан. Энэ хуулийн 36.1.2 дээр олон улсын чанарын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, био бэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс эсхүл Олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах шаардлагатай бол нэг эх үүсвэртэй худалдан авах ажиллагааны аргыг хэрэглэж болно. Ингэхдээ Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас журмын санал боловсруулж, Засгийн газраар батлуулна гэж заасан байгаа. Тэгээд Эрүүл мэндийн яамнаас болон Сангийн яам хамтраад энэ журмын төслийг нь боловсруулчихсан, одоо санал авахаар бэлтгэгчихсэн байгаа юм байна.

**Г.Занданшатар:** Шатарбалын Раднаасэд гишүүн тодруулж асууна.

**Ш.Раднаасэд:** Анх ажлын даалгавар өгч зураг зуруулах байна шүү дээ. 996 сая төгрөгөөр 2021 оны 11 сарын 17-ны өдөр гэрээ байгуулаад гарсан байна. Тэгээд дунд нь юмаа өөрчлөөд үнийн дүн нь 3,3 тэрбум боллоо гээд. Ийм байж болох юм уу. Анх захиалагчаар зургийнхаа тендерийг зарлахдаа та нар чинь тодорхой юмаа өгдөг юм байгаа биз дээ. Тэгээд ийм байдлаас чинь болоод энэ эмнэлгүүд өнөөдөр явахгүй байгаа байхгүй юу. Тулчихсан юмнууд. Яг бодит үнэн бол ний нуугүй хэлэхэд энэ сайд нарын чинь орон нутагт тавьсан өөрсдийнхөө тойрог дээр тавьсан төсөв чинь салбарынх нь хөрөнгө оруулалтын төсвөөс их байгаа шүү. Зөвхөн тойргоо бодож та нар зарим нь ажиллаад байгаа шүү.

**Г.Занданшатар:** Содномын Чинзориг сайд хариулъя.

**С.Чинзориг:** Манай салбартай холбоотой 4 эмнэлгийн асуудал Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт

ороод яваад байдаг. Тэгээд хэрэгждэггүй. Тэгээд энэ жил бас ч гэж 1 үеэ бодвол бас урагш 1, 1 алхаж л байгаа л даа. Эс эд эрхтэн шилжүүлэн суух төвийн барилга бол орж байгаа. Зүрх судасны төвийн барилга, ХӨСҮТ, Халдварын барилгууд ямар ч байсан хөдлөхөөр болж байгаа юм. Хавдрын зурагтай холбоотой асуудал бол 990 сая төгрөгөөр Барилга, хот байгуулалтын яам өнгөрсөн жил тендер зарлаад гүйцэтгэгч сонгосон. Гэхдээ нэг юм хэлье. Манай яамнаас ажлын даалгаврыг ерөөсөө өөрчлөх санал өгөөгүй юм байна лээ шүү. Одоо яагаад ингээд 3,8 тэрбум төгрөг нэхээд байгаа юм бэ. Манайх ажлын даалгавар өөрчилчихсэн юм уу. Обьём хэмжээг өөрчилсөн юм уу гэхээр манайх тийм санал өгөөгүй ээ. Тэр гүйцэтгэгч компани чинь 2,9 тэрбум төгрөг нэмж өгвөл бид нар зургийг чинь гүйцээж өгнө.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Содномын Чинзориг сайд гүйцээж хариулъя.

**С.Чинзориг:** Би яг энэ зурагтай холбоотой асуудлаар 2 хоногийн өмнө Барилгын хөгжлийн төвийн дарга Амарсанаатай уулзсан. Танайх энэ зургийн тендерийг танайх зарласан. Яагаад 990 сая төгрөгөөр зураг төсвийг нь хийж өгнө гэххэд одоогоор хийж өгөхгүй ингээд 2,9 тэрбум төгрөг нэмж нэхээд байгаа юм бэ. Тэгээд манай газрын дарга нар байсан санхүүгийн хүмүүс бүгд манайх обьём хэмжээ өөрчилсөн санал өгөөгүй, ажлын даалгавар өөрчлөөгүй, гүйцэтгэгч компани л үнэ өртөг өссөнтэй холбоотойгоор 2,9 сая тэрбум төгрөг нэмж өг. Тэгэхгүй бол танай зураг төсвийг гүйцээж чадахгүй, одоо бол зураг төсвийг чинь зөвхөн хар скийз зураг нь л гарсан юм байна лээ шүү дээ. Тэгээд одоо би арга ядахдаа ядаж наад компаниасаа сал гэсэн. Тэр хар зураг скийзийг нь ав. Тэгээд ирэх жил Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад байгаа тэр зураг төсвийн мөнгөнөөс наад зураг төсвийг нь гүйцээж өг л гэдэг ийм юм

ярьсан. Танай Амарсанаа дарга бол энийг маш сайн мэдэж байгаа. Сая тэр нүдний шилтэй хүний ярьж байгаагаар манай яамнаас болсон юм шиг объём, хэмжээгээ нэмчихсэн юм шиг, ажлын даалгавраа өөрчилсөн юм шиг юм яриад байна. Тийм юм байхгүй. Битгий Их Хурлын танхимд орж ирээд худлаа мэдээлэл өгөөд бай. Манай яамнаас ерөөсөө барилгын объём хэмжээ өөрчлөөгүй. Ажлын даалгавраа өөрчлөөгүй гэдгээ бол манайхан надад хатуу тийм ойлголт, мэдээлэл өгч байгаа. Харин гүйцэтгэгч компани л 2,9 тэрбум төгрөг нэмэлт шаардлагатай, энийг шийдэхгүй бол зургийг чинь гаргахгүй гээд энэ хавдрын эмнэлгийн асуудал жаахан хүндрэлтэй болчихоод байгаа шүү дээ.

**Г.Занданшатар:** 86. Гүйцээж хариулъя. 1 минут.

**Ц.Баярбат:** Раднаасэд гишүүний асуултад хариулт нэмж өгье. Чинзориг сайдын хувьд би миний хариулт бас буруу ойлгочих шиг боллоо. Энэ бол зургийн даалгавраасаа шалтгаалсан гээгүй. Зураг төсөл боловсруулах шатад гүйцэтгэгч компани нь эмнэлгийн норм стандартын дагуу энд эмнэлгийн цогцолборыг боловсруулахад нийтдээ 5 блок барилга байх ийм шаардлагатай байна. Энэ үүднээс норм стандартынх нь дагуу бид нар эскиз зургаа боловсрууллаа. Цаашид ажлын зургийн шатад энэ объёмоор нь хийх юм бол зураг төсвийн үнэ нэмэгдэх нь гэсэн ийм саналыг ирүүлсэн юм. Тэгээд хэрвээ энэ зураг төслийн үнийн саналын дагуу боловсруулах боломжгүй бол бид нар гэрээгээ цуцлах хүсэлтээ манайд тавьчихсан байгаа. Энэтэй холбогдуулаад Барилга, хот байгуулалтын яам, Барилгын хөгжлийн төвөөс энэ асуудлыг нягталж шалгах ажлын хэсэг гарчихсан ажиллаж байна. Энэ бол цэвэр норм дүрэмтэй нь нягталж тулгаж шалгана гэсэн үг. 3 давхраас доош байх ийм шаардлагатай байгаа. Түүнээс гадна явц дунд нь газрын.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Танд одоо минут байхгүй болсон. 2 удаа тодруулсан. Дашдондогийн Ганбат гишүүн.

**Д.Ганбат:** Ингээд төсөв дагалдаж орж ирж байгаа хуулиуд маань бид бүхэн энийг хэлэлцээд ярьж ярилцаж байна. Энэ дээр нэг хууль байхгүй байна. НӨАТ-ын 10 хувийн буцаалтыг 5 хувь болгоё гэсэн энэ хууль маань хааччихав. Уг нь энэ хууль чинь яг л орж ирж байх ёстой шүү дээ дагалдаад. Яагаад байхгүй байгаа юм бол. Яагаад ингээд ажлын хэсэг гээд тэр хуулийг замхруулах гээд байгаа юм бэ. Энэ ямар учир байна. Хэрвээ үнэхээр тэгж бодож байгаа бол буруу гэж бодож байгаа бол тэр НӨАТ-ынхаа 2 хувийн буцаалтаа ч гэсэн байхгүй болгочих л доо. НӨАТ-ын 10 хувиараа л явчих. Хамгийн зөв зүйтэй энэ иргэдээсээ саналыг нь авсан иргэд маань хэр ойлгоцтой байгаа юм бэ. Төсвийн талаар ер нь улс орон энэ татвар төлөлтийн талаар ямар ойлголттой байгаа вэ гэдэг нь бол манай парламентад бас дэвшилтэд үзэлтэй хүмүүс байна л даа. Ардын нам дотор ч гэсэн ингээд санал асуулга явжээ. Энэ зөв зүйтэй байсан. Ингээд хамгийн боловсролтой иргэд маань 105 мянган иргэд 3 хоногийн дотор саналаа өгсөн байна. Бид нар татвар төлөгчид больё. Бид нар эх орончид байя гэсэн ийм саналыг өгсөн байна. Гэтэл яагаад энийг хэлэлцэж үзэхгүй байгаа юм бэ. Саналаа өгсөн биш тэр иргэд маань доромжлуулж байна шүү дээ эргээд. Тэд нар чинь хамгийн мэдлэгтэй мэдээлэлтэй ийм Монгол Улсын иргэд байна. Тэр судалгаагаар 70 хувь нь эмэгтэйчүүд байна. 30 хувь нь 18-25 насны залуучууд байна. Ийм байхад энэ хэдийн саналыг нөгөө улных гэдэг маягаараа тоохгүй ингэж авч үзэж болохгүй ээ. Ер нь манай Засгийн газар энэ Ардын нам бол арай хэтэрхий данхайчихсан байна л даа. Энэ 3-ны 1 нь давхар дээлтэй, 23 сайдтай, 17 яамтай ийм л болчихсон байна. Гэтэл иргэд чинь бид нар эх орончид байя. Бид нар татвараа төлье. Татвараа бүгд

төлөх ёстой. Энэ хяналтын системийг чинь бид нар сайжруулаад өгье гээд саналаа өгч байхад тэрийг нь хэрэгсэхгүй. Би Жавхлан сайдад хэлсэн. 600 тэрбумаар дутах нь гэж. Үгүй ээ, ойлгож байна. Үүнээсээ илүү гартал иргэд татвараа төлчихнө. Ямар ч санаа зовох юм байхгүй. Энэ 27 их наяд ийм том татвар чинь уг нь цуглуулаад, төсвөө хийгээд бид нар ингээд яахдаа бол уул уурхайн хэдэн компаниуд нь мөнгөө өгчхөөд чимээгүй байж бай. Энэ том төр засаг бол бид нар ингээд Ардын намын уг нь та нар намаа бол ардын гээд нэрлэчихсэн. Одоо яг үүгээрээ бол бараг авлигачдын гэдгээ нотолж байгаа байхгүй юу. Энэ төсвийг тэр том саванд хийгээд цоорхой хувинд хийсэн юм шиг л ингээд л урсаад өнгөрч байна шүү дээ. Тэрийг чинь иргэд гарч ирээд хэлэх гэж байна л даа. Энэ мөнгө чинь буруу зарцуулж байна. Энэ төсөв чинь зөв, буруу байна. Энийг ингэж шийтгэе, ийм чанаргүй юм байна гэж хэлэх эрхтэй болчхож байгаа байхгүй юу. Яагаад гэвэл би татвар төлөгч. 3 үнэн байдаг. Төрөх нь үнэн, үхэх нь үнэн, татвар төлөх нь үнэн. Ийм их мөнгийг үр дүнгүй зарцуулж байна гэдгийг чинь хэлээд яриад өгье, засъя гээд байхад энэ хуулийг яагаад хойшлуулаад байгаа юм бэ. Уг нь энэ төсөвтэйгөө хамгийн сүүлийн төсөв шүү дээ. Энэ оны, энэ чуулганы, энэ бүрэн эрхийн. Хэрвээ энийг хэлэлцсэн бол үнэхээр та бүхэн бол ард түмний нам ард түмний төлөө ажиллаж байгаа ийм төр засаг байж болох байлаа. Гэтэл энэ дотор дэвшилттэй үг хэлж байгаа, үзэл бодлоо тэр юмыг нь дэмжиж байгаа ард түмнийг энэ асуудалд оруулах гэж байгаа энэ юмыг нь ингээд таслан зогсоогоод иймэрхүү маягаар ингээд шийдээд.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Болдын Жавхлан сайд хариулъя гэнэ.

**Б.Жавхлан:** Ганбат гишүүний асуултад хариулъя. Өнөөдөр бид нар 2024 оны төсөв, төсвийн дагасан өргөн мэдүүлсэн хуулиудыг хэлэлцээд явж

байна. Өөрөөр хэлбэл 9 сарын 29-ний өдрийн байдлаар Засгийн газраас өргөн барьсан тэр хүрээнд хэлэлцээд явж байгаа. Таны саяын ярьсан асуудал бол тэрнээс хойш яригдсан, хойш санал хураалтууд онлайнаар явсан. Тэгээд Байнгын хорооноос цаашаа ямар процессоор яаж явахыг Байнгын хороо дээрээс хариулсан нь дээр байх. Одоо бол яг Засгийн газраас өргөн барьсан хуулиудаа л хэлэлцээд явж байгаа.

**Г.Занданшатар:** Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууя.

**Х.Ганхуяг:** Өглөөний мэнд хүргэе. Би түрүүний тавьсан асуултууд дээрээ яг тодорхой хариулт авчихмаар байна. Бид нар 1600 зөвшөөрлийг 362 болгосон. Зөвшөөрлийн хуулийн 8.1, 8.2-т зааснаас бусад бүх төрлийн үйл ажиллагааг зөвшөөрөлгүйгээр эрхлэх эрхтэй болсон юм байгаа юм манай иргэд, аж ахуйн нэгжүүд. Иргэд, аж ахуйн нэгжүүдийн нуруу бол тэнийхээр ийм хууль бид нар баталж өгсөн юм. Энэ дээр бол би гишүүддээ бол талархал илэрхийлж байна. Гэхдээ энэ 362 зөвшөөрлийг чинь бид нар нэрээ заангуут иргэд, аж ахуйн нэгж бүгдээрээ хяналтаа тавьж байгаа юм. Тэгээд бид нар Улсын Их Хурлаас шалгах ажлын хэсэг байгуулаад, жил ажиллаад, санал, дүгнэлтээ танилцуулаад Улсын Их Хурлаас тогтоол гаргаад, 10 сарын 1-ээс өмнө энэ дутуу хуулиудаа өргөн бариач гэдэг тогтоол гаргасан чиглэл өгсөн. Ноднин жил бас 35 дугаар тогтоолоор 81 хуулийг өргөн бариач гэсэн. Тэр дотор 80 хууль өргөн баригдаад, яг биологийн идэвхт бүтээгдэхүүнтэй холбоотой буюу витаминьг өргөн бариагүй авч үлдсэн. Яг тухайн үед протокол бий. 3 удаа Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн, Эрүүл мэндийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Эмийн агентлагийн дарга Цэндмаа гээд бүгдэд нь ийм байдлаар хууль өөрчлөгдөж байгаа гээд нэмэлт, өөрчлөлтийг бүр бичиж өгсөн. Өнөөдөр өргөн бариагүй сууж байна. Тэгээд Хүрэлбаатар сайд энд сууж

байна. Учрал сайд энд сууж байна. 2-уулангаас нь асуулт дээр хариу авчихмаар байна. 1 дүгээр асуудал болохоор энэ витаминь хуулийг яагаад өргөн барихгүй байгаа юм бэ. Ямар ашиг сонирхол байдаг юм. Яг тэр хариуцсан хүмүүс дээр нь би шалгалт явахыг шаардаж байна. Улсын Их Хурлаас шалгах ажил хэсэг дахиж байгуулахыг шаардаж байна.

2 дугаар асуудал энэ Зөвшөөрлийн хуулийн 8.1, 8.2-т зааснаас бусад ямар нэг зөвшөөрлийг тогтоолоор, захирамжаар, Засгийн газрын шийдвэрээр хүртэл нэмэхийг хориглочихсон байгаа. Гэтэл өнөөдөр 100 гаруй бүртгэл нэртэй зөвшөөрлийг бий болгочихсон байна. Тэгээд Учрал сайд уг нь бол Инновацын байнгын хороог ахалж байсан, одоо манай Инновацын яамыг хариуцаад ажиллаж байгаа ийм сайд байдаг. Яг энэ дэвшилтэд үзлийг хүнд сурталгүй байхыг хариуцаж байгаа сайд байхгүй юу. Тэгээд яагаад энэ хууль бус юмыг ийшээ оруулчихсан юм бэ гэдэг би асуулт асуумаар байна. Тэгээд яг энэ 2 асуултаа хариултаа авчхаад 1 дүгээрт Хүрэлбаатар сайдаас, дараа нь Учрал сайдаас хариулт авсны дараа дахиад тодруулъя.

**Г.Занданшатар:** Жавхлан сайд. Чимэдийн Хүрэлбаатар сайд хариулъя.

**Ч.Хүрэлбаатар:** Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Өчигдөр Монгол Улсын Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ Худалдаа аж үйлдвэрийн танхим, ажил олгогч эздийн холбооноос хамтраад төр хувийн хэвшлийн зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан. Энэ зөвлөлдөх уулзалт дээр саяын Ганхуяг гишүүний хэлж байгаа Зөвшөөрлийн тухай хуулийг бизнес эрхлэгчид бол хамгийн өндрөөр дэмжиж, талархаж, хүлээж авч байгаа. Бизнес байдаг хүнд суртал, төрийн зүгээс үзүүлдэг хүнд сурталыг бууруулахад чухал хувь нэмэр оруулах хууль гэж үнэлгээ, дүгнэлт өгчихсөн юм байна лээ. Тэгэхээр

энэ хуулийг цаашид нь сайжруулах чиглэлээр бол Засгийн газар ажиллаж байгаа. Засгийн газрын хувьд энэ бизнес эрхлэгчдийг дэмжих, манай эдийн засгийн өрсөлдөх чадвартай ийм эдийн засаг олгоход яах аргагүй хүнд суртал, Төрийн зүгээс үзүүлдэг янз бүрийн хүнд суртал бага байх чиглэл дээр нь ажиллаж байгаа. Тэр витаминь асуудал дээр бол ийм юм байна лээ Ганхуяг гишүүн ээ. Зөвшөөрлийн хуулиар хасчихсан боловч Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нь бол байгаад байгаа. Тэгэхээр тун удахгүй Эм эмнэлгийнх нь хуульд өөрчлөлт оруулаад, зөвшөөрлийнхөө хуультайгаа нийцүүлсэн ийм арга хэмжээг бол авна гэдгийг би танд хэлье. Ер нь ч тэгээд хэдэн витамин оруулж ирээд хэрэглэж байхад заавал витамин оруулж ирэхэд тусгай зөвшөөрөлтэй гээд хил, гааль дээр дарамтлаад байдаг энэ үзэгдэл бол байх ёсгүй гэж ойлгож байгаа. Таны хэлж байгаатай санал нэг байна. Жоохон хугацаа алдсан юм байгаа энэ дээр уучлал хүсэж байна гэдгийг хэлье. Дээр нь нийслэл дээр 100 гаруй тусгай зөвшөөрөл нэмэгдчихлээ гээд байгаа. Энэ яг үнэндээ үзэхээр тийм тусгай зөвшөөрөл биш, бүртгэлийн асуудлыг ингээд холиод яваад байгаа юм байна лээ. Тэгээд энийгээ цэгцэл гэдэг үүрэг өгөгдчихсөн байгаа шүү гэдгийг Ганхуяг гишүүнд хэлье. Тэгээд энэ удахгүй тэр илүү дутуу юмнууд нь зас залруулагдчих байх аа. Тэгээд бас хууль маань өөрөө дөнгөж хэрэгжээд явж байгаа учраас яг хэрэгжүүлэлтийн явцад бага сага алдаанууд байгаа гэдгийг би бол хүлээн зөвшөөрч байна. Тэгээд засаад залруулаад явчихна гэж ойлгож байгаа.

**Г.Занданшатар:** Учрал сайд, Ням-Осорын Учрал сайд хариулъя.

**Н.Учрал:** Зөвшөөрлийн хууль бол их сайн хууль болсон. Тэгээд хувийн хэвшил, компани, аж ахуйн нэгжүүд их талархалтай байгаа гэдгээ илэрхийлсэн. Хуулийг хэрэгжүүлэх процедур дээр алдаа гараад байна уу гэвэл гарч байгаа.

Жишээ нь 360 зөвшөөрөл буюу энгийн зөвшөөрөл тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн хуулиар хуульчилсан. Зөвшөөрлийн хуулийн гол концепц бол Зөвшөөрлийн хуульд заагаагүй бусад үйлчилгээ бол зөвшөөрөл биш ээ. Тийм учраас зөвшөөрөл авах ёсгүй л гэж байгаа юм. Дээрээс нь хуульд заасан хугацаанд зөвшөөрөл олгогдоогүй бол зөвшөөрөл олгогдсонд тооцно. Хариу илгээгээгүй бол гэдэг ийм хуулийн концепцтой. Тэгэхээр би өнгөрсөн хугацаанд энэ и-монгол дээр и-бизнесийг холбосон юм. И-Монгол руу орохоор иргэн, хуулийн этгээд гээд ангилал байгаа. Хуулийн этгээд рүү орохоор и-бизнес гээд бүх зөвшөөрлүүд байгаа. Энгийн зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл 2-оос бичигдсэн жагсаалт дотроос 208 зөвшөөрөл бол цахимаар хүсэлт авдаг болчихсон байгаа. И-бизнес рүү. Ингээд и-бизнес нээгдсэнээс хойш ерөөсөө 7 сарын хугацаанд гэхэд одоогийн байдлаар 21 мянган хэрэглэгчтэй нийт 47 мянган үйлчилгээ авсан. Цахимаар 6700 компани байгуулагдсан юм байна лээ. Тэгээд энэ бол бас сайн тоо гэвэл тоо. Хэн нэгэнтэй уулзахгүйгээр нөгөө технологи авлигатай бас бодитойгоор тэмцэж байгаагийн илрэл мөн л дөө. Хэн нэгэн чихэр, набор барихгүйгээр зөвшөөрөл авдаг болсон байна. Хэн нэгэн чихэр, набор барихгүйгээр компаниа байгуулдаг болсон байна. Тэр байтугай компанийнхаа нэрийг хүртэл шүүгээд байгаа эсэхийг нь хараад, компанийнхаа нэрийг бүртгүүлээд авчихдаг болчихсон байна. Тэгэхээр ер нь бол бас урагшилж байгаа. Харин и-бизнес дээр нийслэлийн үйлчилгээнүүд яагаад орчихсон юм бэ гэхээр энийг би хотын даргатай бас 2 удаа уулзсан энэ асуудлаар. Дээрээс нь өмнөх хотын даргатай хүртэл энэ асуудлаар уулзсан. Нийслэл дээр Зөвшөөрлийн хуулийн 360 зөвшөөрөл багтаагүй. Тэр байтугай органик хуулиараа бүртгэлд ч тооцогддоггүй зөвшөөрөл биш зөвшөөрлүүд байгаад байсан. Зөвшөөрөл биш зөвшөөрөл гэж нэрлээд байгаа юм. Нэг ёсондоо зөвшөөрөл гэдэг нэргүй мөртөө яг

шаардлага адилхан тавьдаг эсвэл олгодоггүй, олгодоггүй бол дахиад 6 сарын дотор дахиж хүсэлт илгээхгүй шүү гээд урд нь том босго тавьчихдаг. Ингээд Нийслэлийн Засаг даргатай нэгдсэн ойлголтод хүрээд, Нийслэлийн Иргэдийн Хурлын шийдвэр гарах байх. Бид нийслэл дээр үйлчилгээ явуулж байгаа. Нөгөө кофе шоп байгуулах, ресторан байгуулах, дугуй засвар байгуулах, нөгөө барааны дэлгүүр, 8 нэрийн дэлгүүр гээд элдэв олон зөвшөөрөл биш нэртэй мөртөө ийм үйлчилгээнүүд. Энийг цэгцлээд ирэх 7 хоногт хотын удирдлагуудтай хамтраад энэ и-бизнесээс энэ зөвшөөрөл биш мөртөө зөвшөөрөл шиг үйл ажиллагаа явуулаад байгааг салгаад үйлчилгээ рүү оруулж байгаа юм. Ингээд энэ и-бизнесээс бол энэ жагсаалтын 360-д байгаа бүх зөвшөөрлүүдийг гаргаад үйлчилгээ рүү оруулна. Тэгээд дараа 7 хоногт нийслэлийн 60 үйлчилгээ хэрвээ и-бизнес дээр үйлчилгээ хэлбэрээр орчих юм бол ямар боломжийг иргэддээ олгох вэ гэхээр кофе шоп байгуулна гээд иргэн хүсэх юм бол цахимаар нэрээ явуулаад, ямар обьектод үйл ажиллагаа явуулах гэж байгаагаа мэдээлээд, кноп дараад, тухайн цаг үедээ ажлаа эхэл л гэж байгаа юм. Хэн ч зөвшөөрөл олгохгүй, хэн ч бүртгэхгүй. Харин дараа нь мэдээж тэр эрүүл ахуйн шаардлага, стандарт, шаардлагаа нийслэл цаг хугацааны явцад хийгээд явна биз. Нэгэнт зөвшөөрлийн хууль гарчихсан учраас. Тэгээд нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа зөвшөөрөлд хамааралгүй байгууллагууд нь ингээд үйл ажиллагаа явуулна гэдэг ийм л шийдвэр гарч байгаа юм байна лээ. Нийслэлийн тэр агентлаг бусад байгууллагууд нь бол холбогдох журмынхаа дагуу процедурт нь хяналтаа тавиад явна гэсэн. Ингэж Зөвшөөрлийн хуулийг бодитойгоор хэрэгжүүлж эхэлнэ. Нийслэлийн зүгээс үйлчилгээнд байгаа зарим зүйлийг бол зөвшөөрөлд оруулъя гээд жишээ нь такси шиг үйлчилгээг зөвшөөрөл рүү оруулж хуульд оруулж байж л өөрчлөлт оруулна.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Ер нь тусгай зөвшөөрөл бол хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, эрх, эрх чөлөөнд шууд хамааралтай зөвшөөрлүүдийг хэлнэ гэж зохицуулсан шүү дээ. Ганхуяг гишүүний хэлж байгаа зөв байгаа. Тэгэхээр үүнийг энгийн зөвшөөрөлтэй адилтгаж үзэж бол болохгүй шүү дээ. Ганхуяг гишүүн тусгай зөвшөөрөл, энгийн зөвшөөрөл 2-ыг тэгж ялгасан. Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинтой холбоотой асуудал тусгай зөвшөөрөл. Тэгээд тусгай зөвшөөрөл олгоход нягтлах ажиллагаа хийх шаардлагатай гэдгээр хэт туйлширч болохгүй, өргөдөлд хариугүй өгөөгүй бол зөвшөөрөл олгосонд тооцож зохицуулж огт болохгүй гэж төслөөс хасахаар Төсвийн байнгын хорооноос санал гаргасан байна лээ. Засгийн газар дотроо байр суурийн зөрчилдөөнтэй байна. Энийгээ нэгтгэх хэрэгтэй. Сайд нар өөр өөр тайлбар хийж болохгүй. Баагаагийн Баттөмөр гишүүн.

**Б.Баттөмөр:** 2024 оны төсвийн төсөлтэй хамт өөрчлөлт оруулахаар 28 хуулийн төсөл орж ирж байна. Энэ дээр би 2 хуулийн өөрчлөлт дээр санал хэлье гэж бодож байгаа юм.

1 дүгээрт нь энэ Уул уурхайн биржийн хууль. Бидний энэ өнгөрсөн хугацаанд хийсэн хамгийн үр дүнтэй, үр дүнгээ өгч байгаа хууль бол энэ шүү. Яг өнөөдрийн эхний 9 сарын байдлаар Монгол Улсын нийт орлого 5 их наядаар, тэнцвэржүүлсэн орлого нь 5 их наядаар давж яваа. 1 дүгээрт.

2 дугаарт Монгол Улсын валютын нөөц 4 тэрбум доллар болчихсон. Сая тэр Хөгжлийн банкны 500 сая долларыг бас төллөө. Гэх мэтээр асар их Монголын эдийн засагт үр дүнгээ өгч байгаа. Гэтэл энэ дагалдах хуульд бол энэ биржийнхээ хуулийг үгүйсгэсэн, цоорхой гаргасан юм оруулж ирж байгаа шүү дээ. Тэр гаднын компанид жил болгон 2 сая 20 сая тонн нүүрс өгнө. Биржийн бус арилжаагаар тохиролцооны үнээр худалдах юм байна л

даа. Тийм байж ерөөсөө болохгүй. Энэ дээр бол хатуу хэлж байгаа. Тийм байж ерөөсөө болохгүй. Тэр гаднын компанид 20 сая тонн өгч болно. Тэгэхдээ биржийн дундаж үнээр өгөх ёстой. Энийг бол Сангийн сайд маш сайн мэдэж байгаа. Хөгжлийн сайд маш сайн мэдэж байгаа. Үүний шийдлийг олсон уу. Тэр юун дээр би ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн даргаас асууя гэж бодож байгаа юм 1 дүгээрт энэ.

2 дугаарт энэ АМНАТ-ийн бас өөрчлөлт орж байгаа юм байна л даа. Тэгээд энэ 2006 онд Ашигт малтмалын тухай хууль батлагдсан. 2019 онд тэр боловсруулалтын түвшин нь үнээсээ хамаараад тэр АМНАТ-ыг авах хувь хэмжээг бас өөрчилсөн ийм өөрчлөлтүүд орсон. Мөн Монгол Улсын эдийн засагт бол бас зохих хувь нэмэр оруулж байгаа ийм татвар, төлбөрийн нэг хэлбэр шүү дээ. Манай энэ 2024 оны нийт 25 их наяд төгрөгийн бас зонхилох хэсгийг энэ АМНАТ, тэр Тогтворжуулалтын сан, Ирээдүйн өв сан гээд бүгдийг нь бүрдүүлж байгаа шүү дээ. Тэгээд энийг энэ дотор сумуудад өгнө, барина гэсэн юм явж байна л даа. Орон нутгийн хөгжлийг дэмжих сангаар дамжуулаад сумуудад өгнө. 2024 онд 428 тэрбум төгрөгийг орон нутгийн сангаар дамжуулж өгөх юм байна. Энэ өнгөрсөн оны мөн үеийнхээс 112 тэрбум төгрөгөөр илүү байна. АМНАТ-өөр 135 тэрбум төгрөгийг л сумуудад өгөх юм байна. Уул уурхайг дэмждэг сумуудад гэж байгаа. Дэмждэггүй сумуудад өгөхгүй юм уу. Энэ чинь байгаль орчноо хайрлаж, хамгаалах гэж тэмцэж байгаа хүмүүсийн буруу бас байхгүй шүү дээ. Тэгээд энэ ер нь ямархуу тооцоо судалгаан дээр үндэслэж хийгдэж орж ирж байгаа юм бэ. Энэ судалгаанууд. Орон нутгийг бол дэмжихийг зөвшөөрч байна. Дэмжиж байна. Гэхдээ ямар тооцоо судалгаанууд байна. Энийг орон нутагт өгснөөр ямар үр дүнгүүд гарах вэ. Нөгөө тэмцдэг барьдаг хүмүүсийн амыг хаана гэж тооцож байгаа юм уу. Эсвэл орон нутагт очихоороо үнэхээр

тэр бүтээн байгуулалт, тэр ядуурлыг бууруулдаг, ажлын байрыг бий болгодог, хөгжилд хувь нэмэр оруулна гэсэн тийм тооцоонууд байна уу, үгүй юу. Ямар тооцоон дээр энийг хийсэн юм бэ гэсэн ийм асуултуудад хариулт авъя.

**Г.Занданшатар:** Болдын Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Баттөмөр гишүүний асуултад хариулъя. АМНАТ-ын суурь зарчим, АМНАТ-ын хураалт дээр бол ямар ч өөрчлөлт байхгүй шүү. Ямар ч өөрчлөлт байхгүй. АМНАТ-ыг эргүүлээд хуваарилалт дээрээ орон нутгийн хөгжлийн сангаар дамждаг 10% жишээ нь 10% тэр малгай тоо нь бол бас өөрчлөгдөөгүй байгаа. Харин 10% дотроо итгэлцүүр коэффициент дотроо хаанаас илүү их АМНАТ орлого олж ирж байна тэр лүүгээ байраа илүү очдог байх ийм зарчмаар л явж байгаа. Тэр дундаа сум руугаа бүүр илүү очно. Өөрөөр хэлбэл яг ард иргэд рүүгээ илүү очно гэсэн үг. Тийм учраас одоо бид хүссэн хүсээгүй манай эдийн засгийн бүтэц маань ер нь уул уурхайгаас нэлээн хамааралтай. Цаашидаа ч хэдэн жил бид бас ингээж явна. Тийм учраас аль болох энэ эргэлтээ дэмжсэн, эргэлтээ дэмжих тусам эргээд ард иргэддээ илүү их сайхан амьдрах тэр бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, нутагтаа, сумдаа сайхан амьдрах энэ боломжуудыг нь л Орон нутгийн хөгжлийн сангаар буюу ард иргэдийн өөрсдийнх нь оролцоотойгоор Сумын иргэдийн Хурлаар, Аймгийн иргэдийн Хурлаар хэлэлцээд, зарцуулдаг байх тэр зарчим руугаа л явж байгаа гэсэн үг. Өмнөх жилийнхээс нэмэгдэж байгаа дүн нь бол ерөөсөө манай энэ уул уурхайн эдийн засаг, уул уурхайн энэ орлого нэмэгдээд, тэндээс орж ирж байгаа ард түмэнд төлж байгаа төлбөр АМНАТ нь нэмэгдэж байгаатай л холбоотой. Ийм л нэмэгдэл юм байгаа юм.

**Г.Занданшатар:** Дуламдоржийн Тогтохсүрэн дарга хариулъя.

**Д.Тогтохсүрэн:** Баярлалаа. Би Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Энэ уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 10.3-д орсон өөрчлөлттэй холбоотой асуудал байгаа. Засгийн газраас бол орж ирсэн төслийг ерөнхийд нь харахаар бол энэ төрийн өмчит болон төрийн өмчит компаниудыг нэлэнхийдээ бас хамрагдаж болохоор ийм юм бол ажиглагдсан. Тийм учраас ажлын хэсэг дээр ярилцаж байгаад 2 чиглэлээр нэлээн хумьж өгсөн. Энэ заалт бол нэг компанид нэг зориулалтын чиглэлд бол чиглэгдэх ёстой гэж ингээж үзсэн. Тийм учраас бол энд орж байгаа нэг гол өөрчлөлт бол зөвхөн төмөр замын ачиж буулгах буюу терминалыг барихад чиглэгдсэн байх ёстой.

2 дугаарт Улсын Их Хурал 2023 оны 7 сарын 7-нд гаргасан тогтоолоор нийцэж байх ёстой гэдэг ийм 2 зарчмыг барьсан. Энэ зарчмыг барьж үндсэндээ энэ заалтаар бол нэг компани нэг зориулалтаар ийм хэмжээгээр нүүрс худалдан борлуулах ийм байдал руу оруулж байгаа юм. Нөгөө талаас нь үнийн хувьд тухайн бүтээгдэхүүний биржийн арилжааны дундаж үнийг баримтал гэсэн үнийг нь тодорхой зааж өгсөн байгаа. Ингээж ажлын хэсэг дээр ярилцаж байгаад уул уурхайн биржийн тухай хуулийг нэлээд тодотгож ингээж тодорхой болгож ингээж өгсөн байгаа.

**Г.Занданшатар:** Баагаагийн Баттөмөр гишүүн тодруулж асууя. Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа. Төсөв дагуулж оруулсан энэ хуулийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг бас харж байна. Тэгээд Төсвийн тухай хуулийн саяын яриад байгаа АМНАТ-аас орох төлбөрөөс Орон нутгийн хөгжлийн сангийн хуваарилалтыг тухайн олборлолт хийж байгаа уул уурхай, сум, аймгуудад нь 60/40-ийн харьцаатайгаар олгож байгаа энэ асуудлыг бол би маш сайн дэмжиж байна. Үнэхээр тэр уул

уурхайн компаниуд бол тухайн орон нутгийн байгаль орчин ард иргэдийн амьдрах тав тухтай байх, эрүүл аюулгүй байх орчинд бол үнэхээр сөрөг нөлөө үзүүлж байгаа юу гэвэл үзүүлж байгаа. Тийм учраас тэр тухайн орон нутгийн ард иргэд тэндээс олж байгаа орлогоос бас илүү бас үлдэх тэр бололцоо боломжийг нь нээж өгч байгаагаараа бас энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаа гэдгээ хэлье.

Харин энэ Газрын тухай хууль байна. Төсөв дагалдуулж Газрын тухай хуулийг оруулж ирж байна. Бас түрүүн нэг гишүүн хэлсэн, энэтэй санал нэг байна. Энэ чинь том хууль шүү дээ. Газрын тухай хууль чинь. Тэгээд төсвийг дагалдуулж орж ирээд тэгээд Ерөнхий сайдын дэргэд нэг агентлаг байгуулаад 21 аймаг, 9 дүүрэг, 330 гаруй сумдын газар олголтын асуудлуудыг энэ агентлагт нэгтгэхээр эрхийг нь өгөхөөр байж байгаад энэ ажлын хэсэг дээр харин энэ эрхийг нь хасаж байгаа юм байна. Зарчмын зөрүүтэй саналаар. Гэхдээ та нар энэ Газрын тухай хуулийнхаа 2 дугаар зүйлийн 23.2.4 дээрээ улсын хэмжээнд газар зохион байгуулалтын үйл ажиллагааг эрхлэх эзэмшүүлэх ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтыг боловсруулж байгаа юм. Энэ эрх нь тэр агентлагийн энэ эрхийг бол та нар заагаад өгчихсөн байна. Тэгэхээр энэ агентлаг чинь яах юм. Та нар ингээд орон нутагт эрх мэдлийг нэмэгдүүлнэ гээд л ярьдаг хэр нь яг үүгээрээ бол газар зохион байгуулалтын чинь газар олголтын асуудлыг цэгцлэх гээд байгааг чинь ойлгож байна. Гэхдээ яах юм энэ агентлаг нь жагсаалтыг нь баталдаг байх юм уу. Энэ аймаг ирэх жил тэр тэр газар олголтыг ийм ийм зориулалтаар олго гээд жагсаалтыг нь баталсных нь хүрээнд аймаг нь, нийслэл нь, сум нь, дүүрэг нь энэ газар олголтоо хийдэг байх ийм бололцоо хуульчлах гэж байгаа юм уу. Тэгэхээр энэ чинь тэр дээрээ хассан юм шиг байгаа боловч доороо тэр агентлагийн эрх, үүрэгт чинь энэ эрх,

үүрэг нь хэвээрээ байсаар байна. Тэгэхээр энэ агентлаг чинь ер нь ирэх жил дааж давшгүй энэ ажлын ачаалал нь ерөөсөө энэ бүх газруудын орон нутгуудын ирэх жил олгох тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний жагсаалтыг баталдаг газар болох гэж байна шүү дээ. Тэгээд тэр жагсаалтад нь батлагдсаных нь хүрээнд тухайн орон нутгууд газраа олгодог болох нь. Тэгэхээр энэ чинь нөгөө орон нутгуудын өөрсдийнх нь. Тэгвэл энэ орон нутгуудын газрын албадыг татан буулга. Энэ Ерөнхий сайдын дэргэдэх агентлаг чинь бүх ажлыг нь хийхээр авчихсан байна. Энэ үндсэн чиг үүргээрээ. Тэгвэл энэ орон нутгийн газрын алба чинь юу хийх юм. Яг үнэнийг хэлэхэд жагсаалтыг нь тэнд баталж байна. Тийм учраас энэ газрын хуулийг дагалдуулж орж ирснийг бол би бол хувьдаа бол дэмжих бололцоогүй байна л гэж үзэх гэж байгаа юм. Энэ дээр ажлын хэсгийн дарга юм уу, газрын албаныхан хариулт өгөөч.

**Г.Занданшатар:** Энхманлай 88.

**А.Энхманлай:** Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Ер нь энэ газрын хуулиар газрын хуульд өөрчлөл оруулж байгаатай холбоотой Засгийн газрын агентлаг Ерөнхий сайдын мэдэлд шилжсэнээр одоогийн Монгол Улсын хэмжээнд үүсээд байгаа газрын бүртгэл, газар олголттой холбоотой олон субъектуудийн асуудлыг нэгтгэх, өөрөөр хэлбэл Монгол Улсад газар олгож байгаа маш олон байгууллагууд байна. Өөрөөр хэлбэл энэ 330 сумын Засаг дарга, 21 аймгийн Засаг дарга, Нийслэлийн Засаг дарга, 9 дүүргийн Засаг дарга мөн АМГТГ, Байгаль орчны яам зэрэг байгууллагууд газрыг хоорондоо ямар нэгэн уялдаа холбоогүйгээр олгох ажлыг зохион байгуулж байгаа. Эндээс болж нийгэмд маш их бухимдал асуудал үүсэж байна. Энийг бол энэ нэгдсэн байдлаар зохион байгуулах энэ агуулгын хүрээнд Ерөнхий сайдын мэдэлд энэ агентлагийг аваачиж, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангая гэсэн үндсэн



зохион байгуулалттай. Манай дээр сүүлийн жилүүдэд газрын шинэтгэл хэрэгжээд газрын бүх бүртгэлүүдийг нэгдсэн журмаар зохион байгуулах системийг бол байгуулж хөгжүүлсэн. Улсын хэмжээнд төлөвлөгөөгүй газар олголтууд маш их хийгдэж байна. Өөрөөр хэлбэл энэ орон нутгийн удирдлагуудад эрх мэдэл байгаа хэвээрээ байгаа. Энэ Газрын хуулийн өөрчлөлтөөр ямар нэгэн байдлаар тэд нарын эрх мэдэлд халдах, тэдний эрх мэдлээс өөрчлөх ийм заалт, хуулийн төсөл орж ирээгүй. Харин тэдний хийж байгаа ажил дээр мэргэжлийн хувьд дэмжлэг үзүүлэх, буруу төлөвлөгөө гаргах гэж байгаа бол буруу төлөвлөгөө дээр нь бид бүхэн цахим системээр дамжуулаад улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөө аймгийнх нь газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй нь уялдуулаад ямар нэгэн голын гэдэг юм уу ойн хамгаалалтын бүсүүдэд олгох гэж байгаа газар байвал тэр дээр нь хязгаарлалтыг нь зааж өгөөд, хасалт хийгээд ингээд тухайн жилийн төлөвлөгөөнд нь дүгнэлт, зөвлөмж гаргаж өгөх зорилгоор л энэ хуулийн заалт орж ирж байгаа юм. Энэ хуулийн заалт нь угаасаа урьд нь бас манай энэ агентлагийн эрх хэмжээ дээр байж байсан. Өөрөөр хэлбэл улсын хэмжээний газар зохион байгуулалтыг эрхлэх гээд 1 ерөнхий заалт байсан. Тэгвэл газар зохион байгуулалтыг эрхлэх нь яг юуг хэлж байгаа юм бэ гэвэл тухайн жилд боловсруулагдаж байгаа ерөнхий төлөвлөгөө дээр нь л бид бүхэн анализ хийж, дүгнэлт, зөвлөмж өгөх ёстой. Тэгж байж энэ улсын газарт бүх олгогдох гэж байгаа газрууд хоорондоо ямар нэгэн давхцалгүй, бусад ерөнхий төлөвлөгөөтэй зөрчилдөхгүйгээр хориглолт хамгаалалтын бүсэд орохгүйгээр ингэж олгогдох нөхцөл бүрдэх юм. Олгох эрх мэдэл нь бол бүх аймаг саяын нэр дурдсан субъектүүдэд бол хэвээрээ байгаа. Тэгэхээр бол бид бүхэн улсын хэмжээнд газар олгох гэж байгаа, бүртгэл хийх гэж байгаа ажлуудыг бол нэгдсэн удирдлага зохион

байгуулалтаар л хангаж өгч байгаа болохоос эрх хэмжээнд нь бол халдсан ийм хуулийн өөрчлөлт энэ хуулиар бол ороогүй ээ гэж хэлбэ. Дээр нь нэмж хэлэхэд улсын хэмжээний 117 сум дээр ерөнхий төлөвлөгөө хийгдээгүй байж байгаа. Тэгэхээр бол энэ ерөнхий төлөвлөгөөнүүдийг бас бид бүхэн захиалж заавал ойрын хугацаанд хийлгэх хэрэгтэй. Ингэж байж газрыг төлөвлөлтийн дагуу олгодог ийм систем рүү шилжинэ. Тэгэхгүй бол дур зоргоороо орон нутгийн иргэдийн хурал ямар нэгэн үндэслэлгүйгээр газар олголтын төлөвлөгөө гаргаад, Засаг дарга нь шийдвэр гаргаад дараа нь эргээд хууль зөрчөөд асуудал үүсдэг. Тэгснээрээ манай улсын орон нутгууд ямар ч эмх замбараагүй, хот, суурин газруудыг үүсгээд яваад байна. Эндээс болоод иргэдийн эрх ашиг, улс орны нөхцөл байдалд хүндээр нөлөөлж байгаа учраас энийг засаж сайжруулах зорилгоор агентыг ийш нь шилжүүлж, энэ эрх хэмжээг нь тодорхой болгож ингэж зааж өгч ийм хуулийн заалт оруулж ирсэн. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Тодруулъя. Цэндийн Сандаг-Очир гишүүн.

**Ц.Сандаг-Очир:** Та нар ингээд энэ чуулганы танхимд худлаа яриад байж болохгүй шүү Энхманлай дарга аа. Та нар оруулж ирсэн, өргөн барьсан хуулиараа энэ Ерөнхий сайдын дэргэд агентлаг байгуулаад энэ агентлагт иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх олгох шийдвэр гаргахыг энэ агентлагтаа өгөх гэж байсан. Та нарын өргөн барьсан хуулиар. Харин Тогтохсүрэн даргын ажлын хэсэг дээр харин энийг чинь өнөөдөр зарчмын зөрүүтэй саналаар хасахаар оруулж ирж байгаа юм байна. Гэхдээ та нар 2 дугаар зүйлийнхээ 23.2.4-өөр та нар ахиад өөрсдөдөө ямар эрхээ авч үлдэж байгаа гэхээр орон нутагт олгох газрын тухайн жилийнх нь тэр жагсаалтыг нь та нар өөрсдөө баталдаг байх тэр эрхээ авч үлдэж байна.

Тэгэхээр орон нутаг чинь та нарын тэр жагсаалтыг хүлээгээд улам энэ газар олголтын асуудлууд чинь улам хүндрэлтэй. Танай агентлаг хэдэн хүнтэй байх билээ. Та нарын жагсаалтыг хүлээсээр байгаад улам хүндрэл улам тэнд чинь авлига, хээл хахууль цэцэглэнэ шүү газрыг дагаад. Тийм учраас та нар цэгцлэх гэж байгаа нэрийн доор улам хүндрэлтэй байдлыг.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Цэрэнпилийн Даваасүрэн сайд. 1 минут хариул.

**Ц.Даваасүрэн:** Би яах вэ, аймгийн дарга, дүүргийн дарга байсан гишүүдийнхээ ярьж байгааг ойлгож байна. Тэгэхдээ бид нар нэг юмыг бас анхаарах хэрэгтэй. Хэрвээ өнгөрсөн хугацаанд газрын асуудал ямар ч маргаангүй байсан бол надад хэлэх юм алга. Өнгөрсөн хугацаанд газар төлөвлөлтгүй олгогдлоо гэдэг юм чинь хаа сайгүй яригдаж байгаа учраас төлөвлөлтийн дагуу яаж олгодог болох вэ гэдэг л арга хэмжээг л төрөөс авах гэж байна шүү дээ. Жишээлбэл тэр аймаг, сум, дүүргийн дарга нар олгож болно. Харин олгохдоо төлөвлөлтийн дагуу олгож байна уу, үгүй юу гэдгийг баталгаажуулдаг больё л гэж байгаа шүү дээ. Хэрвээ сайн олгож байсан юм бол яагаад энэ хэл үг энэ Улаанбаатарын төлөвлөлт ийм болчихсон юм. Тэгээд төлөвлөлтийг чинь нэгдсэн журмаар хийж байгаа шүү дээ. Одоо манайх хийж байгаа шүү дээ манай яам. Тийм учраас бид нар хийдгээрээ хийнэ. Сумдын ерөнхий төлөвлөлтийг ч хийж өгнө. Тэгэхдээ аймаг, сумдын Засаг дарга нар газар олгохдоо.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж дууслаа. Энэ газрын тухай хууль дээр тэгэхдээ Сандаг-Очир гишүүний асууж байгаа асуулт, хариулт 2 өөр болоод байгаа нь ер нь бүгд тэр газрын ерөнхий төлөвлөгөө, хотын ерөнхий төлөвлөгөө, хотын бүсчилсэн төлөвлөгөө, хуульд ч байж байсан тэр

хэрэгжүүлээгүй л асуудлууд л даа. Тэгэхдээ орж ирсэн хуулийн төсөлд 18.1.7-д энэ газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага буюу Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын саналыг үндэслээд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд газар эзэмшүүлэх, ашиглуулах, эрх олгох шийдвэр гаргах Засгийн газрын бүрэн эрхэд хамааруулахаар заасан нь зөрчил үүсгээд энийг сая хасахаар оруулж ирсэн юм. Сангийн яам энэ хуулиудыг төсөвтэй хамт өргөн барих энийг хянаж үзээгүй. Энэ заалт бол Засгийн газар газар олгох шийдвэр гаргахаар ойлгогдож, энэ өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга газар олгодог холбогдох хуулийн зохицуулалттай зөрчилдөхөөр байсан. Ер нь бол энэ газар зохион байгуулалт, энэ газрын лиценз энэ юмнуудыг бүгдийг нь цэгцэлж, төлөвлөгөөтэй болгож, хяналттай болгож тэр төлөвлөгөөг хяналттай болгох нь туйлын зөв. Агуулга нь. Яг бичилт дээрээ очоод Увс аймгийн Давст сумд 1 хүн хашааны газар авах бол бараг эндээс олгохоор юм шиг ойлгогчлоод байна гэж гишүүд яриад байгаа. Энэ Аймгийн дарга байсан хүмүүс нь ингээж ойлгоод байгаа юм л даа.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. 13 цаг болсон тул чуулганы нэгдсэн хуралдаан завсарлалаа. 14 цагаас санал хураалтаар үргэлжилнэ. 53 саналтай.

ЗАВСАРЛАГА.

**Г.Занданшатар:** 11 сарын 02-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Одоо санал хураалт явуулна. Ирцээ бүрдүүлээрэй. Санал хураалт явуулна. Санал хураалт явуулъя. Жавхлан сайд аа, сайд нараа дууд. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан. Одоо зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 53 санал байгаа.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хороо дэмжсэн 1 санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

**“1/59 дүгээр зүйлийн 59.3.5 дахь заалт:**

“59.3.5.өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн, Ширнэнбандийн Адьяа, Пүрэв-Очирын Анужин, Тилеуханы Аубакир, Энхтайвангийн Бат-Амгалан, Жамбын Батсуурь, Балжиннямын Баярсайхан, Гонгорын Дамдинням, Мөнхөөгийн Оюунчимэг, Бөхчулууны Пүрэвдорж, Цэдэвийн Сэргэлэн, Цэвэгдоржийн Туваан, Ганзоригийн Тэмүүлэн, Дамдины Цогтбаатар, Цэдэндамбын Цэрэнпунцаг, Нямаагийн Энхболд, Жаргалтулгын Эрдэнэбат. Цаашид ажлын хэсэг гэнээ. Энэ саналыг дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх хүн байна уу. Ирц санал хурааж болж байгаа юу.

Энэ дээр 1 дэх асуудал. Хөндөөгүй заалт хөндөж байгаа агуулгатай боловч анх оруулж ирсэн төсөл дээрээ энэ хуулийн зааснаас бусад хэсгийн 60 хувийг дараах итгэлцүүрийг харгалзан хуваарилна гээд 59.8 дээр ингээд нэмчихсэн юм байна тээ. Хууль дээр бол 59.3 хөндөгдөөгүй. Хууль дээр бол 59.3

байхгүй. Орон нутгийн хөгжлийн сантай холбоотойгоор Сангийн яам оруулж ирсэн төсөл дээрээ Орон нутгийн хөгжлийн санд жилийн гүйцэтгэлийн үр дүнгийн үнэлгээг үндэслэн санхүүжилт авч болно гэсэн байгаа юм л даа. Жилийн гүйцэтгэлийн үр дүнгийн үнэлгээ гэж байдаг юм уу. Энэ үнэлгээг тэгээд хэн хийдэг юм. Мижиддоржийн Санжаадорж дарга. 93

**М.Санжаадорж:** Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж. Улсын Их Хурлын даргын асуултад хариулъя. Тэгэхээр анх энэ Орон нутгийн хөгжлийн санг бол анх хэрэгжүүлж эхлэхдээ бол тогтвортой амьжиргаа гээд Дэлхийн банкны санхүүжилттэй төслөөр анх эхлүүлж байсан. 2015 оноос хойш тогтвортой амьжиргаа 3 төсөл явж байгаа. Энэ төслийн гол зорилго нь болохоор хэрэгжихүйц байгаад, иргэдэд үр дүнгээ үзүүлсэн байх байгаа юм. Тэгэхээр Дэлхийн банкнаас яаж явдаг вэ гэхээр, АМНАТ-ын 10 хувиас бүрдсэн орон нутгийн том хөгжлийн сангаас гадна жил болгон 3-5 сая доллар нэмж өгдөг байсан юм. Түүгээрээ маш сайн иргэдийн саналыг зөв журмын дагуу дүрэм, журмын дагуу авсан, дээрээс нь нөгөө төсөл нь ТЭЗҮ-тэй байгаад хэрэгжсэн, төсөл нь иргэддээ үр өгөөж хүрсэн ийм сумуудад нь үнэлээд, тэд нартаа урамшууллыг нь илүү нэмж өгдөг байсан. Нэмж өгдөг ийм систем бол одоо байгаа. Тэр нь болохоор Орон нутгийн хөгжлийн сангийн өөрийнх нь вэб сайт дээр ил тодоор байж байгаа. Одоо үнэлгээг нь бол Дэлхийн банкны тэр төсөл бол хэрэгжүүлээд явж байгаа. Ирэх жил Орон нутгийн хөгжлийн сан бол татан буугдаж байгаа. Төсөл нь дуусаж байгаа. Тэгэхээр энэ үнэлгээний

урамишууллыг нь бол цаашаа авч явах нь зүйтэй юм байна гэж манай яамнаас санал оруулж ирж байгаа юм. Яагаад гэхээр үнэлэхгүй болохоор дахиад цаашидаа энийг дахиж бүртгэдэг, бөглөдөг. Иргэдээс зөв зүйтэй санал авдаг энэ маань байхгүй болчих магадлалтай байна гэж үзсэн. Жишээ нь, зарим нэг аймаг дээр фэйсбүүкээр санал авсан ийм тохиолдол гарч байсан.

Хуулийн төсөл дээр бол Засгийн газраас орж ирсэн санал дээр бол жилийн гүйцэтгэлийн үр дүнгийн үнэлгээ гээд биччихсэн. Энэ бол маш том сонсогдоод байна. Энэ чинь бол нөгөө гүйцэтгэлийн санхүүжилттэйгээ холилдоод байна гэсэн учраас ажлын хэсэг дээр илүү тодорхой бичээд, өмнөх жилийн гүйцэтгэлийн үр дүн гэдэг байдлаар томъёолж оруулж ирсэн байгаа.

**Г.Занданишатар:** Гол асуулт нь жилийн гүйцэтгэлийн үр дүнгийн үнэлгээ гэж байдаг юм уу л гээд байгаа юм. Байдаг бол энийг өөрчлөх шаардлагагүй. Энэ санал хураалт хэрэггүй гэсэн үг. Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ гэж байхгүй учраас тодорхой болгож өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээ гэж 59.3.5 гэж шинэ заалт нэмж болж байна. Гэхдээ хөндөөгүй заалт учраас хөндөж орж ирэхээр тэр зөрчил дээр нь үндэслэхгүй бол 59.8, 59.9-ийг хөндсөн болохоос 59.3.5-ыг хөндөөгүй байгаа байхгүй юу. Яг зүйл, заалтаараа бол 59.3.5 өөрчилсөн заалт байхгүй л дээ. 59.3.5-ыг өөрчлөлт оруулах нь зөв гэж байгаа юм. Тодорхой болгох нь. Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ гэж байхгүй юм байна лээ. Жилийн гүйцэтгэлийн үр дүнгийн үнэлгээ гэж бүтэн жилээр нь үнэлсэн. Уг нь ажлын хэсгийн зөв байна гээд байна шүү дээ.

Гэхдээ энд үнэлгээ гэдэг юм байхгүй гэдэг үндэслэлээр л орохгүй бол хөндөөгүй заалт учраас хуулийн зөрчил гарах гээд байгаа юм л даа. Байхгүйг чинь ойлгож байж оруулъя.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяа, Жамбалын Ганбаатар, Хассуурийн Ганхуяг нарын урилгаар Баянгол дүүргийн ерөнхий боловсролын Орчон сургуулийн 10<sup>о</sup> ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Хүндэт багш, сурагчдадаа сурлага, спортын өндөр амжилт хүсэн ерөөе.

Санал хураалт явуулахад ирц болсон уу. Санал хураалт явуулъя. Ер нь бол Орон нутгийн хөгжлийн сангийн тухай хуульд тодорхой иргэдээс асуух, зөвлөлдөх, үр дүнгийн үнэлгээ энэ тэр хийх тодорхой заалт. Тэр жилийн үр дүнгийн үнэлгээ бодитой хийгдэхгүй байгаа л асуудал байна гэж байгаа шүү дээ. Санад хураалт. 66.0 хувийн саналаар санал дэмжигдлээ. Ингээд хуулийн зөрчлийг засах зорилгоор шинэ зүйл, заалт оруулж болох гэсэн дэгийн дагуу нэмж байгаа шүү. Тэгэхгүй бол хөндөгдөөгүй заалт.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг 2 дахь заалт болгон өөрчилж, тус заалтын 59.8, 59.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“59.8.Энэ хуулийн 59.1.2-т заасан эх үүсвэрээс энэ хуулийн 59.3.5-д заасан итгэлцүүрээр хуваарилагдах хөрөнгийг сумын орон нутгийн хөгжлийн санд шууд хуваарилна.

59.9.Энэ хуулийн 59.7, 59.8-д заасны дагуу орлогын шилжүүлгийг

тодорхойлсны дараа орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн үлдсэн хэсгийг энэ хуулийн 59.3.1, 59.3.2, 59.3.3-т заасан итгэлцүүрээр тодорхойлно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 68.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг 3 дахь заалт болгон өөрчилж, тус зүйлийн 60.2.10 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“60.2.10.энэ хуулийн 59.8-д заасан хуваарилалт.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 3 дугаар зүйлийг 2 дугаар зүйл болгон өөрчилж, тус зүйлийн 1 дэх заалтын 59.2.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“59.2.2.энэ хуулийн 59.8-д зааснаас бусад хэсгийн 60 хувийг дараах итгэлцүүрийг харгалзан хуваарилна:

59.2.2.1.хүн амын тоо;

59.2.2.2.нутаг дэвсгэрийн хэмжээ;

59.2.2.3.ашигт малтмал болон газрын тосны ашиглалтын талбайн хэмжээ.” Санал гаргасан ажлын хэсэг. Яахаараа ашигт малтмал газрын тосны ашиглалтын талбайн хэмжээ. Тэр чинь угаасаа АМНАТ-ын 10 хувийг үлдээж байгаа биз дээ. Ашиглалтын талбайг ярьж байна л даа. Хайгуул биш. Ашиглалтын талбайн

хэмжээ. Санал хураалт. 59.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нар уулзсан. Тэр гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх зөвлөлийг шилжүүлж авахаас эхлээд тэр хороо, зөвлөлийн үйл ажиллагааны журмыг тодорхой тогтоогоогүй, маш шүүрхий юмнууд их байгаа юм байна лээ шүү. Нэгжгийн хууль дээр. Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх мэдлийг хязгаарласан асуудлууд.

6.Төслийн 4 дүгээр зүйлийг 3 дугаар зүйл болгон өөрчилж, тус зүйлийн 7.9 дэх хэсгийн “төсвийн” гэснийг хасаж, “гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын” гэснийг “эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 4 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн “3.1.2, 4.1.3-4.1.10-т заасан нийтээр тэмдэглэх баярын болон” гэснийг “3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Одоо Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалт явуулна. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал байгаа.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 23.9, 23.10 дахь хэсэг, Тайлбарыг бүхэлд нь хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

**Б.Пүрэвдорж:** Улаанбаатар хотоос хөдөө, орон нутагт шилжээд, тэнд ажиллах юм бол зэрэг дэвийг нь 1 жил ажиллахад 1.6 жилээр тооцож олгоно гэж байгаа. Тэгэхээр энэ дээр ямар зөрчил гарч байна гэхээр хөдөө тэнд насаараа ажилласан хүн жил ажиллаад 1 жилээрээ тооцуулаад байж байдаг. Гэтэл хотоос очсон нэг нөхөр хажууд нь 1 жил ажилчхаад 6 сараар нэмэгдүүлээд яваад байхаар нөгөө зэрэг дэв нь нэмэгдээд, тэрнийхээ дагуу цалин нь ч нэмэгдээд бас ахлах албан тушаалтан дээр хурдан очих ийм боломж нь бүрдэх байхгүй юу даа. Тэгээд тэнд яг адилхан ажил хийчхээд нэг нь 1 жил ажиллаад 1.6-аар бодуулаад ингээд явахаар тэнд хүний эрхийн асуудал маш их гарч ирж байгаа байхгүй юу даа. Тэгээд энийг Төрийн байгуулалтын байнгын хороо дээр хэлсэн чинь Тогтохсүрэн дарга маш хурдан санаа аваад, энэ ерөөсөө Пүрэвдорж гэдэг нөхөр ёстой улс төржүүлээд аюулыг нь тарих юм байна гээд бушуухан шиг хассан байна. Баяр хүргэе. Ингээж хүмүүсийг дотор нь хуваагдуулсан, хүмүүсийг нэг нь нөгөөгөөс яг адилхан ажил хийж байхад ингээж ялгаварласан энэ зүйл чинь бол хүний эрхийн зөрчлийн хамгийн дээд хэлбэрт ордог. Тийм учраас энэ хасаж байгааг бол дэмжиж байгаа гэдгээ хэлье. Баярлалаа.

**Г.Занданиатар:** Гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна. Санал хураалт. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн дэмжсэн боловч эсрэг санал гарсан байна. Дэмжсэнээр тооцъё гэж протоколд тэмдэглэе. Өөрийнх нь гаргасан саналыг үндэслээд. 58.3 хувийн саналаар санал дэмжигдсэн.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 57.18 дахь хэсгийг бүхэлд нь

хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хороо дэмжсэн санал байна. Төсвийн байнгын хорооны саналаар санал хураалт. 58.3 хувийн саналаар санал дэмжигдэж, Төсвийн байнгын хорооны санал дэмжигдлээ.

3.Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.5.4 дэх заалтын “тагнуул,” гэснийг хассугай.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр. Санал хураалт. Баттөмөр гишүүн ээ, таны санал явж байна шүү. 58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн гарчгийн “НЭМЭЛТ” гэсний дараа “,ӨӨРЧЛӨЛТ” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр. Санал хураалт. Гишүүд анхааралтай.

**Л.Мөнхбаатар:** 60.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар хэлэлцье. Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “2025 онд 40, 2026 оноос 65” гэснийг “2025 оноос 65” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлье.

**Б.Пүрэвдорж:** Уул уурхайн орлогоосоо хуримтлал үүсгэх энэ

Ирээдүйн өв сангийн агуулгатай ийм сангууд бол анх 195 онд Кувейтэд бий болсон. Тэрнээс хойш Норвег хамгийн сайн жишээ болоод байгаа. Өнөөдрийн байдлаар 1 их наяд долларын дүрмийн сантай ийм Норвегийн хөгжлийн сан байгаа. Тэгээд энэ хөгжлийн сангаараа дамжуулаад том том компаниуд хөрөнгө оруулалт хийх замаар том том төслүүдийг санхүүжүүлэх замаар бас тодорхой хэмжээний сангаа арвижуулдаг ийм туршлагатай. Тэгэхээр манай Монгол Улсад Ирээдүй өв сангийн хуулийг батлаад 2030 он хүртэл ерөөсөө гар хүрэхгүй гэсэн ийм заалттай байсан боловч үе үеийн Засгийн газар гарч ирээд л ерөөсөө Ирээдүй өв сандаа гар дүрдэг ийм зүйл маш их болчихоод байна. Тэгээд өнгөрсөн жил гэхэд Ирээдүй өв сангийн орлого 0 байна гэж үзэж байгаад, тэрний хуримтлагдсан 1.4 их наяд төгрөгийг хүүхдийн мөнгөнд хуваарилаад явсан. Тэгээд эндээс 1.4 их наяд төгрөг Ирээдүй өв санд хуримтлагдах ёстой байтал тэрийгээ зарцуулаад, тэгээд төсвийн алдагдал бага гаргах ийм зүйлүүдийг хийж байгаа. Тийм учраас энэ хууль дээрээ сайжруулаад тэртээ тэргүй ирэх жил өөр Засаг байгуулагдах юм чинь гээд 2025 онд 40, 2025 оноос 65 гээд ингээд оруулаад ирж байгаа юм байна л даа. Өнөөдөртөө ингэж Ирээдүй өв санд бид нар түүхий эдийн үнэ өндөр өсөлтэй энэ үед бол бид нар аль болох л экспортын хэмжээ ч нэмэгдэж байгаа. Энэ үед аль болох л хуримтлал үүсгэж ирээдүйдээ бид нар хадгалж үлдэх ийм үүрэгтэй хүмүүс. Тэгэхээр гэнэт үнэ уначихвал яах юм. Ийм их тэлсэн төсөв тэрэнд сурсан төрийн алба, эд нар чинь хэрвээ уул уурхайн бараа бүтээгдэхүүний экспорт нь багасаад үнэ нь уначих юм бол ийм данхайсан төсвийг хэн авч явах юм. Монгол бол бүгдээрээ дифолт болох байхгүй юу даа. Тийм учраас Ирээдүй өв

сандаа бид нар хуримтлуулж байж дараа дараагийнхаа бас хойч үедээ энэ уул уурхайн орлого өндөр байгаа энэ үед бас хуримтлуулах тэр ажлуудаа хийх ёстой л гэж би үзэж байгаа. Тийм учраас сонгуулийн бус жил нь 0 болгож байгаад ашиглачихдаг юм байж, хойтноос эхлээд нэмэгдээд эхэлж байгаа юм байна. Энийг нь дэмжээд л явъя даа.

**Л.Мөнхбаатар:** Пүрэвдорж гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэллээ. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт. Бөхчулуун Пүрэвдорж гишүүн горимын санал гаргая.

**Б.Пүрэвдорж:** Би сая хуулийн 53 дах дээр 2025 онд 40, 2026 оноос 65 гэдгийг дэмжиж хэлсэн. Гэтэл төхөөрөмж ажиллаагүй эсрэг дарагдчихлаа. Дахин санал хураалт явуулж өгнө үү.

**Л.Мөнхбаатар:** Бөхчулууны Пүрэвдорж гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт. 56.2 хувиар санал дэмжигдлээ. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Үндсэн саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүдээ саналаа өгөөрэй. 64.6 хувиар санал дэмжигдлээ. Дараагийн санал хураалт.

4.Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Төслийн 2 дугаар зүйлийн “дуудлага худалдааны” гэж” гэсний дараа “,139 дүгээр зүйлийн 139.1.17 дахь заалтын “сонгон шалгаруулалтад”

гэснийг “дуудлага худалдаанд” гэж” гэж, “зураасан” гэсний дараа “болон түүнтэй адилтгах” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 62.5 хувиар санал дэмжигдлээ.

5.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал байна.

Төслийн 2, 3 дугаар зүйлийг нэгтгэж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийн “Тайлангаар баталгаажсан өмнөх жилийн албан татвар ногдох орлогын хэмжээ 50.0 сая төгрөгөөс хэтрээгүй нөхцөлд тухайн хувь хүн” гэснийг “Хувь хүн” гэж, 15.7 дахь хэсгийн “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангаж нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлсэн, энэ хуулийн дагуу хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх эрхтэй албан татвар” гэснийг “Энэ хуулийн дагуу хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх албан татвар” гэж,” 21 дүгээр зүйлийн 21.2.5 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1.6 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “20.1-д” гэснийг “20.1, 20.4-т” гэж тус тус өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

**Б.Пүрэвдорж:** Энэ урьд талын Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарчмын зөрүүтэй санал гараагүй учраас би олон нийтэд бас

хүргэх нь зүйтэй гэж үзлээ. Махны холбооны тэргүүнийхээ хувиар. Урьд нь бол мах малчин хүнээс авлаа гэхэд баахан бичиг баримт шаарддаг. НӨАТ төлөхгүй, тэгсэн мөртөө баахан бичиг баримт шаарддаг. Тэгэхээр малчид яадаг вэ гэхээр энэ бичиг баримтыг чинь бүрдүүлж чадахгүй гэдэг. Тэгэнгүүт нөгөө үйлдвэрлэгч яадаг вэ гэхээр баахан худлаа бичиг баримт бүрдүүлэх болдог. Тэгэхээр нөгөө НӨАТ-ыг чөлөөлсөн ч гэсэн тэр 2-ын хооронд харилцаа явдаггүй. Тэгээд яадаг вэ гэхээр малчин хүмүүс наадах чинь бүтэхгүй юм байна. Тэрний оронд бид нар ченжүүдэд өгнө гэдэг. Ченжүүд нь худлаа үнэн бичиг баримт бүрдүүлж байгаад үйлдвэрлэгчид өгчихдөг. Тэгээд энэ зохицуулалтыг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулснаар ишийдэж байгаа шүү. Өөрөөр хэлбэл үйлдвэрлэгч тухайн Пүрэвдорж гэдэг малчнаас 10 ширхэг хонь авлаа гэхэд тэр хүнийх нь нэрээр шууд худалдан авалтаа хийгээд бүртгэлд оруулаад и-баримт тэндээсээ татаад авчихна. Хамгийн гол нь малчин жилдээ 1 удаа л тэр татварын систем рү ороод тэрийгээ зөвшөөрөх тухай асуудал байгаа. Ингэснээр дундын ченжүүд байхгүй болно гэсэн үг. Дундын ченжүүд байхгүй болохоор малчнаас Улаанбаатар хотын эцсийн хэрэглэгч юм уу, аль эсвэл экспортод гарч байгаа тэр түүхий эд ямарваа нэгэн дундын ченжүүдгүйгээр явах ийм шууд худалдагчаас хэрэглэгч рүү хүрэх, малчнаас хэрэглэгч рүү хүрэх энэ боломжийг л бүрдүүлж энэ хуулиар зохицуулж өгч байгаа шүү. Тэгээд энэ эрх баригч нар сайн тайлбарлаж өгөхгүй байна. Махны холбооныхоо тэргүүнийхээ хувиар талбарлаад өгчихье. Сүү, хөөвөр, арьс шир, ноолуур, ноос бүгдээрээ орж байгаа шүү. Баярлалаа.



**Л.Мөнхбаатар:** Бөхчулууны Пүрэвдорж гишүүн Улсын Их Хурлын гишүүнээс гадна, Махны холбооныхоо тэргүүний хувиар байр сууриа илэрхийлж үг хэллээ. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт. Гишүүдээ саналаа өгөөрэй. 68.8 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлийг 3 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“3 дугаар зүйл.**Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, 2 дугаар зүйлийн 21.2.5, 25.1.6 дахь заалт, 27.1 дэх хэсгийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн, 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 23 дугаар зүйлийн 23.16 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 15.6, 15.7 дахь хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2030 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл, 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 23 дугаар зүйлийн 23.17 дахь хэсгийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2030 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл тус тус дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 68.8 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 20.4, 20.5 дахь хэсэг, мөн зүйлийн 2 дахь заалтын 23.17 дахь хэсгийн “нийслэл,” гэснийг “нийслэлийн болон” гэж тус тус өөрчлөх Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57.1 хувиар санал дэмжигдлээ.

6.Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн

талаар. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал байна.

Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

**“3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55.1 хувиар дэмжигдлээ.

7.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар хэлэлцүүлэг явуулъя. Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал байна.

1.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“3 дугаар зүйл.**Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 22 дугаар зүйлийн 22.5.15, 22.5.16 дахь заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2030 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл, 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 22 дугаар зүйлийн 22.5.17 дахь заалтыг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2030 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл, 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 18 дугаар зүйлийн 18.13, 18.14 дэх хэсэг, мөн зүйлийн 3 дахь заалт буюу 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэг, 2 дугаар зүйлийн 20.2.4 заалт, 24.5 дахь хэсгийн дугаарын өөрчлөлтийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн, мөн зүйлийн 26.15 дахь хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 71.4 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 18.13, 18.14 дэх хэсэг, 3 дахь заалтын 24.5 дахь хэсгийн “нийслэл,” гэснийг “нийслэлийн болон” гэж, мөн зүйлийн 2 дахь заалтын 22.5.15 дахь заалтын “цэс” гэснийг “цэсийн” гэж өөрчилж, 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 22.5.15, 22.5.16, 22.5.17 дахь заалтуудын “тус тус хөнгөлнө.” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 70 хувиар санал дэмжигдлээ.

8.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “татварын хуульд зааснаас бусад” гэснийг “Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25.8-д, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 24.5-д зааснаас бусад” гэж өөрчлөх.Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 70 хувиар санал дэмжигдлээ.

9.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар хэлэлцье. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 10.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, тус зүйлд доор дурдсан агуулгатай 10.4 дэх хэсэг нэмэх:

“10.3.Стратегийн орд эзэмшигч төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотой Монгол Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу нүүрсийг харилцан ашигтай, тогтвортой, урт хугацаанд худалдах

гэрээг байгуулахад энэ хуулийн 10.2 дахь хэсэг хамаарахгүй.

10.4.Энэ хуулийн 10.3-т заасан гэрээг байгуулахдаа тухайн бүтээгдэхүүний биржийн арилжааны дундаж үнийг баримтална.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 53.1 хувиар санал дэмжигдлээ.

10.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар хэлэлцье. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 8.15 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.15.Стратегийн орд эзэмшигч төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотой Монгол Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу уурхайн үйл ажиллагааны тасралтгүй, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор хайгуул-олборлолтын ажлыг хамтад нь гүйцэтгэх этгээдтэй арав хүртэл жилийн хугацаатай гэрээ байгуулахаар тендер зарлаж болно.”Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59.2 хувиар санал дэмжигдлээ.

11.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар хэлэлцье. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 18.1.10 дахь заалтыг хасах.Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал

хураалтыг хүчингүйд тооцлоо. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр 2016 оноос хойш өнөөдрийг хүртэл өнөөдрийн эрх баригч нар үе шаттайгаар төрийн байгууллагууд, түүний томилгоо, гаргаж байгаа шийдвэр, тэр бүх зүйлийг босоо тогтолцоотой болгож байгаа. Тэрний хамгийн оргил үе нь бол 2020 оны 12 сарын 10 дээр батлагдсан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль байгаа. Энэ хуулиар бол ялангуяа нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагааг хэтэрхий боомилсон, хаасан ийм шийдвэрүүдийг гаргасан. Үүний үр дүнд яаж байна вэ гэхээр ялангуяа уул уурхайн орд, түүнийг ашиглах гэж байгаа компани болон тэнд насан туршидаа амьдарч байсан ард иргэдийн хооронд янз янзын тэмцэл гардаг. Урьд нь тэндхийн иргэд нь тэр нэгжийн тухай хуулийг дагалдаж орсон Газрын тухай хуулийн заалтыг харуулж байгаад тэмцэл хийдэг байсан бол иргэдийн тэр тэмцэл хийдэг бүх заалтуудыг яг энэ батлагдсан хуулийн дагуу бүгдийг нь авч хаясан. Тийм учраас өнөөдөр иргэд уул уурхайн иргэдийн эрх ашиг зөрчиж байгаа тэр компаниудын эсрэг тэмцэхээр 50 мянган төгрөгөөр торгоод, 500 мянгаар торгоод, сүүлд нь баривчилна гэхээр тэр бүх залуучууд бүгдээрээ тэр тэмцлээ зогсоогоод алаг болж байгаа юм. Тэгээд энэ ер нь бол иргэдийн эрх ашигийг булааж авсан босоо тогтолцоотой болгосон энэ шийдвэр дахиад энэ Газрын тухай хууль дээр ороод ирж байна л даа. Ялангуяа нутгийн өөрөө удирдах ёсны гаргадаг энэ шийдвэрийн тэр байгууллага дээр бас төлөвлөгөө гаргадаг тэр бүх эрх мэдлийг нь ийшээ авчхаад энд нь тэгээд юу ч шийдэж өгөхгүй болохоор тэнд ямар ч ажил нь явахгүй ийм л нөхцөл байдал руу энэ хууль оруулах юм байна. Тэгээд нэртэйгээр нь зүгээр коммунизм байгуулна гээд л зарлачих л даа. Тэнд ард иргэд юм шийддэггүй, тэгээд л тэнд нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага

гээд нэр төдий тийм байгууллага болгож хувиргаад, тэндхийн ард иргэд нь хамгийн ойрхон тэр нутгийн өөрөө удирдах ёсдоо ханддаггүй, дарга нар руу л ханддаг. Босоо тогтолцоотой газар руу ханддаг ийм орон болгоод, хуучин социализмын үеэр тэгээд яв л даа. Тэгвэл бүр Үндсэн хуулиа өөрчлөлт хийсэн нь дээр шүү дээ. Та нар ингэж иргэдийн эрх ашигийг сэглэсэн ийм хуулийг 1, 1-ээр нь сэмхэн сэмхэн оруулдаг хэзээ болих юм бэ.

**Л.Мөнхбаатар:** Бөхчулууны Пүрэвдорж гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэллээ. Саналын томьёоллыг уншиж танилцуулсан байгаа. Санал хураалт явуулъя. 61.2 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 23.2.3 дахь хэсгийн “сумын газар зохион байгуулалтын” гэснийг “энэ хуулийн 25.1.4-т заасан” гэж өөрчилж, мөн зүйлийн 23.2.4 дэх заалтын “эрхлэх,” гэсний дараа “тухайн жилд” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 66 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийн 23.2.10 дахь заалтын “байгууллага, мэргэжлийн байгууллагад” гэснийг “байгууллагад мэргэжлийн байгууллагын” гэж өөрчлөн, “дүгнэлт өгөх” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 66 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар зүйлийн 23.2.15 дахь заалтын “Засгийн газарт” гэснийг “холбогдох хуульд заасан эрх бүхий этгээдэд” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 70 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 2 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 23.2.16 дахь заалт нэмэх:

“23.2.16.улсын тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалтыг эрхлэх;” Санал гаргасан

ажлын хэсэг. Санал хураалт. 69.4 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“5 дугаар зүйл.**Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 67.3 хувиар санал дэмжигдлээ.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргилын урилгаар Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуулийн харьяа Ерөнхий боловсролын ахлах сургуулийн 11 дүгээр ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдэд сурлага, хөдөлмөрийн өндөр амжилт хүсэн ерөөе.

Санал хураалтаа явуулъя. Төсвийн байнгын хороо дэмжээгүй санал байна. Гишүүд анхаараарай.

1.Төслийн 2 дугаар зүйлийн 23 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 23.2.23 дахь заалт нэмэх:

“23.2.23.төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил ашиглалтад байгаа газар дээр хууль бусаар баригдсан барилга объектыг төрийн өмчид хураан авах ажлыг зохион байгуулах.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд.Саналаа тайлбарлаж үг хэлж болно.

Шатарбалын Раднаасэд гишүүн үг хэлье. Зарчмын зөрүүтэй санал байна.

**Ш.Раднаасэд:** Энэ заалтыг гишүүдээ анхааралтай сонсож байгаач. Энэ уг нь төрийн өмчийн газрыг хамгаалж байгаа байхгүй юу. Хэн нэгний барьсан юмыг аваад нураагаад, төрд буцаагаад аваад байя гэж байгаа юм биш. Барих гэж байгаа бол тэрнээс нь урьдчилан сэргийлье. Хууль зөрчиж

төрийн өмчийн эмнэлэг сургууль цэцэрлэгийн газар дээр байшин барьж байгааг мэдэж байгаа хүмүүс шүүхийн шийдвэр гараад буруудчих юм бол төр авчих юм байна гэж ойлгож байгаа. Гишүүд яамаар юм бэ. Чинзориг сайдаа танай эмнэлгүүдийн хураагдсан газрыг хамгаалаад би юм яриад байна. Энэ хууль зөрчиж авсан газрыг чинь хамгаалж үлдэх гээд байгаа юм. Өнөөдөр эмнэлэг, сургууль, цэцэрлэгүүдийн газрын бүгдийг нь алдчихлаа гээд сууж байгаа биз дээ. Дахиж алдахгүй байхын тулд энийг чинь хамгаалалт болгож хийж өгч байгаа юм. Түүнээс барьсан болгоныг төрд аваад байя гэж байгаа юм биш. Энэ заалтыг дэмжээд энийг энэ хуульд хамаарахгүй яг энэ зүйлд хамаарахгүй гэж тайлбарлаад байх шиг байгаа юм. Тийм биш ээ. Энэ юмыг дүүргийн газрын алба юм уу, сумын газрын алба энийг хийж чадахгүй. Үнэхээр ийм агентлаг байгуулж байгаа бол энэ агентлаг гарсан шүүхийн шийдвэрийн дагуу тэр кадастрт нь өөрчлөлт оруулаад газрыг төрд нь буцааж авах юм байгаа юм. Миний мэдэж байгаагаар их сургуулийн тойрсон дандаа хувийн сургуулиуд, цэцэрлэгийг тойрсон дандаа хувийн цэцэрлэгүүд, эмнэлгийг тойрсон дандаа хувийн эмнэлгүүд байгаа. Энэ чинь өөрөө энэ эрүүл мэндийг чинь явуулахгүй байна. Энэ эмнэлгүүдийг чинь хөгжүүлэхгүй байна. Энэ эмнэлгийн дарга нар чинь тойруулаад барьчихсан лабораториудаа, оношилгооны төвүүд, эмийн сангуудаа ашигтай байлгахын тулд тэр эмнэлэгтэй холбоотой бүх л зүйлийг гацааж байна. Бүх хэлбэрээр. Ийм үл үзэгдэгч гар ажиллаад байна. Тийм учраас энийг дахиж цаашид гаргахгүй байхын тулд Газрын хуулийн энэ зүйл дээр 1 заалт л нэмж байгаа юм. Энийг дэмжихийг та бүхнээс хүсэж байна. Энийг дэмжихгүй байгаа гишүүд бол тэндээс ямар нэгэн байдлаар газар авсан юм байна гэж ойлгоё. Эсхүл газар олгосон юм байна гэж бас ойлгоё. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Раднаасэд гишүүн гаргасан зарчмын зөрүүтэй саналаа тайлбарлаж үг хэллээ. Энэ саналыг Төсвийн байнгын хороо дэмжээгүй санал байгаа. Раднаасэд гишүүний гаргасан санал гэсэн үг. Хэрвээ Улсын Их Хурлын чуулган дээр дэмжигдвэл Төсвийн байнгын хорооны санал дэмжигдэнэ. Дэмжигдэхгүй бол Раднаасэд гишүүний санал босно гэсэн үг. Санал хураалт. Ажлын хэсэг үг авах юм уу. Одоо энэ Раднаасэд гишүүний гаргасан санал дэмжигдсэн тохиолдолд Раднаасэд гишүүний гаргасан энэ саналаар бол төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа, ашиглалтад байгаа бүх газар дээр баригдсан бүх хувийн өмчийн объект барилгуудыг бол төр хурааж авах гэсэн ийм шийдвэр гарах гэж байна шүү дээ. Энэ дээр ажлын хэсгийнхэн үг авах юм уу. Ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн үг хэлье. Тогтохсүрэн даргын микрофоныг өгье.

**Д.Тогтохсүрэн:** Гишүүд ээ, та нар маш анхааралгүй байгаад байна. Саяны санал чинь ийм санал шүү дээ. Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй санал байхгүй юу. Тэр дэмжээгүй саналыг бид нар дэмжиж байж, энэ санал Раднаасэд гишүүний санал унах байсан юм. Би зүгээр ингээд байгаа юм. Раднаасэд гишүүний санаа бол маш зөв санаа. Гэхдээ энэ хэрэгжүүлэхэд маш хэцүү. Хүний хөрөнгийг бид нар ингээд хурааж авах шийдвэр гаргаж байгаа байхгүй юу. Яагаад хурааж авах гэж байна вэ гэхээр төрийн газар дээр баригдсан гэдгээр нь шууд хүний хөрөнгийг хураагаад авчаж байгаа байхгүй юу. Тэгээд Улсын Их Хурлаас хувь хүний хөрөнгөнд халдсан шийдвэр гаргах уу, үгүй юу гэдэг асуудал байгаа байхгүй юу цаанаа. Хамгийн том юм нь энэ байгаад байгаа юм аа. Би бол тэгж л, санаа нь бол зөв. Жишээлбэл энэ төрийн өмчит газруудыг ямар нэгэн хэлбэрээр худалдаж байна. Янз бүрийн юмнуудыг ойлгож байна. Гэхдээ энэ бол шүүхийн шийдвэрээр л явах ёстой. Шүүхийн шийдвэрээр. Тэрнээс

парламентын шийдвэр гаргаад хүний хөрөнгийг хурааж авч ерөөсөө болохгүй. Энэ парламентын зарчимд огт тэнцэхгүй байхгүй юу. Парламент чинь хүний хөрөнгийг хурааж авдаг байгууллага биш шүү дээ. Тийм учраас бид нар ийм шийдвэр гаргаж болохгүй. Тийм учраас сая эсрэг санал өгсөн гишүүд горимын санал гаргаад, энэ асуудлаар дахиж санал хураалт явуулах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл бид нар дэмжиж байж, Байнгын хорооны санал дэмжигдэх ёстой байсан байхгүй юу.

**Л.Мөнхбаатар:** Раднаасэд гишүүн ээ, дэгээрээ дэмжсэн 3, дэмжээгүй 3 хүн үг хэлнэ. Сая саналыг дэмжсэн 1, дэмжээгүй 1, 1 үг хэлсэн байна. Дахиж үг хэлж болно. 1 гишүүн 2 удаа үг хэлэх ойлголт байхгүй. Үг хэлэх хэн байна. Жаргалмаа гишүүн кнопоо дараарай. Улсын Их Хурлын гишүүн Жаргалмаа үг хэлье.

**Б.Жаргалмаа:** Түрүүн би яг өөрийнхөө ойлгож хууль хэлэлцэж эхэлж байх үед асуусан асуултдаа дахиад тайлбар хэлэх гээд байна л дээ. Сая Раднаасэд гишүүн хэллээ. Төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил, ашиглалтад байгаа газар дээр хууль бусаар баригдсан. Нэгэнт л хууль зөрчсөн бол энэ чинь хуулийн хүрээнд тухайн газар эзэмших эрх нь цуцлагдах ёстой биз дээ. Одоо Акуа гарден гээд яригдаад байгаа. Энэ дээр бас хуулийн хүрээнд шийдвэрлэгдэнэ гээд хотын даргын гаргасан шийдвэрийг хуулийн дагуу шийдвэрлэхээр шүүхийн шатанд явагдаж байгаа гэсэн ойлголт байгаа. Би юун дээр асуугаад байна гэвэл эмнэлгийн газраас гадна сургууль орчмын сургуулийн эзэмшлийн газрыг хууль бусаар хувийн хувийн компанид эзэмшүүлсэн тохиолдол манай улсад, нийслэл хотод байгаа. Түрүүн мэдээлэл өгч байсан. 166 сургуулийн 8 нь хувийн компанийн эзэмшилд газар нь шилжээд хувийн орон сууц болчихсон. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид биеийн тамирын талбайгүй болчихсон ийм

кейсүүд зөндөө байгаа. Би энэ кейс дээр тулгуурлаж, Раднаасэд гишүүний саналыг дэмжээрэй гэдэг саналыг хэлсэн. Хууль бусаар баригдсан барилга, объектыг. Нэгэнт л хууль зөрчөөд барьсан бол тэр өөрөө хуулийн этгээд хариуцлага хүлээх ёстой. Геронтологийн үндэсний төвийн барилгын асуудал ч гэсэн яригдаж байгаа. 6.8 тэрбум төгрөгийг 2011 оноос хойш ямар ч үргүй зарцуулчихаад тухайн компанийн өнөөдөр газраа авна гэж яриад байгаа байхгүй юу. Гэтэл энийг нь Үндэсний аудитын газар ашиглах боломжгүй болсон. Барилгын үнэ нь хэт өндөр өсчихсөн. Өнөөдөр баригдсан тэр барилгын 80 хувийн гүйцэтгэлтэй байгаа барилга нь ашиглах боломжгүй болчихсон. Тэгвэл бүхэл бүтэн төр байж газраа тэр хувийн компанид алдана гэсэн үг үү. Энэ жишиг дээр энэ саналыг дэмжсэн гэдгээ хэлье. Бусад гишүүд нь ойлгох биз ээ.

**Л.Мөнхбаатар:** Бейсен гишүүн кнопоо дараарай. Бейсен гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлье. Бейсен гишүүний микрофоныг өгөөрэй.

**Б.Бейсен:** Энэ Раднаасэд гишүүний санаа нь зөв л дөө уг нь. Гэхдээ бид нар сая Байнгын хорооны дэмжээгүй санал. Гэхдээ ийм асуудал байгаа юм. Би энэ хотын бүх клиникийн эмнэлгүүдээр явсан. 1, 2, 3, Хавдар судлал, Эх нялхас. Тэгээд бүх газрыг зарсан. Эмнэлгүүд өргөтгөл барих ямар ч боломжгүй байгаа л даа. Сургуулиуд мөн адилхан. Гэтэл үүний цаана хууль бус юм байвал энийг дэмжих нь зөв. Гэхдээ бүгдээрээ энэ олон жил болчихсон юм чинь бас хуулийн хүрээнд баригдсан байвал энийг сая Тогтохсүрэн даргын хэлдгээр парламентын хүрээнд шийднэ гэдэг чинь бас болохгүй асуудал байна. Шүүхээр шийдэхгүй бол.

**Л.Мөнхбаатар:** Раднаасэд гишүүний гаргасан санал дээр гишүүд дэмжсэн болон дэмжээгүй үг хэлж дууслаа. Раднаасэд гишүүн та үг хэлсэн л дээ. Дэмжсэн 3, дэмжээгүй 3 л саналын

томъёололтой холбоотой үг хэлэх ёстой юм. Ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн үг хэлье.

**Д.Тогтохсүрэн:** Энэ заалт дээр ажлын хэсэг ямар санал гаргаж байна вэ гэхээр гүйцээн боловсруулах чиглэл өгчих. Саяны санал нь хэвээрээ байж байгаа. Байнгын хороо дээр дахиж ярилцъя гэж бодож байна. Ер нь бол парламент хүний хөрөнгийг хураахтай холбоотой асуудлаар шийдвэр гаргаж хэрхэвч болохгүй. Хүний хөрөнгийг хураахтай холбоотой асуудлыг зөвхөн шүүхийн шийдвэрээр бид нар хандах ёстой. Бид нар тийм нийгэмд ажиллаж, амьдарч байгаа хүмүүс. Түүний үлгэрлэл нь бол би парламент байх ёстой гэж бодож байгаа юм. Тийм учраас манай гишүүд энэ дээр цаашидаа анхаарах хэрэгтэй байх гэж бодож байна.

**Л.Мөнхбаатар:** Хуулийн ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэнгийн саналыг үндэслээд Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 23 дугаар зүйл дээр гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. Ажлын хэсэг, Байнгын хороо дээр сайтар ярилцаарай. Дараагийн санал хураалтыг явуулъя.

12.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар хэлэлцье. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Төслийн гарчгийн “ӨӨРЧЛӨЛТ” гэсний өмнө “НЭМЭЛТ,” гэж нэмж, төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.2.8, 10.2.9 дэх заалт нэмсүгэй:

“10.2.8.бүх ангиллын кадастрын зураглалын стандарт,

технологийн аргачлал, дүрэм, журмыг батлуулан мөрдүүлэх;

10.2.9.газрын кадастр хийх нутаг дэвсгэрийн ээлж дарааллыг тогтоох, газрын кадастрын судалгааг гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд нь хяналт тавих;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Раднаасэд гишүүн үг хэлье.

**Ш.Раднаасэд:** Энэ түрүүн хууль бус болох нь тогтоогдох юм бол гэж. Монгол Улс түүхэндээ ганцхан барилга нураасан байдаг юм. Шүүхийн шийдвэрээр. Энэ барилгачдын талбай дээр барьсан 3 давхар байшинг. Саяын энэ өмнөх заалт дээр орж байгаа Газрын хууль ч гэсэн хууль бус болох нь тогтоогдох юм бол гэж би шүүхийн шийдвэрийн юм яриад байгаа байхгүй юу. Үүний цаана. Шийдвэртэй байж байж л нураана шүү дээ. Нураахгүйгээр барихаас нь өмнө тэрийг чинь тэгвэл одоо энэ авлига хороолол гэдэг ч юм уу тэр хорооллын 1, 2 байшинг нь нураана гээд. Тэрний цаана дахиад түмэн хүний хөрөнгө явж байгаа. Барихаасаа өмнө тэр хүн энэ хууль бус зүйл рүү орох юм бол би балрах юм байна. Тэр авчих юм байна шүү гэдэг агуулга мэдэж байгаа хүн хэзээ ч тэр рүү хүсэж тэмүүлж, барилга баръя гэж ярьж явахгүй байхгүй юу. Тийм учраас энийг авангуутаа шууд баригдсаныг нь бүгдийг нь төр авчих юм байна гэж. Энэ аймгийн Засаг дарга байсан учраас Тогтохсүрэн дарга энэ дээр их болгоомжлоод байгаа юм бас. Энд бол шүүхийн шийдвэр заавал цуг байгаа шүү гэдгийг гишүүд ойлгоорой.

**Л.Мөнхбаатар:** Тогтохсүрэн дарга үг хэлье.

**Д.Тогтохсүрэн:** Тэгэхээр ийм л юм л даа. Ерөөсөө газар нь өөр субъектийн өмч, объект нь өөр субъектийн өмч байж болно шүү дээ. Энэ нээлттэй асуудал байхгүй юу. Газар нь төрийн өмч. Объект нь хувийн өмч байж болно. Энэ өөрөө нээлттэй асуудал байгаа. Хаана ч байдаг зүйл. Өөр хүний газар дээр өөр хүн юм барьчихаад тэрийгээ газрын түрээсийн төлбөрөө төлөөд явдаг тохиолдол хэдэн арван зуугаараа байгаа шүү дээ. Тэгэхээр бид нар юу гэж хэлэх гэж байна гэхээр тэр газар бол хамаа байхгүй төрийн өмч буцаагаад болж болно. Дээр нь байгаа объектыг нураах тухай юм уу, төрд авах тухай асуудал байж болохгүй. Харин тэр нь хэрвээ авбал худалдан борлуулахтай холбоотой юм уу, түрээс юм уу энэ хэлбэр рүүгээ явна уу гэхээс биш хэзээ ч парламентын шийдвэрээр хүний хөрөнгийг авч болохгүй. Тийм учраас энэ дээр бол гэхдээ энэ байсан ч гэсэн энэ бол одоо цаашидаа ийм байгаа. Газар нь хууль бус өгөгдсөн байна гэлээ. Барилга нь ингээд барьчихсан барилгыг шууд төрийн өмч гэж болохгүй байхгүй юу. Тэр төрийн газрыг түрээслээд юм уу, тэгээд л байж л байна биз дээ энэ объект чинь. Тэр дотроо нөгөө нэг юм нь бол парламентын шийдвэрээр бид нар хэзээ ч хүний хөрөнгөнд халдаж болохгүй байхгүй юу. Парламент бол хүний хөрөнгийг хурааж авдаг газар биш. Энийг шүүхийн шийдвэр л гарах ёстой. Тийм учраас гишүүд энэ дээр уян хатан хандах ёстой. Би Раднаасэд гишүүний нэг сайн тал нь юу байна гэхээр төрийн газрыг худалдаад байгаа, түүгээрээ баяжсан авлигажсан энэ олон түшмэдийн буюу тэр байгууллагын даргын асуудал байгаа байхгүй юу. Тэгсэн тохиолдлууд зөндөө бий. Тэрэнд арга хэмжээ тооц гэдгийг бол шууд дэмжиж байгаа. Ганцхан хүний

хөрөнгийг авна гэдэг л болохгүй байгаа юм.

**Л.Мөнхбаатар:** Та 2 өмнөх санал хураалт дээрх зүйлтэй холбогдуулж үг хэлээд байна. Дараагийн санал хураалтад орчихсон. Тийм учраас санал хураалтын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт явуулъя. Өмнөх Раднаасэд гишүүний санал хураалтыг бол Төсвийн байнгын хороо дээрээ гүйцээн боловсруулах, дахин хэлэлцэх боломжийг олгосон байгаа шүү дээ. 61.7 хувиар санал дэмжигдлээ.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай 2, 3 дугаар зүйл нэмэх:

**“2 дугаар зүйл.**Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.8 дахь заалтын дугаарыг “10.2.10” гэж өөрчилсүгэй.”

**3 дугаар зүйл.**Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 9<sup>1</sup> дүгээр зүйлийг хүчингүй болгосугай. ”Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 72.9 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын сана хураалгая.

1.Төслийн 2 дугаар зүйлийн дугаарыг 4 дүгээр зүйл болгон өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 68.8 хувиар санал дэмжигдлээ.

13.Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар хэлэлцье. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай” гэснийг

“болон татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагууд” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 75.0 хувиар санал дэмжигдлээ.

14.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар хэлэлцье. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “бүхий QR код (лавлагаа авах холбоос)” гэснийг, тус зүйлийн “,мөн зүйлийн 5 дахь хэсгийн “энгийн” гэсний дараа “болон тусгай” гэж, 5.5 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “хугацаа” гэсний дараа “ажлын” гэж тус тус” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтыг хүчингүйд тооцъё. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлье.

**Б.Пүрэвдорж:** Зөвшөөрлийн тухай хууль батлагдсан. 1600 гаруй зөвшөөрлийг цэгцлээд 360 орчим болгосон. Энэ бол бизнест барьж байгаа том бэлэг гэж үзнэ. Өөрөөр хэлбэл энэ бол тодорхой хэмжээгээр төрийн дарамтыг бол маш бага түвшинд аваачиж байгаа. Тэгээд энэ зөвшөөрлийн тухай хуулиар нэг зүйлийг тодорхой болгож байгаа нь хэрвээ тухайн зөвшөөрлөөр хүсэлт гаргаад, 1 сар болох юм бол, 21 хоног ч байна уу хэрвээ албан тушаалтан хариу өгөхгүй байвал шууд тухайн бизнесээ хийгээд явах ийм боломжтой. Хуулиараа. Дээрээс энэ Зөвшөөрлийн хуульд зааснаас бусад үйлчилгээ бол тухайн иргэн ямар ч бизнесийг өөрийнхөө хүссэн цагаас эхлээд хийх боломжтой. Хэн нэгнээс зөвшөөрөл авахгүйгээр. Гэтэл энэ и-монголиа дотор и-бизнес гэж платформ нэмээд тэр дотроо нийслэлийн баахан үйлчилгээнүүдийг нэмчихсэн байна.



Тэгээд энэ мухлаг энэ тэр баахан юм нэмчихсэн. Тэгээд би сая Учрал сайдаас асуусан. Энэ манайх нэмээгүй, нийслэл нэмчихсэн байна. Нийслэлтэй учраа олоод хасаж байгаа гэж байна. Тэгэхээр ер нь бол энэ тийм очер дараалал үүсгэдэг, зөвшөөрөл өгдөг энэ юм дээрээ тэр дунд шатны албан тушаалтнууд чинь хэвээрээ байгаад байна шүү. Энэ хуулийг сайн тайлбарлах, өөрөөр хэлбэл иргэд тэртээ тэргүй нийслэлийн албан тушаалтнууд бол хуучин зөвшөөрөл өгч байсан тэр юм руугаа явах сонирхолтой байгаа. Гэхдээ иргэд нь хамгийн гол нь тэр ямарваа нэгэн зөвшөөрөл авахгүйгээр үйл ажиллагаа явуулж болж байгаа шүү гэдгийг л иргэдэд энэ хуулиа сурталчлан таниулах нь бол хамгийн чухал асуудал болоод байгаа. Энэ дээр Ганхуяг ажлын хэсгийн ахлагч энэ дээр яриад байдаг. Одоо Учрал сайдаа энэ асуудал дээр ялангуяа залуучууд бизнес эрхлэх маш их сонирхолтой байгаа шүү дээ. Та өөрөө залуу хүн. Тийм учраас яг тэр хүмүүс рүү энэ хуулийн гол утга агуулгыг сайн тайлбарлаж хүргэх нь бол таны чухал үүрэг шүү. Тэгээд би нэг зүйлийг л манаж байгаа. Зөвшөөрлийн хуульд заагаагүй өөр зөвшөөрөл нэхэж байгаа тэр албан тушаалтнуудтай шууд хариуцлага тооцоод явах ийм шаардлагыг нь тавина. Өөрөөр хэлбэл энэ чинь хуулийн хяналтыг хангуулах нь бас Улсын Их Хурлын гишүүдийн үндсэн үүрэг шүү дээ. Ганхуяг энэ тэрийг дээрэлхээд тэр витаминь зөвшөөрлийг гааль дээр нэхээд байна шүү дээ. Тэр гаалийнхаа албан тушаалтны нэрийг нь тэгээд ажлаас нь чөлөөлөөд өгье гэж байна шүү дээ. Сая Жавхлан сайд бол шууд хариуцлага тооцоод явах боломжтой гэж хэлж байна шүү дээ. Иймэрхүү хууль биелүүлэхгүй байгаа тэр албан тушаалтнуудыг чинь бушуухан шиг салах сонирхол бол хэн хүнд бүгдэд

нь л байгаа. Тэгээд зөвшөөрөл нэхэж байгаа тэр албан тушаалтан чинь бол нэг дарга байж таараа. Даргыг солих сонирхол бол та нарт бүгдэд нь байж байгаа шүү дээ. Тийм учраас хууль зөрчиж байгаа тэр нөхдүүдийг хурдан хурдан солиод оронд нь тэр ажиллая гэсэн тэр хүмүүсийг нь тавиад явсан нь дээр шүү дээ.

**Л.Мөнхбаатар:** Учрал гишүүн үг хэлье.

**Н.Учрал:** Пүрэвдорж гишүүнд баярлалаа. Би Пүрэвдорж гишүүн, Ганхуяг гишүүн нарт их талархаж байна. Тэгээд энэ Зөвшөөрлийн хуулийн хэрэгжилт дээр анхаарал тавьж байгаа нь бол их чухал юм. И-Монгол дээр и-бизнес гээд хуулийн этгээдтэй холбоотой зөвшөөрлүүд орсон. Үүн дээр Зөвшөөрлийн шинэ хууль батлагдсаны дагуу 208 зөвшөөрөл буюу энгийн тусгай зөвшөөрөлд орсон 208 зөвшөөрөл яам яамаараа байгаа. Энэ 208 зөвшөөрлийг авъя гэсэв цахимаар хүсэлт гаргаж байгаа. Гэхдээ тоон гарын үсгээ хэрэглэж байгаа. Энэ бол дэвшил гарсан. Хэнтэй ч уулзахаа больсон. Шууд хүсэлтээ илгээдэг болсон. Ингээд иргэд юу гэдэг байсан бэ гэхээр бид зөвшөөрлийг хүсдэг. Гэтэл нөгөө зөвшөөрлийн баримт бичгүүдийг чинь аваад шалгаж байна гэдэг нэрийдлээр хэдэн сар болдог. Зөвшөөрлийн хууль дээр нэг маш сайн заалт байгаа юм байна лээ. Хуульд заасан хугацаанд хариу ирүүлээгүй бол зөвшөөрөл өгсөнд тооцно гэж. Тэгэхээр эрх бүхий албан тушаалтнууд хэрвээ зөвшөөрлийг шалгаад хэрвээ хугацаандаа хариуг нь өгөхгүй бол шууд үйл ажиллагаагаа эхлэх эрх нь иргэдэд, хуулийн этгээдүүдэд нээлттэй. Энэ бол хүнд суртлын эсрэг авч байгаа том арга хэмжээ. Ингээд

байж байтал нэг шинэ нийслэлийн үйлчилгээнүүдийг нэгтгэж байна гэж онлайн бизнес төв гэдэг аппликейшн хийгээд онлайн бизнес төв бол өөрөө санаачилга нь зөв. Гэтэл зөвшөөрөл гэдэг нэргүй мөртөө яг зөвшөөрөл шиг үйлчилгээнүүдийг бараг 120-г энд оруулсан байсан. Ингээд хотын удирдлагуудтай яриад наадах чинь зөвшөөрөл биш, тэрбайтугай наадах чинь бүртгэл ч биш, наад үйл ажиллагааг чинь, наад кофе шопыг чинь, энэ дугуй засварыг чинь, мухлагийг чинь хэн ч хүссэн хүн үйл ажиллагаагаа хэнээс ч асуухгүйгээр хийх эрх нь Зөвшөөрлийн хуулиар оногдсон юм гэж хэлээд, нэлээд шахсан. Ингээд бас Их Хурлын гишүүд энэ Зөвшөөрлийн хуулийн ажлын хэсгийн ахлагч Ганхуяг гишүүн, Пүрэвдорж гишүүн энэ тэр бас нээрээ хань болж байна. Энийг бас олны анхааралд авч ирж ингэж ярьж байгаа нь бол маш чухал. Тийм учраас би энийг жоохон зоригтой, золбоотой үргэлжлүүлээд ажиллая гэж бодоод байна. Та 2 хамт байвал. Яагаад гэхээр энийг чинь очихоор проблем үүсдэг. Энийгээ зөвшөөрлөөсөө гарга гэхээр наадханы чинь ард стандарт байгаа, наадханы чинь ард үйлчилгээг нь шахаж шаардахгүй бол бараг л стандартыг зөрчөөд байна гээд байдаг байхгүй юу. Яг нөгөө дунд шатанд чинь нэг ийм хүндрэл үүсгээд байна шүү дээ яг үнэндээ. Энд хууль баталдаг нөгөө хууль чинь очоод газар дээр буухаараа хууль биш болчихоод байгаа байхгүй юу даа. Тийм учраас бид энэ Зөвшөөрлийн хуулийг хэрэгжүүлье. Энэ 260 зөвшөөрлийг нэмэгдүүлэхгүй байх бодлогыг харин барих ёстой шүү. Хувийн хэвшил өөрсдөө үйл ажиллагаагаа явуулна. Нэгэнт бизнесийн зарчим хүнээ цалинжуулаад, орлого олоод ажиллаж байвал ажиллаж болно шүү дээ. Тэртээ тэргүй тэр дүүрэг, орон нутаг нь

стандарт дээр нь аюулгүй байдал дээр нь хяналтаа тавиад л хамтраад ажиллаж байгаагаас хойш.

Тэгэхээр дараа 7 хоногт би ажлын хэсгийн гишүүд дээ хариуцлагатай хэлэхэд дараа 7 хоногийн 3 дахь өдөр гэхэд нийслэлийн 60 үйлчилгээг бизнесийн зөвшөөрөл огт биш. Энэ бол зөвхөн үйлчилгээ. Цахимаар тоон гарын үсгийг таниулаад хүсэлтээ л явуул, тэгээд болоо. Тэгээд л үйл ажиллагаагаа шууд эхэл. Яагаад тэр хүсэлтийг нь явуулахыг хүсэж байна вэ гэхээр нэгдсэн бүртгэл хөтлөөд явахгүй бол бас хаана хэдэн кофе шоп байгаагаа мэдэхгүй байж болохгүй учраас би кофе шоп байгуулж байна шүү гээд сануулахад болно. Тэгээд үйл ажиллагаагаа явуул гэсэн энэ зарчмаа баръя. Хэрвээ цаашидаа яамнууд, агентлагууд шинэ зөвшөөрөл нэмнэ гэвэл хуулиар л орж нэмэх юм байна лээ. Хуулиар орохгүйгээр хэн нэгэн зөвшөөрөл нэмэх боломж байхгүй.

Пүрэвдорж гишүүн би танд нэг зүйлийг хүсмээр байна. Яах вэ, энэ бол үйлчилгээ. Гэтэл зөвшөөрлөөс том бүртгэлүүд байна. Бүртгэнэ гээд заачихсан. Бүртгэхгүй бол үйл ажиллагааг нь зөвшөөрдөггүй. Зөвшөөрөл, бүртгэл 2 агуулгын хувьд өөр мөртөө яг амьдрал дээр бүртгэл бол яг л зөвшөөрөл болчихсон. Энэ олон байгууллагууд чинь дандаа бүртгэл хийж байгаа шүү дээ. Тэгээд бүртгэхгүй бариад суучихдаг. Шаардлагад нийцсэнгүй гээд. Тэгээд бүртгэхгүй бол үйл ажиллагаа эхлэхгүй юм чинь хувийн хэвшилдээ дахиад л хортой шүү дээ. Тэгэхээр ерөөсөө л энэ бүртгэлийг цэгцэлж өгөөч ээ Пүрэвдорж гишүүн ээ. Энэ ямар байгууллага нь бүртгэл хийгээд, ямар нь бүртгэл хийдэггүй юм. Ямар үйлчилгээ нь зөвшөөрөлгүй болоод ямар

нь зөвшөөрөлтэй байгааг ангилж өгөхгүй бол Зөвшөөрлийн хууль сайн хууль ч гэсэн бүртгэлийг цэгцлээгүйгээс болоод одоо бүртгэл нэртэй зөвшөөрлүүд төрийн хүнд суртлыг бас л бий болгосоор байна. Тийм учраас Зөвшөөрлийн хууль дээр ажилласан ажлын хэсэг үргэлжлүүлээд бүртгэлийг цэгцлэх ажлыг шийдвэрлэж өгөөч ээ гэж хүсмээр байна.

**Л.Мөнхбаатар:** Учрал сайд, Пүрэвдорж гишүүн, Ганхуяг гишүүн 3 бол Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад зоригтой, золбоотой ажиллах үүрэг хүлээж байгаа юм байна гэж ойлголоо. Энэ саналыг дэмжиж байгаа. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт. 62.5 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “бичиг” гэсний өмнө “олгоно.” гэсний өмнөх” гэж, мөн зүйлийн “өөрчилсүгэй.” гэсний өмнө “, 5.5 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “хугацаа 10 хоног” гэснийг “хугацаа ажлын 10 өдөр” гэж тус тус” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56.2 хувиар санал дэмжигдлээ.

15.Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар хэлэлцье. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Төслийн гарчгийн “,ӨӨРЧЛӨЛТ” гэснийг болон 2 дугаар зүйлийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58.3 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийг 2 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 52.1 хувиар санал дэмжигдлээ.

16.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар хэлэлцье. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Төслийн гарчгийг “Тогтоолд нэмэлт оруулах тухай” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56.2 хувиар санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

“1.“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын 4 дэх заалтын “26,” гэсний дараа “27,” гэж нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58.3 хувиар санал дэмжигдлээ.

3.Тогтоолын төслийн 1 дэх заалтыг 2 дахь заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Энэ тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60.4 хувиар санал дэмжигдлээ.

4.Тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмэх:

“3.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.” Санал гаргасан ажлын

хэсэг. Санал хураалт. 58.3 хувиар санал дэмжигдлээ.

17. “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар хэлэлцье. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дэх заалтын “төсвийн тухай хууль” гэснийг “төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 62.5 хувиар санал дэмжигдлээ.

18. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Төслийн тэмдэглэх хэсэгт “Монгол Улсын Засгийн газрын” гэсний өмнө “Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Бөхчулуун Пүрэвдорж гишүүн үг хэллээ.

**Б.Пүрэвдорж:** Би 2012-2016 оны хооронд Иргэний харьяат ижилжих хөдөлгөөний ерөнхий газрын дарга хийж байсан. Тэр үед бол А28 гээд клуб байсан. Өөрөөр хэлбэл 28 агентлагтай байсан. Яг өнөөдрийн байдлаар миний тооцоолсноор 41, 42 агентлаг байх шиг байна. Яасан ч олон яамтай болсон юм. Яасан ч олон агентлагтай болсон юм. Яг энэ дээр Шадар сайд Хүрэлбаатар сууж байна. Дээрээс нь Шадар сайд Амарсайхан сууж байна. Яг энэ хууль хэлэлцэх явцад Засгийн газрын Хэрэг эрхлэх газрынхан байдаггүй. Тийм учраас яг ажлаа мэдэж байгаа байлгүй дээ 2 дарга. Энэ чинь одоо өчнөөн олон жил Шадар сайд хийцгээлээ. Яг хэдэн

агентлаг байгаа юм. Тэрийгээ одоо бас яг тоогоор нь хэлээдэх дээ. Яг хэдэн агентлаг.

**Л.Мөнхбаатар:** Саналын томъёололтой холбогдуулж үг хэлдэг дэгтэй. Асуулт, хариулт бол байхгүй байгаа. Пүрэвдорж гишүүн үг хэллээ. Саналын томъёоллыг танилцуулсан. Ер нь бол Пүрэвдорж гишүүний асуусан асуултад Засгийн газрын Хэрэг эрхлэх газрынхан хариултыг нь өгөөрэй. Саналын томъёоллыг танилцуулсан байгаа. Санал хураалт. 59.2 хувийн саналаар дэмжигдлээ.

19. “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дэх заалтын “Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлж, төвлөрлийг сааруулах зорилгоор 2024 оныг “Хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжих” жил болгон зарласугай.” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Энхбаярын Батшугар, Ням-Осорын Учрал, Пүрэв-Очирын Анужин нарын урилгаар Сонгинохайрхан дүүргийн ерөнхий боловсролын Хөгжил ирээдүй сургуулийн 12 дугаар ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдэд сурлага, хөдөлмөр, спортын өндөр амжилтыг хүсэн ерөөе. Санал хураалтыг үргэлжлүүлэе.

2.Төслийн 2 дахь заалтыг 1 дэх заалт болгон өөрчилж, тус заалтын 11 дэх дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11/ Газрын багц хуулийн төсөл, түүнд нийцүүлэн Ашигт малтмалын тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон холбогдох бусад хуулийн төслийг боловсруулан 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 12 дахь дэд заалт нэмэх:

“12/төсвийн ил тод, хариуцлагатай байх зарчимд нийцүүлж төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрөөр төлөвлөн, хөтөлбөр, арга хэмжээний үр дүн болон үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлж түүнтэй уялдсан төсвийн зардлыг тооцож боловсруулж байх;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 2 дахь заалтын 5 дахь дэд заалтын “нийтлэг” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58.0 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 3 дахь заалтыг бүхэлд нь хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн 4 дэх заалтыг 2 дахь заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/-д тус тус даалгасугай:

1/орон сууцны ипотекийн зээлийн эрэлт болон төвлөрлийг сааруулах бодлоготой уялдуулан ипотекийн хөтөлбөрийн эх үүсвэрийг

нийслэл, орон нутагт үе шаттайгаар нэмэгдүүлэх;

2/ипотекийн зээлийн 60 хувийг хөдөө орон нутгийн иргэдийг орон сууцжуулах хөтөлбөрт хуваарилах;

3/агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах зорилгоор инженерийн дэд бүтцийн шийдэлтэй, нийт талбай нь 100 м<sup>2</sup>-аас ихгүй хэмжээтэй амины орон сууцыг орон сууцны ипотекийн зээлд хамруулах.”Санал гаргасан ажлын хэсэг. Улсын Их Хурлын гишүүн Бямбацогт. Энэ саналын 2 дахь дэд заалтыг Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн байна. Дэмжсэн 3, дэмжээгүй 3 хүн үг хэлнэ. Кнопоо дараарай. Нэлээн олон гишүүн байна. Дэмжиж байгаа, дэмжээгүйгээ үгийнхээ эхэнд хэлээд явна шүү. Тэгэхгүй бол олон гишүүн байгаа учраас дэмжсэн 3, дэмжээгүй 3 хүн л үг хэлэх боломжтой байгаа. Дэгээрээ тийм. Хассуурийн Ганхуяг гишүүн үг хэлье.

**Х.Ганхуяг:** Би энэ заалтыг Эдийн засгийн байнгын хороо дээр дэмжигдсэн саналыг дэмжихгүй байгаа юм аа. Бид нар яах вэ, түгжрэлийг сааруулна гээд орон нутаг дээр шууд багцлаад нийт ипотекийн сангийн 60 хувийг тийшээ зарцуулна гэдэг байж болохгүй асуудал. Угаасаа орон нутагт ипотекийн зээл, зээлийн хүү нь хөнгөлөлттэй байгаа шүү дээ. Тэгээд орон нутагт, дээрээс нь нийт зээлийн багцын 60 хувийг шилжүүлэхгүй бол энэ хотынх нь яах юм. Энэ хотод чинь талаас нь илүү хүмүүс энэ хотод нь амьдарч байна шүү дээ. Тэгээд энэ одоо ингээд яах юм хот хотод төрснөөрөө буруутай юм уу эсвэл хотод байр авч болохгүй гэж байгаа юм уу. Уг нь бид чинь гэр хорооллоо барилгажуулаад аль болох энэ барилгажуулалтын ажлаа нэмье л гэж Засгийн газар барьж байгаа бодлогоо бариад явж байгаа гэж ойлгож байгаа шүү дээ. Тэгээд энэ дээр би хотын гишүүдээ уриалах гэсэн юм аа. Энэ заалтыг бол дэмжмээргүй байна гээд. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Хассуурийн Ганхуяг гишүүн үг хэллээ. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлье.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр 2012-2016 оны хооронд нийтдээ 3,2 их наяд төгрөгийн ипотекийн зээлийг хэрэгжүүлсний үр дүнд нийтдээ 86 мянган айл ашиглалтад орсон байгаа. Тэгээд хэн дуртай нь очоод аль ч банк дээр очоод ипотекийн зээлийг хэн нэгэн даргын гуйлт хүсэлтгүйгээр авдаг байсан юм. Харамсалтай нь энэ санхүүжилтийг нь 2016 оноос хойш гацааснаас хойшоо Монголбанк хэдэн төгрөг өгдөг. Тэр нь нэг ойролцоогоор 4-5 мянган айлын орон сууцын ипотекийн зээл өгдөг. Тэрийг нь одоо яаж байна вэ гэхээр Монголбанкнаас арилжааны банк руу оруулчихдаг. Арилжааны банк дээр нэг зээлийн эдийн засагч, дарга захирлууд нь тэндээс одоо төр дээр бас авлига байгаад байвал бас эндүүрэл шүү. Хувийн банк, хувийн байгууллагууд дээр хүртэл авлигууд орчихсон байж байгаа. Тэгээд тэнд 10 хувиа өгсөн нь ипотекийн зээлд хамрагддаг ийм тогтолцоотой болчихсон байгаа яг өнөөдрийн байдлаар. Тэгэхээр энэ дээр бас тодорхой арга хэмжээ аваад, миний ойлгосноор бол 700 тэрбум төгрөгийг ирэх жил ипотекийн зээлд Монголбанк гаргах ийм үүрэг хүлээж байгаа юм байна. Энэ бол ойролцоогоор 20 мянган айлын орон сууц гэсэн үг. Энэ 20 мянган айлын орон сууцаар энэ тогтоолын заалтын дагуу зарчмын зөрүүтэй заалтын дагуу 12 мянгын буюу хөдөө, орон нутагт баригдсан 12 мянган айлын орон сууцыг ипотекийн зээлд хамрагдуулах ийм зорилт тавьж байгаа юм байна. Тэгээд энэ дээр нэг зүйлийг хэлэхэд жишээ нь, хамгийн их барилгажиж байгаа Ховд аймаг гэхэд бол жилдээ 1000-аад айлын орон сууц бас орж чадахгүй байгаа. Тэгэхээр яг энэ 12 мянга гэдэг чинь бас зөв үү буруу юу гэдэг дээр бас сая тэр Ганхуягийн хэлээд байгаа энд хамгийн гол нь Улаанбаатар хотод тэр хашааг барилгажуулах, байраар солих тэр хөтөлбөр чинь илүү ипотекийн зээлээр

дэмжигдэж байж энд утаа униар чинь арилж, алга болно, түгжэрэл алга болно гэдгийг л ойлгох ёстой юм байгаа юм. Тийм учраас яг энэ Засгийн газрын оруулж ирж байгаа энэ зүйлийг бол ипотекийн зээлийг нэмэгдүүлж байгаа учраас ойролцоогоор 5-20 мянгад хүргэж байгаа учраас би хагас дэмжиж байна. 1 дүгээрт.

2 дугаарт нь түрүүний хэлсэн нэг зүйлийг мартчихаж. Өөрөөр хэлбэл 2012-2016 оны хооронд 3,2 их наяд төгрөгийн ипотекийн зээл гарсан. Тэр нь жил болгон эргэн төлөлтөөр 400 тэрбум орж ирсээр байгаад, нөгөө 2012-2016 онд гарсан ипотекийн зээл чинь бүрэн буцаад төлөгдчихсөн байж байгаа шүү дээ. Тийм учраас энэ бол маш их үр дүнтэй арга. Энэ ипотекийн зээлийг бас ирэх жил орж ирэх тэр эргэн төлөлтөөс бас дахин санхүүжүүлэх хэрэгтэй. 700-аас бас нэмэгдүүлэх хэрэгтэй. Тэгж байж бид нар энэ барилгажих, орон сууцжуулах энэ хөтөлбөрийгөө, энэ зорилтыгоо бид нар илүү биелүүлж чадна л гэж харж байна. Тийм учраас энэ ипотекийн зээлийг нэмэгдүүлж байгаа, өөрөөр хэлбэл нэмэгдүүлж байна гэдэг чинь хүнд суртал, дараалал байхгүй болоод тэнд авлига, хээл хахууль багасна гэсэн үг. Тийм учраас би энэ агуулгаар нь дэмжиж байгаа шүү гэдгийг хэлье.

**Л.Мөнхбаатар:** Дэмжсэн 1, дэмжээгүй 1 гишүүн үг хэллээ. Одоо Сандагийн Бямбацогт гишүүн үг хэлье.

**С.Бямбацогт:** Би бас дэмжиж байгаа юм. Энэ агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах зорилгоор инженерийн дэд бүтцийн шийдэлтэй нийт талбай нь 100м<sup>2</sup>-аас ихгүй хэмжээтэй амины орон сууцыг орон сууцын ипотекийн зээлд хамруулах гэсэн саналыг гаргасан юм. Өнөөдөр үндсэндээ Улаанбаатар хот, 21 аймгийн төв бүгдээрээ утаатай болчихсон. Утаагаа шийдэх гээд үндсэндээ сүүлийн 20 жил оролдсон. Утаагүй зуух үзлээ, утаагүй түши үзлээ, шахмал түши үзлээ, хагас

кокс гээд үзлээ ерөөсөө бүгдийг нь. Ерөөсөө гал түлж л байгаа бол утаа гардаг юм байна. Тийм болохоор утааг шийдэхийн тулд бид нар гал түлэхгүй байх ёстой юм байна. Гал түлэхгүй байхын тулд ерөөсөө айл өрхүүдийг инженерийн шугам сүлжээнд холбоод ингэж шийдэж болох юм байна. Манай Ховд аймагт бол болж байгаа. 6000 орчим гал түлдэг яндан байдаг. Үүнээс 3000 орчим цэвэр, бохир усны шугамд холбогдох бололцоотой болчихсон. Одоогийн байдлаар 500 орчим айл холбогдож байна. Гал түлэхгүй, гадаа гарч бие засаж жорлон ухааж, хөрс бохирдуулахгүй, утаа гаргаж агаар орчин бохирдуулахгүй, хашиандаа хаустай, халуун хүйтэн устай, цэвэр бохир устай, хүлэмжтэй, хүүхдийн тоглоомын талбайтай, гарааштай амьдарч болж байгаа юм. Энийг л улсын хэмжээнд хийчих юмсан. Ингэхийн тулд бас тэр амины орон сууц чанартай, бага өртгөөр барьж байгаа хашиандаа хаус, амины орон сууц барьж байгаа иргэдийг дэмжье гэдэг агуулгаар энийг дэмжиж байгаа юм. Тийм болохоор метр квадрат нь яах вэ 100м<sup>2</sup> гээд тавьчихсан. Хэрвээ энийг их байна гэж үзэх юм бол 80м<sup>2</sup> байж болно. Шаардлагатай бол юу гэдэг юм метр квадратых нь үнэ нь 2.500.000-аас хэтрэхгүйгээр бас үнийн босго тавьж болно. Ийм байдлаар. Иймэрхүү байдлаар үндсэндээ хашиандаа, гэр хороололд гал түлж байгаа жорлон ухааж, хөрс бохирдуулж байгаа утаа гаргаж байгаа айлуудыг цэвэр, бохир устайтай, халуун хүйтэн устай, гал түлэхгүй, жорлон ухахгүй, хөрс бохирдуулахгүй, утаа гаргахгүй ийм л амьдрах бололцоо боломжийг бүрдүүлэх юмсан гэдэг агуулгаар энэ саналыг оруулсан юм.

Гэтэл энэ санал маань нөгөө ипотекийн зээлийн 60%-ийг хөдөө, орон нутгийн иргэдийн орон сууцжуулах хөтөлбөрт хуваарилна гэдэгтэй хамт орчхоод үүнээсээ болоод үндсэндээ хотын гишүүд дэмжихгүй уначих гээд байх шиг байна. Энийг бас салгаад

хураачхаж болохгүй юу. Ер нь бол бас юу яаж байгаа юм. Өнөөдөр орон нутагт ипотекийн зээл бол нийт авч байгаа ипотекийн зээлийн 15 орчим хувь нь л орон нутгийн иргэд ипотекийн зээл авч байгаа. Үлдсэн 80 гаруй хувь нь Улаанбаатар хотынхон авч байгаа юм. Тийм болохоор юу гэдэг юм, заавал хувь заахгүйгээр бололцоо бололцоогоороо аваад явах юм бол одоо дөнгөж 15 хувь байж байхад чинь 50 хувь хүрэхэд л хангалттай. Тийм болохоор юу гэдэг юм 1 зөв саналаа нөгөө хоорондоо зөрчилтэй саналаар ингээд давхарт нь чирээд битгий унагаачхаач, салгаж хураалгаж өгөөч ээ гэсэн саналыг хуралдаан даргалагчид гаргаж байгаа юм. Энэ саналыг салгаад хураалгаад өгөөч. Манай хотын гишүүд бол үндсэндээ 60 хувь гэдгийг дэмжихгүй байгаа ч гэсэн энэ агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах, жорлон ухахгүй байх, хөрсөө бохирдуулахгүй байх, гал түлэхгүй, утаа гаргахгүй байх энэ амины орон сууц хашиандаа барих хүмүүсийг дэмжих инженерийн шугам сүлжээтэй болохыг дэмжиж байгаа байх. Ингээд ийм зөрчилтэй л болчихоод байгаа. Тийм болохоор хуралдаан даргалагчийг энэ саналыг салгаж хураалгаж өгөөд ингээд бас ялгаад салгаад өгөөч л гэсэн ийм хүсэлтэй байна. Зарчмын хувьд дэмжиж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Сайнбуянгийн Амарсайхан, Цэндийн Сандаг-Очир нарын урилгаар Багануур дүүргийн 3 дугаар хорооны иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдийн ажил амьдралд хамгийн сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе.

Бямбацогт гишүүн гаргасан саналаа тайлбарлаж дэмжсэн үг хэллээ. Одоо Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн үг хэлье. Дэмжсэн дэмжээгүйгээ хэлнэ шүү.

**М.Оюунчимэг:** Статистикийн мэдээнээс харахад жишээ нь 2019 оноос

хойш нийслэл Улаанбаатар хотод 2004 зуугаад л айл түрээслээд өмчлөх орон сууцад хамрагдсан. Энэ нь дөнгөж 1,2%. Энэ бол дэндүү хангалтгүй бөгөөд дэндүү арчаагүй байна л гэсэн үг л дээ. Яагаад гэвэл гэр хорооллын иргэдийн манай нийслэл Улаанбаатар хот 1 сая 600 гаруй хүн амтай. Тэгээд өнөөдөр 70 гаруй хувь нь гэр хороололд амьдарч байна. Гэтэл агаар, хөрсний бохирдол өнөөдөр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн түвшинд хүрчихсэн байгаа шүү дээ. Хөрсний бохирдол нь өөрөө бүр худаг ус руугаа орчихсон. Энэ нь өөрөө хорт хавдар болон бусад өвчлөлийн үндэс болчихоод байгаа учраас орон сууцжуулах асуудал бол 1 номерын чухал.

Сая Бямбацогт гишүүний хэлдэг шиг яг Чингэлтэй дүүргийн 7 дугаар хороонд Сервис центр гээд 300 айл өрхийн дунд 1 дэд төв бий болгож үнэхээр айлууд өнөөдөр хашаандаа халуун, хүйтэн устай хауст амьдраад, дээрээс нь нөгөө байдал орчин нөхцөл нөхцөл өөрчлөгдөнгүүт иргэдийн амьдрах байдал нь ч шал өөр болчихсон. Дээрээс нь ажилтай, хөдөлмөртэй хүүхдүүд нь тэр соёл суралцах гэдгээрээ ч тэс өөр болж байгаа. Өрхийн орлогод хүртэл нөлөөлчихсөн байгаа. Тийм учраас энэ орон сууцжуулах хэсэгчилсэн дэд төвүүд барих энэ асуудал бол зөв байгаа юм. Туйлын чухал байгаа.

Харин сая тэр 60/40 гээд яахаараа орон сууц чинь хөдөө, орон нутагт дэд бүтэц нь ч өнөөдөр байхгүй байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр хөдөө яг бололцоотой шаардлагатай хүн амын тоогоос нь шалтгаалаад ипотекийн зээл юм уу орон сууцжуулъя. Улаанбаатар хотод 70 гаруй хувь нь байгаа гэр хорооллыг ингэе гээд иймэрхүү зүйл дээр тооцоо судалгаатай хийх хэрэгтэй байна шүү дээ. Тэгээд одоо болохоор бид нар хэн хэрэгжүүлэх юм, хэдий хэмжээний санхүүжилтийг нь ипотека дээр байгаа гэдэг нь ч байхгүй. Нөгөө алаагүй баавгай арьсыг хуваана гэдэг шиг ипотека дээр нь мөнгө нь байхгүй, нэмэлт санхүүжилт

тусгагдаагүй, улсын төсөв дээр ч байхгүй, нөгөө төрөөс баримтлах мөнгөний бодлого дээр ч тодорхойгүй байгаад байгаа. Тийм юман дээр өнөөдөр бид нар ингээд 60/40 гээд л баахан хоорондоо маргалдаад л байна л даа. Үнэхээр энийг ингэж хэрэгжүүлэх гэж байгаа гэвэл эхлээд хэн хэрэгжүүлэх юм, хэдий хэмжээний санхүүжилт нэмж тусгах юм гэдгийг тодорхой болгочоод энийг яримаар байна л даа. Одоо байгаа тэр ипотекийн зээлийн санхүүжилтийн хүрээнийх нь яривал хөдөө 2300-аад айл, Улаанбаатар хотод 2000-аад л иргэд хамрагдах ийм жоохон юмны тухай л яриад байгаа юм байна лээ шүү дээ. Санхүүжилт нь одоо байгаа энэ хүрээнд. Хэрвээ үнэхээр ийм том хэмжээгээр орон сууцжуулах бодлого явуулъя гэвэл тэгвэл эхлээд ипотекийн зээлийг нь нэмчих хэрэгтэй байна. Тэгээд энэ нь нэмэгдсэн юм уу, нэмэгдээгүй юм уу энэ нь ч одоо тодорхойгүй байгаад байгаа шүү дээ. Төсөв дээр лав ипотекийн зээлд тэд гэсэн мөнгө байхгүй. Төрөөс баримтлах мөнгөний бодлого дээр эх үүсвэр нь тодорхойгүй байгаа. Тэгэхээр одоо яаж хэрэгжүүлэх гээд байгаа юм. Эсвэл зүгээр бас нэг хэрэгжихгүй заалт гаргачих юм уу. Тэгээд энийгээ эхлээд тодорхой болгох шаардлагатай байна гэж хэлмээр байна.

**Л.Мөнхбаатар:** Сая та дэмжсэн дэмжсэн юм уу, дэмжээгүй юм уу. Үгүй ээ, яг дэмжсэн, дэмжээгүйгээ тодорхой хэлнэ шүү. Яаж ч магадгүй байгаа гэж бас. Содномын Чинзориг гишүүн үг хэлье.

**С.Чинзориг:** Би энэ заалтыг ерөнхийд нь зарчмын хувьд бол дэмжиж байгаа юм. Гэхдээ ер нь бол Оюунчимэг гишүүнтэй санал ойролцоо л юм хэлэх гээд байгаа юм. Өнгөрсөн жил бид нар 2023 оны Төрөөс мөнгөний талаар баримтлах бодлогын бичиг баримт батлахдаа Их Хурлын тогтоол гараад, 2023 оны 2 дугаар улиралд багтааж ипотекийн зээлийн хөтөлбөрийг Засгийн газар шилжүүлэн хүлээж авч хэрэгжүүлэх гээд тогтоол гаргачихсан.



Одоо тэгээд энэ чинь Засгийн газар хэрэгжүүлэх хөтөлбөр болчихоод байгаа юм уу, Их Хурал х хэрэгжүүлэх хөтөлбөр болчихоод байгаа юм уу гэдэг нь тодорхойгүй байгаад байгаа юм.

Мөнгөний бодлого ярьж байхад би бол ажлын хэсэг дээр ипотекийн зээлийн хөтөлбөрийг Засгийн газар шилжүүлэн хүлээж авах хүртэл хугацаанд Монголбанк энэ хөтөлбөрөө үргэлжлүүлэн хэрэгжүүлж бай гэсэн ийм заалт ажлын хэсэг дээр гаргаад яриад байгаа юм. Тэгэхээр энийг 1 хэсэг нь бол зөв гээд, 1 хэсэг нь ийм заалт оруулж болохгүй. Ийм заалт оруулбал наадах чинь мөнгө хэвлэх асуудлыг Их Хурлын тогтоолоор шийдэж өгөх гэж байна гээд ингээд бас Эдийн засгийн байнгын хороо дээр маргаан дагуулаад, тэгээд энэ эх үүсвэр нь яах вэ гэдэг асуудал, хэн хэрэгжүүлэх вэ гэдэг асуудал нь тодорхойгүй болчихоод байгаа юм. Тэгээд энийг бол бас нэг тийш нь шийдмээр байгаа юм. Би бол энэ Засгийн газар шилжүүлэн авах хүртэлх хугацаанд Монголбанк ипотекийн зээлийн хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж бай гэдэг тийм заалт бол зайлшгүй энд орох уу эсвэл тэр мөнгөний бодлого дээр орох уу тодорхой 1 хариуцах эзэнтэй болгож байж цааш явмаар байна. Нэг дэх асуудал.

2 дахь асуудал нь ер нь бол хөдөө, орон нутагт бид нар хөдөөгийн хөгжил, хөдөөгийн сэргэлт гээд Засгийн газар яриад байдаг. Улаанбаатар хотын түгжрэл гээд Улаанбаатар хотод байгаа иргэдийг хөдөө гарч ажиллаж амьдрахыг дэмжинэ. Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулна гээд яриад байдаг. Одоогийн энэ ипотекийн хөтөлбөрийн чинь санхүүжилтийг аваад үзэхээр нийт санхүүжилтийн чинь 16 хувь нь хөдөө, орон нутагт хуваарилагдаад, 84 хувь нь Улаанбаатар хотод хуваарилагдаад байгаа юм байна лээ. Тэгээд ийм санхүүжилтийн хуваариар ипотекийн зээл үргэлжлэх юм бол Засгийн газраа, Их Хурлаас

хэрэгжүүлж байгаа хөдөөгийн сэргэлт, хөдөөгийн хөгжлийг дэмжих бодлого хэрэгжихгүй энэ Улаанбаатар хотын түгжрэл, төвлөрлийг сааруулах ажил чинь бол явахгүй байгаа юм. Тийм учраас тодорхой хэмжээгээр тэр орон нутагт ипотекийн зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийн 60 хувийг орон нутагт хуваарилъя гэдэг ийм бас чиглэл Монголбанканд өгөх нь бол зүйтэй.

Монголбанкны 1 хийсэн арга хэмжээг би бол нэг их зөв бодлого ч гэж үзэхгүй байгаа юм. Улаанбаатар хотод ипотекийн зээл авахад 150 сая төгрөгийн зээл олгодог. Хөдөө, орон нутгийн иргэд зээл авахад 100 саяын зээл олгодог. Тэгээд энийг ярьж байгаад Монголбанк хөдөө, орон нутагт адилхан ипотекийн зээлд хамрагдаж байгаа иргэн бол санхүүжилт авах хэмжээг нь 150 болгочихсон юм байна лээ. Би бол хөдөө, орон нутаг гэж 1 иргэний авах санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлж ижил түвшинд аваачихаасаа өмнө эхний нийт санхүүжилтийн эх үүсвэрийн 60 хувийг хөдөө, орон нутагт өгдөг болгох хэрэгтэй. Тэгэхгүй адилхан 1 иргэний тэр орон сууцын зээлийн хэмжээг 150 болгочихвол одоо Даваасүрэн сайд мэдэж л байгаа байх. Хөдөө, орон нутгийн орон сууцын метр квадрат үнийг 1 одоо түвшинд очуулна л гэсэн үг. Өөрөөр хэлбэл хөдөө, орон нутгийн иргэдийн хөдөө баригдаж байгаа орон сууцын метр квадрат үнийг яг Улаанбаатар хотын үнэтэй ижилхэн болгоод ингээд хөдөөгийн баригдаж байгаа орон сууцын үнийг хөөрөгдөх ийм бодлого явууллаа гээд би бол Монголбанкныг жаахан зэмлээд байгаа юм. Ийм асуудлууд бол байгаа. Гэхдээ ер нь цаашидаа энийг би бол одоо санал хураах юм уу эсвэл гүйцээн боловсрох чиглэл авдаг юм уу ажлын хэсэг. Би 1 дүгээр заалтыг бол тэр эх үүсвэрийг хөдөө, орон нутагт үе шаттайгаар нэмэгдүүлэх гэх шаардлага бол байхгүй. Энийг нь бол аваад нийт ипотекийн зээлийн хөтөлбөрийн эх үүсвэрийг шийдвэрлэх гэдгээр найруулаад авчих

хэрэгтэй. 2 дахь заалтыг бол тэр ипотекийн зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийн 60 хувийг хөдөө орон нутагт гээд ингээд найруулаад авчих нь зүйтэй болов уу гэсэн ийм саналтай байна. Тийм учраас энийг одоо санал хураах юм уу эсвэл гүйцээн боловсруулах чиглэл аваад дахиж нэлээн редакцын үзээд, тэгээд тэр ер нь ипотекийнхоо зээлийг эх үүсвэрийг яаж нэмэгдүүлэх юм бэ гэдэг асуудал, 2 дугаарт ипотекийн зээлийг хэн хэрэгжүүлэх юм бэ гэдэг асуудал. Хэрвээ тэр өнгөрсөн жил мөнгөний бодлого батлахдаа гаргасан Их Хурлын тогтоол хэрэгжих боломжгүй гэж байгаа бол тэр Засгийн газраас шилжүүлэн хүлээж авах хүртэл хугацаанд Монголбанк нь хэвийн үргэлжлүүлэн хэрэгжүүлж байх гэсэн заалт оруулж өгөхгүй бол энэ чинь тэгээд хэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй болчихоод байгаа асуудлууд их одоо байгаа юм аа гэдгийг хэлье. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Ер нь яах вэ энэ заалтыг бид бас Байнгын хороо дээрээ эргэж сайтар ярих шаардлага бол байна. Энэ бас 2 зүйлүүдийг бас нэгтгэчихээр бас санал хураалт явуулахад бэрхшээл учраад байгаа юм байна. Ипотекийн зээлийн 60%-ийг хөдөө, орон нутагт иргэдийг орон сууцжуулах хэлбэрт хуваарилах гэсэн 1 агуулга байна. Нөгөөтээгүүр Бямбацогт гишүүний гаргасан санал байгаад байгаа юм байна шүү дээ. 100м<sup>2</sup>-аас ихгүй хэмжээний амины орон сууцыг ипотекийн зээлд хамруулах гээд энэ 2 асуудлуудыг нэгтгэчихсэн байгаад байгаа. Тийм учраас энэ дээр ажлын хэсэг үг авах уу. Ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн үг аваад, саналаа хэлчих.

**Д.Тогтохсүрэн:** Гишүүдийн хэлсэн саналтай холбогдуулаад энэ томъёолол дээр ажлын хэсгийн зүгээс дахин боловсруулах чиглэл авчихмаар байна. Тэгээд бид нар дахиж боловсруулж байгаад заавал тоо тавих ч шаардлагагүй дээ. Засгийн газар бол тэгш хүртээмжтэй гэдэг л байсан юм. Тоо тавихаар бас хэрүүл болоод баймаар

юм байна. Тийм учраас энийг нь би харгалзаж үзээд, ажлын хэсэг дахин боловсруулах чиглэл авах ийм саналтай байна.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42.2.1-д заасныг үндэслээд Байнгын хороо дээрээ дахиж ярих шаардлагатай гэж үзэж, гүйцээн боловсруулах чиглэлийг өгч байна. Дараагийн санал хураалтад оръё.

7.Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмэх:

“3.Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн дагаж мөрдөх хугацааг сунгах тухай хуулийн төслүүдийг 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.” Санал гаргасан ажлын хэсэг. Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал байна. Санал хураалт. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар суудалдаа сууя. Бейсен гишүүн санал хураалтдаа оролцъё. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт. 61.4 хувиар санал дэмжигдлээ.

8.Төсөлд доор дурдсан агуулгатай 5 дахь заалт нэмэх:

“5.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54.5 хувиар санал дэмжигдлээ.

20.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар хэлэлцье. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал:

1.Төслийг “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай

холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй нэгтгэж нэг төсөл болгон, төслийн 1 дэх заалтыг “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь заалтын 13 дахь дэд заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13/хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан болон тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, ачаа тээврийн урсгалыг сайжруулах, төмөр зам, нисэх буудал, авто зам, замын байгууламжийн сүлжээг өргөтгөн шинэчлэх, боомтын хүчин чадлыг сайжруулах, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийг нэмэгдүүлэх, Нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, төвлөрлийг сааруулах, шинэ суурьшлын бүс, хот байгуулах дэд бүтэц бий болгох болон төрийн үйлчилгээний салбарын төсөл хөтөлбөрийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хүрээнд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх асуудлыг судлан шийдвэрлэх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтыг цуцаллаа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлье. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Пүрэвдорж гишүүний микрофоныг өгье.

**Б.Пүрэвдорж:** Энэ заалт дотор боомтын хүчин чадлыг сайжруулах гэж байгаа. Тэгэхээр боомтын хүчин чадлыг сайжруулах агуулга дотор чинь 2 зүйл ордог юм. Нэгэнд нь боомтын менежмент, нөгөөдхөд нь боомтын хөрөнгө оруулалт яг энэ хувийн хэвшилтэй хамтран ажиллах хүрээнд. Тэгэхээр энд аль алийг нь хувийн хэвшилээр

хийх боломжтой. Өөрөөр хэлбэл боомтын менежментийг хөрөнгө оруулалтыг хийсэн жишээ бол манай сая нэг хэд хэдэн сайд нараас боомтыг хувийн компанид менежментээр өгч болох уу гээд асуусан чинь болохгүй гэж байна. Тэгээд 1 хэвчимэл ойлголтоосоо салах хэрэгтэй байгаа юм. Тэгэхээр боомтын менежментийг өгч байгаа жишээ бол манай яг хажууд байна шүү дээ. Хөшигийн хөндий. Хөрөнгө оруулалтыг нь хувийн хэвшилээр хийлгэчихсэн. Зээлээр хийсэн ч гэсэн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийлгэчихсэн. Дээрээс нь менежментийг нь тэр Японы компанид өгчихсөн байж байгаа. Тэгээд бас энэ Хөшигийн хөндий чинь бас сүрхий ажиллаад байгаа. Одоо нөгөө бидний нислэгийн хүчин чадал маш их нэмэгдсэн учраас тэнд нэг хүнд суртлын арилгасны үндсэн дээр олон нислэг явдаг болчихоод тэнд хүчин чадал нь багадаад байгаа юм. Хуучин нөгөө дарамттай байх үеийн цөөхөн нислэг байсан бол тэр хангалттай л даа. Тэгтэл өнөөдөр хүчин чадал нь их болоод асуудал үүсгээд байгаа юм. Тэгэхээр энэ боомтын хөрөнгө оруулалтыг хийх тэр эрхийг нь хамгийн гол нь энэ дээр бүр тодорхой нарийн зааж өгөх хэрэгтэй байна. Хувийн хэвшлийн байгууллагаар хөрөнгө оруулалтыг нь хийж болно. Тэгээд тэр хөрөнгө оруулалт хийсэн компани нь менежментийг нь аваад тодорхой хугацаанд ажиллах ийм эрхийг нь өгөх хэрэгтэй.

Тэгэхээр би энэ дээр нэг зүйлийг хэлэх гээд байгаа юм. Нэгэнт бид нарт Хөшигийн хөндийг менежментээр тэр боомтын үйл ажиллагааг зохицуулах эрхийг нь өгчихсөн юм чинь бид нар хилийн нэг боомт дээр, хуурай замын нэг боомт дээр бид нар менежментээр тэр боомтын үйл ажиллагааг сайжруулах

тэр эрхийг хувийн хэвшилд өгөөд үзэх хэрэгтэй. Би жишээ нь Ховд аймгийн Байтагын боомтыг менежментийн гэрээгээр өгөөсэй гэж бодож байна. Хэрвээ тэгэх юм бол тэр АН2 гээд босоо тэнхлэгийн замд 70км замд тэр менежментийн компани нь дор нь замыг нь холбочихно. Дээрээс нь тэр боомтынхоо барилга дэд бүтцийн асуудлыг бүрэн шийдчихнэ. Ингэсний үр дүнд жилд 5 машин, 10 машин гардаг тэр Байтагын боомтыг хамгийн багадаа өдөрт 100 автомашин гардаг ийм боомт болгож чадах байхгүй юу даа. Энийг хувийн хэвшлийнхэн л хийнэ. Энийг төр өнөөдөр боомтоор ямар ч менежмент хийхгүй юу ч хийхгүй жилд 5, 10 машин гаргадаг ийм боомт болгож хэдэн жил тэнд боомт нэртэй явуулах ийм зүйлийг төр л хийж байна шүү дээ. Тэгэхээр энийг хэрвээ боомтын менежментийг хувийн хэвшилд аваачиж өгөх юм бол яг энэ хөрөнгө оруулалтаа бүрэн хийгээд, дээрээс нь тэрүүгээр ачаа эргэлтийг сайжруулаад, тэр ярантын боомтын нийт хөдөлгөөний 80 хувьд нь хүргэх ийм боломж нь хангалттай байгаа байхгүй юу даа. Тэгэхээр яг ийм эрхүүдийг яг энэ боомтын хүчин чадлыг сайжруулах тэр агуулга дотроо хөрөнгө оруулалтыг нь хийх, менежментийг нь хийх энэ 2-ыг нь бас нарийвчлан тусгаж өгөхийг бас хүсэж байна.

Тэгээд энэ дээр яг энэ эцсийн хэлэлцүүлэг дээр бас тодорхой гүйцээн боловсруулах чиглэл дарга нэг өгчхөөч ээ. Тэгээд мэдээж сөрөг хүчин учраас намайг дэмжихгүй байж магадгүй. Тэгэхдээ Байнгын хороон дээр ярилцаад үзье. Тэгээд та нар дэмжвэл тэр биз, дэмжихгүй бол тэр биз.

**Л.Мөнхбаатар:** Сэргэлэн гишүүн үг хэлье.

**Ц.Сэргэлэн:** Баярлалаа. Би энэ дээр нэг тайлбар хэлье. Ялангуяа авто замын боомтын тал дээр бол. Зүгээр Пүрэвдорж гишүүний хэлж байгаа дээр бол энэ Хөшигийн хөндий, Чойбалсан байдаг юм уу өөр юу байдаг юм Улаангомын, Хөвсгөлийн гээд олон улсын чанартай агаарын замын боомтууд бол болно. Монгол Улс өөрөө нэг онцлогтой байдаг. 2 хөрш оронтойгоо хуурай газраар хиллэдэг орон. Хуурай газрын авто замын боомт өөрөө газар нь төрийн мэдлийн тусгай хэрэгцээний газар байгаа. Ийм газар дээр хувийн хэвшил хөрөнгө оруулалт хийсэн тохиолдолд оруулсан хөрөнгө оруулалтынхаа үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ авахаас эхлээд асар олон зүйл энэ дээр зөрчилдөнө. Харин менежментийн асуудал нь яаж болдог юм бэ гэвэл энэ дээр асуудал ярьж болох байх.

Тийм учраас Монгол Улсын газар нутгийн зах хязгаарыг хөрш орны газар нутгийн зах хязгаартай яг хиллэж байгаа тэр хилийн хэсэг дээр байгаа хилийн боомт дээр хөрөнгө оруулалтыг яаж хийх вэ гэдэг бол энэ үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудал шүү. Тийм учраас нухацтай авч үзээрэй. Сэтгэлийн хөөрлөөр хийж болохгүй вэ гэдгийг л би хэлэх гэсэн юм. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Энэ бол Засгийн газарт чиглэл өгч байгаа Улсын Их Хурлын тогтоолын төсөл шүү дээ. Тийм учраас Засгийн газар сая Пүрэвдорж гишүүний хэлсэн энэ агуулгаар нь судалж үзээд холбогдох арга хэмжээ авах нь бол нээлттэй байгаа. Их Хурлаас бол тодорхой чиглэл өгч байгаа ийм тогтоолын төсөл гэдгийг бас та бүгдэд сануулан хэлье. Саналын томъёоллыг

унишиж танилцуулсан. Санал хураалт 57.8 хувиар санал дэмжигдлээ.

*Найруулгын санал хураалгая.*

*1.Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллууд дэмжигдсэнтэй холбогдуулан эдгээр хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн зүйл, хэсэг, заалтын дугаарыг өөрчлөх, агуулга зарчмыг хөндөхгүйгээр үг хэллэг, найруулгын шинжтэй засвар хийх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 53.3 хувиар санал дэмжигдлээ.*

*Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.*

*Монгол Улсын 2024 оны төвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.*

*16.23 цаг.*

***Дараагийн асуудалд оръё. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/-ийг явуулъя.***

*Одоо санал хураалттай байгаа шүү. Гишүүд хүлээж байгаарай. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулъя.*

*Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Цогтбаатар дарга горимын санал гаргая. Хууль зүйн байнгын хорооны дарга Дамдины Цогтбаатарын микрофоныг өгье.*

***Д.Цогтбаатар:*** *Баярлалаа. Манай Байнгын хороо Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан ер нь бол цаг наргүй ажилласан. Гэхдээ яах аргагүй энэ дээр нэлээн хэдэн зөрүүтэй саналууд орж ирээд байгаа тул анхны хэлэлцүүлэгт буцааж өгөөч гэдэг горимын санал гаргаж байна. Энэ дээр санал хураалгаж өгөөч ээ.*

***Л.Мөнхбаатар:*** *Хууль зүйн байнгын хорооны дарга Дамдины Цогтбаатарын гаргасан горимын саналаар санал хураалгая. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41.8-д зааснаар нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг дахин явуулах шаардлагатай гэж хуралдаанд оролцогчдын олонх үзэх юм бол анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороонд буцаах дэгтэй. Тийм болохоор санал хураалтыг явуулъя. Гишүүд санал хураалтаа бэлтгээрэй.*

*Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Дамдины Цогтбаатарын саналаар Эрүүгийн хуулийн холбогдох төслийг Хууль зүйн байнгын хороогоор дахин хэлэлцэх гэсэн горимын саналыг дэмжье гэсэн саналтын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 60 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал дэмжигдсэнтэй холбогдуулаад Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах холбогдох төслүүдийг Хууль зүйн байнгын хороонд*

анхны хэлэлцүүлгийг дахин явуулахаар шийдвэрлэлээ.

16.27 цаг.

**Дараагийн асуудалд оръё.**  
**“Хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаарх” Улсын Их Хурлын хяналтын сонсголын тайланг сонссон талаарх санал, дүгнэлтийг хэлэлцье.**

Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Цэрэнжамцын Мөнхцэцэг танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**Ц.Мөнхцэцэг:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Мөнхцэцэг нарын 20 гишүүнээс Улсын Их Хурлын дарга Занданшатарт хандан Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын асуудлаар ерөнхий хяналтын сонсгол явуулах санал гаргах тухай 2023 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 03/7749 дугаар албан бичиг, Улсын Их Хурлын гишүүн Баярсайхан нарын 17 гишүүнээс Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, Хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүргийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах, Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн хэрэгжилтийн асуудлаар сонсгол явуулах тухай 2023 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 03/7750 дугаарт албан бичгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлийн 116.4 дэх хэсэгт заасны дагуу хүүхдийн эрхийг хамгаалах, хангах асуудлаар Улсын Их Хурлын хяналтын сонсгол зохион байгуулах шийдвэр гарсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.2 дахь хэсэг, Нийтийн сонсголын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Монгол

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.4 дэх хэсэгт заасны дагуу хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаарх хяналтын сонсголыг зохион байгуулах тов тогтоож, сонсголыг 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт Байнгын, дэд хорооны гишүүдийн 3/1-ээс доошгүй нь оролцсоноор тухайн сонсголыг хүчинтэйд тооцно гэж заасан бөгөөд сонсголд Улсын Их Хурлын гишүүн Мөнхцэцэг, Адьшаа, Мөнх-Оргил, Учрал, Энхбаяр, Сүхбаатар, Раднаасэд, Энх-Амгалан нар оролцож, хуульд заасан шаардлагыг хангасан бөгөөд хяналтын сонсголд төрийн байгууллага болон аж ахуйн нэгж, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн төлөөлөл зэрэг 90 гаруй оролцогч, 12 ажиглагч оролцсон.

Хууль зүйн байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаараа хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаарх Улсын Их Хурлын хяналтын сонсголын тайланг сонсож дараах санал, дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

Хүүхдийн эрхийг хамгаалах, хангахад шаардлагатай мэргэжлийн тогтолцоог бүрдүүлэхэд гарч байгаа хүндрэлтэй асуудлуудыг судлан тогтоож, шаардлагатай бол хууль тогтоомжийн зохицуулалт өөрчлөлт оруулах замаар төрийн бус байгууллагатай хамтран болон гэрээлэн ажиллах арга замыг судлах;

Хүүхдийн эрхийг хамгаалах хангахад нөлөөлж буй суурь шалтгааныг тогтоох;

Хүүхдийн бие бялдрын хүмүүжлийн асуудлаас гадна цахим хэрэглээ оюуны боловсролын асуудалд

нөлөөлөх арга хэмжээг бодлогын түвшинд тогтоож үүнээс үүдэлтэй сэтгэцийн асуудалд урьдчилан сэргийлэх талаар үе шаттай арга хэмжээ авах;

Хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг, мэдээллийг олгох, энэ чиглэлээр сургалт, сурталчилгаа, бусад арга хэмжээг зохион байгуулахад шаардлагатай эрх зүйн зохицуулалтын уялдааг хангах, боловсронгуй болгох талаар шаардлагатай арга хэмжээг авах;

Хүүхдийн эрхийн хамгаалах хангах асуудлыг өргөн хүрээнд авч үзэж цогц байдлаар шийдвэрлэх нь ирээдүйд бий болох хүн амын нийгмийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийн чанарын асуудал чухал болохыг анхаарах;

Хүүхэд хамгааллын чиглэлээр зарцуулсан төсвийн зарцуулалт, түүний үр дүнгийн талаар холбогдох байгууллагуудын мэдээллийг сонсох зэрэг болно.

Дээрх асуудлыг хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүн Энх-Амгалан хүүхдийн үзэж байгаа кино контентод хяналт тавих боломжтой эсэх, хүүхдийн сурч байгаа орчин, идэж байгаа хоол, хүнсний талаар авах арга хэмжээний тухай, хүүхдийг цахим орчинд хамгаалах хууль, эрх зүйн орчныг хэрхэн бүрдүүлэх талаар ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганбат хүүхэд илчлэгтэй хоол хүнс хэрэглэж чадаж байгаа эсэх, хүүхэд хамгааллын төсвийн талаар тус тус үг хэлсэн болно.

Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатар хүүхэд хамгааллын чиглэлээр хүний нөөцийн асуудал, хүүхэд хамгааллын төсвийн тогтолцоо, санхүүжилтийн талаар тогтвортой бодлого барьж ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганбат сургуулийн нэг ангийн дүүргэлт хэтэрсэн, хүүхдийн нарийн мэргэжлийн эмчийн бэлтгэх тогтолцоо байхгүй байгааг анхаарч

ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар хүүхдийн эрхийн хамгаалах тогтолцоог анхаарч ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил хүүхдийн эрхийн хамгаалах, хангахтай холбоотой асуудлаар болон сонсголын үр дүнгийн талаар холбогдох байгууллагад үүрэг чиглэл өгөх Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг санаачлан боловсруулж, хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналуудыг гаргасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүүхдийн эрхийн хамгаалах, хангахтай холбоотой асуудлаарх Улсын Их Хурлын хяналтын сонсголын тайланг сонссон талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Мөнхцэцэг гишүүнд баярлалаа.

Зочин танилцуулья. Улсын Их Хурлын гишүүн Гарибалын Амартүвшин, Даваажанцаны Сарангэрэл, Тогмидын Доржханд нарын урилгаар Хөдөө аж ахуйн их сургуулийн оюутнуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдийн ажил хөдөлмөрт хамгийн сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу. Байхгүй байна. Оюунчимэг гишүүнээр тасаллаа. Гонгорын Дамдинням гишүүнийг нэмье. Дамдинням гишүүнээр тасаллаа. Балжиннямын Баярсайхан гишүүн асуулт асууж, үг хэлье.

**Б.Баярсайхан:** Баярлалаа. Бид нар хүүхдийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр Улсын Их Хуралд Хууль зүйн байнгын хорооны хурлаар хүүхдийн эрхийг хангах асуудал ямар байгаа

хэмжээнд хяналтын сонсгол хийсэн. Тэгээд хяналтын сонсгол хийгээд дараа нь цаашаа яах вэ. Яаж энэ асуудалд ахиц дэвшил, бодитой үр дүн гаргах вэ гэдэг асуудал өнөөдөр бидний өмнө үлдсэн. Тэгэхээс биш зүгээр хяналтын сонсгол хийгээд ингээд асуудал хэвээрээ байвал энэ ямар ч үр дүнгүй байна гэсэн үг. Жишээлбэл өнөөдөр 2024 оны төсвийн тухай хуульд хүүхэд хамгааллын мөнгийг бараг 2 дахин нэмэх буюу 14,3 тэрбум төгрөг болгох гэж байна. Энэ төсвийг юунд зарцуулах гэж байгаа юм. Ямар бодлого шинэчлэл хийх гэж байгаа юм. Энэ салбар хоорондын уялдаа дахиад цаашаагаар энэ хяналтын сонсгол хийсний дараагаар сайжрах юм уу гээд олон асуудлуудыг бид нар үр дүнтэй өөрсдөө бодитоор хийх шаардлагатай. Тэгэхээс биш нэг хурал цуглаан, нэг хяналтын сонсгол хийгээд л ингээд асуудал бахь байдгаараа байх юм бол энэ ямар ч нэмэргүй ээ. Жишээлбэл өчигдөр Үндэсний өгөх өдөр 11 сарын 1-нд тохиож Цахим хөгжил, харилцаа холбооны яам И-монголиатай хамтраад энэ сурагчдын амралт эхэлж байгаатай холбогдуулан и-кидс аппликэйшнийг эцэг, эхчүүдийн хүртээл болгох ажлыг уриалсан байгаа. Жишээлбэл ийм сайн технологийн шийдлийг Монгол Улсын Засгийн газар хийчхээд байхад энэ ажлыг эцэг, эхчүүд, олон нийт бол төдийлөн сайн мэдээгүй байна. Тийм учраас бидний ажил юунаас эхлэх вэ гэхээр ядаж л эцэг, эхчүүд өөрсдийнхөө хүүхдүүдийг и-монголиад бүртгүүлээд, түүнийхээ үндсэн дээр и-кидсийг эцэг эхчүүд татаад, саяын нийгэмд болоод байгаа энэ танихгүй хүмүүстэй нөхөрлөх, бага насны өсвөр насны хүүхдүүдийг уруу татах, ямар нэгэн танихгүй хүнтэй холбогдож машин тэргэнд нь сууж явах, улмаар амь нас хохирох зэрэг асуудлуудаас хамгаалах энэ технологийн шийдлийг бид нар өөрсдөө хэрэгжүүлмээр байна. Тийм учраас энэ сурагчдын амралт тохиож байгаатай холбоотой Боловсролын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, холбогдох салбарын сайд нар үүнийг дагаад аймаг,

орон нутаг, нийслэл, сум, дүүрэг, хороодын Засаг дарга нар, мөн сургуулийн захирал, удирдлагууд эцэг эхчүүдийг энэ и-кидс аппликэйшнийг татаж хүүхдүүдээ хаана явж байгааг харж хянах энэ боломжийг өөрсдөө олгооч ээ. Тэгэхгүй яг хүүхэд хулгайлагдаад юм уу, хүүхдийн амь нас ямар нэгэн байдлаар эрсдэлд ороод ирэхээр сошиал дээр нийгмээрээ шуугьдаг, яг өөрсдөд нь хамгаалах энэ боломжийг нь өгөхөөр энэ асуудалд хойрго ханддаг ийм асуудал байна.

Үүнээс гадна ирэх оны төсөв нэмсэнтэй холбоотойгоор орон нутагт байгаа хамтарсан багуудад хуваарилагдах мөнгийг яг дорвитой, бодитойгоор нэмэхгүй бол хүүхэд хамгааллын ажил бас тэр чигтээ хэвээрээ үргэлжилнэ гэдгийг бол мэдэж байна. Тийм учраас орон нутагт хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллаж байгаа хамтарсан багт яг хэдэн төгрөг төсвийг хуваарилах гэж байгаа юм бэ гэдгээ бас энэ салбарын удирдлагууд бол тодорхой болгох шаардлагатай гэж үзэж байна.

Дахиад нэг зүйл хэлэхэд Эрүүл мэндийн яам хүүхэд хамгааллын бодлогоо яаралтай гаргахгүй бол энэ өсвөр насны охидын абортод орж байгаа, өсвөр насны хүүхдүүдийн бэлгийн хүчирхийлэлд өртөж байгаа асуудлыг бид нар бас цааш нь үнэхээр хумьж чадахгүй гэдгийг бас анхааруулж хэлье. Тэгээд ер нь эцэст нь дүгнээд хэлэхэд Улсын Их Хурлаас ажлын хэсэг гарлаа, шалгалаа, холбогдох хуулиудад шаардлагатай зүйл заалтыг орууллаа. Одоо ч гэсэн Гэр бүлийн тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль батлагдах гээд хэлэлцэгдээд явж байна. Хамгийн гол нь хэрэгжилт шүү. Тэгээд энэ төсөв батлагдсаны дараа Засгийн газар холбогдох салбарынхан бодитой ажил хийж, шинэчлэлт, өөрчлөлт хийхгүй бид хүүхдээ хамгаалах асуудал төдийлөн бодитой үр дүнд хүрэхгүй байгаа гэдгийг сануулж хэлье. Баярлалаа.



**Л.Мөнхбаатар:** Баярсайхан гишүүн үг хэлчихлээ. Одоо Улсын Их Хурлын гишүүн, Монгол ардын намын бүлгийн дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэг үг хэлье.

**М.Оюунчимэг:** Хүүхдийн эрхийг хангахтай холбоотой нээлттэй сонсгол бол бас ажил хэрэгч, үр дүнтэй болсон. Одоо бас бид нар хүүхэд хамгаалахтай холбоотой цогц хууль орж ирж байгаа. Мэдээж бид нар бие биетэйгээ танин мэдэхүйн чанартай мэдээлэл солилцох юм уу, ярилцах зүйл маш их ингээд л цаг аваад яваад байдаг. Харин бодит амьдрал дээр хэрэгжилт тал дээрээ хангалтгүй зүйлүүд байгаад байгаа юм. Бид хүүхэд хамгаалахын тулд энэ арга хэмжээг цогцоор нь авах, наад зах нь аюулгүй орчин бүрдүүлэхийн тулд камержуулалтын асуудлыг цогцоор нь шийдэх хэрэгтэй. Яг энэ цагдаагийн хамгаалах юун дээр бүх юуг камержуулна, төсвийн тэдэн хувь нь камерт зарцуулагдана гэсэн хэр нь энэ заалт огт хэрэгжихгүй байгааг цагдаагийн байгууллагынхан нээлттэй сонсголын үеэр хэлж байсан. Бид ч гэсэн улсын төсөв дээр энэ камержуулалтын асуудлыг ялангуяа сургууль, цэцэрлэгүүдийн орчин тойронд төр өөрөө тэр камержуулалтын асуудлыг бүрэн шийдээд өгчихвөл энэ өөрөө аюулгүй орчин. Гэтэл энэ асуудал шийдэгдэхгүй байгаагийн нэг жишээ сая тэр Сонгинохайрхан дүүрэг дээр 14 настай охин яг тэнд зогсож байсан, машинд суугаад явсан. Тэгээд л камер байхгүй. Хувийн дэлгүүрийн нэг жижигхэн камераар харагдсан. Тэр хавь өөрөө маш их хөл хөдөлгөөнтэй хэр нь камерууд нь байхгүй. Эвдэрчихсэн ганц камер ажиллахгүй байгаа. Тэгээд яагаад та нар энийгээ засахгүй байна гэхээр төсөвт хөрөнгө мөнгө суухгүй байгаад байгаа гээд ярьж байгаа. Гэтэл энийг маш сайнаар шийдэх бололцоо байгааг манай Чингэлтэй дүүрэгт ногоон бүс гээд бид камержуулалтыг 50 хувийг нь шийдсэн. Энд жишээ нь хулгай, гэмт хэрэг 40 орчим хувиар буурсан. Энийг

цагдаагийн байгууллагынхан хэлж байгаа. Яг энэнтэй адилхан бид одоо төсөв хэлэлцэж байгаа үед энэ камержуулалттай холбоотой асуудлыг шийдээд, ямар ч байсан ингээд урагшаа явмаар байна. Тэгэхгүй бол яриад л байдаг, хийгээд л ингээд л хууль дүрэм гаргаад байдаг. Гэтэл нэг талаасаа хуулиа хэрэгжүүлэх нөгөө талаасаа хэрэгжүүлэх санхүүжилтийг нь уяж өгөх тэр тогтолцоогоо маш тодорхой болгох асуудлууд чухал байна л даа.

Би Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга байхдаа тэр НҮБ-ын хүүхдийн сантай хамтраад судалгаа хийлгэхэд манай хүүхэд хамгааллын тогтолцооны гажуудал нь юундаа байна гэдгийг маш тодорхой гаргаж өгсөн. Тэгээд энэ дээр үндэслээд 300 сая төгрөгийн төсөвтэй байсан хүүхэд хамгааллын төсвийг 2017 оноос хойш бид ингээд нэмсээр байгаад өнөөдөр 8 тэрбумд хүргэсэн. Гэхдээ хүүхэд хамгаалал цогцоор авч үзье гэвэл 11 тэрбум шаардлагатай гэсэн. Одоо энэ төсөв дээр 14 тэрбум орж ирж байгаа. Гэхдээ энэ мөнгийг юунд, яаж зарцуулах вэ, юунд нь хүүхэд хамгаалалд нь хоол хүнсэнд нь байх вэ, камержуулалт хэд байх вэ гээд, хүний нөөц бэлтгэх дээр хэд байх вэ гээд энийгээ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам маш тодорхой болгох шаардлагатай байгаад байна. Тэгэхгүй бол мөнгийг нь нэмээд байдаг үр дүн гарахгүй, хүүхдэд хамгаалалттай тэр хүүхэд аюулгүй орчинд өсөх энэ нь зөрчигдөөд байгаа тоо нь өсөөд байдаг. Тийм учраас бид нар энэ уялдаа холбоог нь хангах, ялангуяа улсын төсөв хэлэлцэж байгаа үед хүүхэд хамгааллын хууль гарах гэж байна. Гэр бүлийн тухай хууль гарах гэж байна. Эд нарыг яг уяад энэ шалтгаан, шалтгаан дээр үндэслэсэн санхүүжилт, хүний нөөц, тэгээд энийг ил тод байлгах юмнуудыгаа маш тодорхой тусгаж өгөхгүй бол ингээд л чиглэл өгч байна, үүрэг болгож байна гээд байдаг. Амьдрал дээр хэрэгжихгүй байгаад байгаа учраас бид нар энэ дээр онцгой

анхаарах шаардлагатай байгаа. Ямар ч байсан хүний нөөцийг нэмж байна. Тэгэхгүй бол хөдөө, орон нутаг ч юм уу, дүүргүүд дээр харахад хүүхэд хамгааллын нийгмийн ажилтан гэхэд бараг 300, 400 төрлийн ажил хийж байгаа. Ямар цагт нь тэр хүн хүүхдээ хамгаалах вэ ямар ч бололцоо байхгүй байгаа. Тийм учраас энэ асуудлуудыг цогцоор нь шийдэж нээлттэй сонсголын үр дүнг хуультайгаа уяж өгөх асуудал бол чухал байгаа гэдэг саналыг хэлмээр байна.

Ялангуяа энэ санхүүжилтийг ил тод болгох, үүнээс гадна бид аюулгүй орчныг нь бүрдүүлэх, нөгөө талаасаа хоол хүнсэн дээр нь хүртэл анхаарах, үүнийг төсөв хөрөнгөтэй нь уяж өгөх асуудлуудыг би бол бас их онцолж саналаа хэлж байгаа. Хуульд ч гэсэн энэ зүйлүүдийг тусгана гэж бодож байгаа. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэгийн урилгаар Чингэлтэй дүүргийн 174, 275 дугаар цэцэрлэгийн багш, ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдийн сурган хүмүүжүүлэх их үйлсэд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс өндөр амжилт хүсэн ерөөе.

Одоо Гонгорын Дамдинням гишүүн үг хэлье.

**Г.Дамдинням:** Өнөөдөр бид нар хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаарх Улсын Их Хурлын хяналтын сонсголын тайланг сонсож байна. Харамсалтай нь бид нар Монгол даяар сэтгэл шимирүүлсэн мэдээ сонсож, дуулиан шуугиан болсны дараа л ярьцаалаа л даа. Байнга л ярьж байх ёстой. Байнга анхаарч байх ёстой. Хийж байх ёстой ажил. Тэгээд бодвол энэ Байнгын хорооны тайланг сонсоод санал, дүгнэлтээ гаргаад, дараа нь Улсын Их Хурлын тогтоолын төсөл орж ирэх

байлгүй. Тэгээд хуулиудад оруулах өөрчлөлтүүд орж ирэх байх. Би тэгээд 2 чиглэлээр бас хүсэлт байгаа юм.

1 дүгээрт Хууль зүйн байнгын хорооныхон тэгээд бас энэ хүний эрхийн чиглэлээр ажиллаж байгаа манай энэ гишүүд бас 1 дүгээрт хүүхдүүд өөрсдөө сургууль боловсролынхоо орчинд, сургуулийн өмнөх боловсролын орчинд, сургууль дээрээ өөрийнхөө эрхийг хамгаалуулах талаар, өөрөө ямар эрхтэй талаар мэддэг, мэдээлэл авдаг энэ тогтолцоог бүрдүүлж өгөх, эрх зүйн зохицуулалтыг бид нар тусгаж өгөх хэрэгтэй байгаа шүү. Барууны өндөр хөгжилтэй орнуудад хүүхдүүд өөрөө өөрсдийнхөө эрхийг нэхэж чаддаг. Утасддаг утастай, уулздаг хүнтэй, интернэтээр харилцдаг ийм сувагтай байдаг. Ингэж байж тэр хүмүүсийн тэр бидний ирээдүйн асуудлуудыг бид нар сонсож чаддаг. Бид нар томчууд байхгүй юу. Том хүмүүс бид тэр хүүхдүүдэд юу тулгараад байгааг бүтнээр нь харж чадахгүй байгаа. Өдөр тутмынх нь амьдралд тулгамдаж байгаа энэ бэрхшээлүүдийг давж гарахад шинэ үеийн Монголчууд шинэ ирээдүй гэрэл гэгээтэй, хүүхдийн хүчирхийлэлгүй байх, аюулгүй байх энэ орчныг тэдний саналаар л бид нар хийнэ. Тэгэхийн тулд энэ хүүхдүүдэд бид нар боловсролоор нь дамжуулаад ядаж л биеийнх нь аль хэсэгт хүн хүрч болно, болохгүй, ямар хүн, ямар сэдвээр өөртэй нь ярьж болно, болохгүй, дижитал орчинд яаж харилцах ёстой, үгүй гээд энэ сургалтыг ордог л доо. Шинэ юм биш, дэлхий дахинд бол хэрэгжээд явж байгаа. Энийг бид нар энэ хууль, эрх зүйн орчныхоо хүрээнд боловсролын хуулиуддаа ч юм уу оруулаад явах ёстой. Дан ганц бид нар төсөв хөрөнгө шийдээд энэ асуудлыг шийдэхгүй. Зөв тогтолцоо бүрдүүлэх ёстой.

2 дугаарт саяын Дорноговьд болсон үйл явдал үндсэндээ 2 дахь айхтар олон нийтэд түгсэн харамсалтай үйл явдал болсон. Амбер аллерт гэж

хүүхэд алга болоход бүх тухайн орчинд байгаа хүмүүст нэгэн зэрэг нэг шугамаар мэдээлэл өгдөг мэдээллийн тогтолцоо байдаг. Энэ тогтолцоог Монгол Улсад бий болгох эрх зүйн зохицуулалтыг энэ тогтоолдоо тусгаж оруулж ирмээр байна. Хуулийг нь хиймээр байна. Унтарчихсан байгаа утсанд хүртэл шууд асаад л мэдээлэл орж ирдэг байхгүй юу. Тухайн районд, хаана байгаа хүнд нь зориулаад яг тэр хавьд явж байна гэж үзэх юм бол шууд нийт улс даяараа биш яг тухайн хэрэгтэй газрууддаа мэдээллээ түгээгээд, репортоо буцаагаад авчихдаг ийм тогтолцоог бид нар бүрдүүлэх хэрэгтэй байна. Энэ тухай бид нар энэ тогтоол, хууль, эрх зүйн орчиндоо тусгамаар байна.

3 дугаарт энэ гэр бүлийн хуультай холбоотой асуудлыг бас зайлигүй ярих ёстой болчхоод байгаа юм. Бид нар томчууд өөрсдөө л томчуудын хооронд байдаг асуудлаас болж энэ хүүхдүүдийг асар ихээр хохироож байгаа. Хараа хяналтгүй болгож байгаа. Амьдрах орчныг нь хүндрүүлж байгаа. Аав ээж 2 муудалцлаа, саллаа. Амьдрал мэдээж баян. Асуудал үүслээ. Хүүхэд л хохирдог гэж бүгдээрээ ярьдаг. Тэгэхээр энэ гэр бүлийн хууль дээр хүүхдийг харгалзаж үлдэж байгаа, авч үлдэж байгаа энэ хүмүүсийг шүүхээр шуурхайгаар шийдээд өмч хөрөнгөтэй холбоотой зөндөө л асуудлууд явдаг юм байна лээ. Олон ч хүнтэй уулзаж байсан. Олон ч асуудлуудыг ярьж байсан. Шүүхийн мэдэгдэл нь гараад ирээд шүүх дээр асуудлаа ярья гээд дуудчихсан байхад эцэг нь ч юм уу, эх нь ч юм уу хаяг нь тодорхойгүй гээд 2, 3 жил алга болчихсон л байдаг байгаа байхгүй юу. Тэгээд хаяг тодорхойгүй хүнийг шүүхэд дуудаж ирж чадахгүй байна гээд ингээд явж л байдаг. Хүүхэд хохирно энэ хооронд, хүүхдээ харж байгаа хүн хохирно. Тэгэхээр энэ мэт Гэр бүлийн хуулиуд дээр байгаа, Эрүүгийн хууль дээр байгаа, Иргэний хууль дээр байгаа гажгуудыг нэг мөр засаж хүүхэд хохирохгүй байх орчныг бүрдүүлэх

талаар дараагийн энэ сонсголтой холбоотойгоор орж ирэх тогтоолын төслүүд хууль, эрх зүйн орчнууддаа өөрчлөлт хийж оруулж ирээрэй гэж хүсье. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Гонгорын Дамдинням гишүүн үг хэллээ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Чуулганы нэгдсэн хуралдаанаар “Хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаарх” Улсын Их Хурлын хяналтын сонсголын тайланг сонссон талаарх санал, дүгнэлттэй танилцлаа.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье ээ. Гишүүдэд баярлалаа.

16.46 цаг.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС  
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ